



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр, Мягмар гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-12
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	13-78
<hr/>		
1.	<i>“Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар явуулсан Улсын Их Хурлын хяналтын сонголт”-ын тайлан</i>	14-33
2.	<i>Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	33-65
3.	<i>Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Инновац, цахим бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/</i>	65-75
4.	<i>“Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</i>	75-76
5.	<i>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</i>	76-78

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны 10 дугаар сарын 31-ний өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 26 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Тасалсан: Б.Дэлгэрсайхан, Ш.Раднаасэд.

Нэг. “Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар явуулсан Улсын Их Хурлын хяналтын сонсгол”-ын тайлан

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны асуудал хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

“Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар явуулсан Улсын Их Хурлын хяналтын сонсгол”-ын тайланг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Д.Ганбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Ц.Сандаг-Очир, Н.Учрал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Д.Ганбат, Ц.Мөнх-Оргил, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

“Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар явуулсан Улсын Их Хурлын хяналтын сонсгол”-ын тайлан болон Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Улсын Их Хурлын гишүүд “Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар явуулсан Улсын Их Хурлын хяналтын сонсгол”-ын тайланг сонсов.

Уг асуудлыг 10 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дэд дарга бөгөөд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга Х.Ариунболд, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хууль, тогтоомжийн хэлтсийн дарга Э.Бадамсамбуу, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Т.Нарантунгалаг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Тээврийн цагдаагийн албаны Мөрдөн шалгах хэлтсийн дарга В.Хосбаяр, Тээврийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн дарга Ц.Чинзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны асуудал хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй
саналын томъёолол:

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Д.Ганбат нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.10 дугаар зүйлийн 10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн энэ хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 12.3 дугаар зүйлийн 2.1, 3.2 дахь заалт, 13.1 дүгээр зүйлийн 2.1-д заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхэлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир санал хэлж, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ нар тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “2,” гэснийг хасаж, “22 дугаар бүлэгт” гэснийг “22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 4

Бүгд: 15

73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын тавьсан асуултад Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс болон ажлын хэсгээс зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 3.Ажлын хэсгээс гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3.8, 3.9 дэх заалтыг хасаж, 5 дахь хэсэг, Тайлбарын “арван дөрвөн насанд хүрээгүй хүний” гэснийг “бага насны хүүхдийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 5
Бүгд: 15
52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгээс гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 11
Бүгд: 15
26.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

5.Ажлын хэсгээс гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 27.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хэрэгслийн жолооч” гэснийг “хэрэгслийг жолоодох эрхээ хасуулсан хүн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 6
Бүгд: 15
60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 27.10 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Энэ” гэсний дараа “зүйлийн 3 дахь хэсэгт заасан” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай дараах Тайлбар нэмэх:

“Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй хүн” гэдэгт тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх аваагүй, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан, тээврийн хэрэгсэл жолоодох эрхтэй боловч тухайн ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй хүнийг ойлгоно.

“Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн” гэдэгт согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн үйлдлийн улмаас тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүнийг ойлгоно.

“Тээврийн хэрэгсэл” гэж механикжсан тээврийн хэрэгслийг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн нар хариулж, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14

64.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн тавьсан асуултад Тээврийн цагдаагийн албаны Мөрдөн шалгах хэлтсийн дарга В.Хосбаяр хариулж, тайлбар хийв.

-Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хорин” гэснийг “хорин таван” гэж гэснийг, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “хорин тав” гэснийг “гучин” гэж,” гэснийг “10.1 дүгээр зүйлийн Тайлбарын “арван дөрвөн” гэснийг “арван зургаан” гэж” гэснийг, “12.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 2.1 дэх заалтын “арван дөрвөөс” гэснийг “арван зургаагаас” гэж, мөн зүйлийн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14

50.0 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14

50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшиний “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшиний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13

61.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хорин” гэснийг “хорин таван” гэж гэснийг, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “хорин тав” гэснийг “гучин” гэж,” гэснийг “10.1 дүгээр зүйлийн Тайлбарын “арван дөрвөн” гэснийг “арван зургаан” гэж” гэснийг, “12.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 2.1 дэх заалтын “арван дөрвөөс” гэснийг “арван зургаагаас” гэж, мөн зүйлийн” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 5, 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 5, 6 дугаар зүйлийг зүйл тус бүрээр хэлэлцэж дуусав.

Хоёр.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол:

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, Тээврийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн дарга Ц.Чинзориг нар хариулж, тайлбар хийв.

-Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг дээр Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Зөрчлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх үндэслэл нь энэ хуулийн 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 5.7, 5.8, 5.10, 5.11, 5.12, 5.13, 5.14, 5.15, 5.18, 5.20, 6.4, 6.5, 6.6, 6.7, 6.8, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.17, 6.18, 6.20, 6.22, 6.23, 6.26, 6.27 дугаар зүйл, Долдугаар бүлэг, 8.1, 8.6, 8.7, 8.8, 8.9, 9.7, 10.3, 10.7, 10.15, 10.25 дугаар зүйл, Арван нэгдүгээр бүлэг, 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6, 12.8, 12.9, 12.10, 12.11, 13.1, 13.2, 13.4, 13.5, 13.6, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.8, 14.9, 14.10, 14.11, 14.12, 14.13 дугаар зүйл, Арван тав, Арван зургадугаар бүлэг, 17.1 дүгээр зүйлд тус тус заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2, 3, 4 дүгээр зүйлийг зүйл тус бүрээр хэлэлцэж дуусав.

-Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Д.Цогтбаатар: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг өөрчлөн найруулж 3 дугаар зүйл болгон шилжүүлэх.

“3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.Жолооч:

3.1.согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

3.2.тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

3.3.согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 6 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан найруулгын саналаар санал хураалт явуулав.

Нэг.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх найруулгын санал:

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “3.5, 3.6 дугаар” гэснийг “3.5 дугаар” гэж өөрчилж, мөн зүйлд “4/3.6 дугаар зүйл:” гэж нэмж, Төслийн 3 дугаар зүйлийн “1.2, 1.3, 1.4 дэх заалтын дугаарыг “1.3, 1.4, 1.5” гэж,” гэснийг “1.2. 1.3 дахь заалтын дугаарыг “1.3. 1.4” гэж өөрчилж, мөн зүйлийн “3.5-3.8 дугаар зүйлийн дугаарыг “3.7-3.10” гэж” гэснийг “14.7 дугаар” гэснийг өмнө нь шилжүүлж, төслийн 4 дүгээр зүйлийн ““ , 14.7 дугаар зүйлийн 5 дахь” гэснийг “хэсэг, 14.7 дугаар зүйлийн 5 дахь” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх найруулгын санал:

Д.Цогтбаатар: 1.Ажлын хэсгийн гарсан, Төслийн 1 дүгээр зүйлийн “агуулга бүхий зүйл, хэсэг” гэснийг “агуулгатай дараах зүйл, хэсэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2 дахь хэсгийг нэгтгээд өөрчлөн найруулах санал гаргав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Ц.Мөнх-Оргил, Д.Ганбат нар үг хэлж, Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир гаргасан зарчмын зөрүүтэй саналаа татаж авав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

-Төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Инновац, цахим бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх Б.Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Ж.Амгалан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны асуудал хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан, Инновац, цахим бодлогын байнгын хорооны асуудал хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Ц.Мөнх-Оргил, Б.Энхбаяр, Б.Энх-Амгалан, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар санал гаргав.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулах гэсэн саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 12 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. *“Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хууль зүйн байнгын хорооны асуудал хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

“Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Тав. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хууль зүйн байнгын хорооны асуудал хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт П.Хулан нар байлцав.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно.

Д.Цогтбаатар: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 4
Бүгд: 13
69.2 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 32 минут үргэлжилж, 19 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 89.5 хувийн ирцтэйгээр 12 цаг 58 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Жанжисин Д.Сүхбаатар”
танхим
09 цаг 26 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Гишүүддээ
өглөөний мэндийг дэвшүүлье.

Хууль зүйн байнгын хорооны 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаа эхэлье.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны энэ өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн ирсэн, Ганибалын Амартүвшин гишүүн ирсэн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн ирсэн, Лхагвын Мөнхбаатар гишүүн ирсэн, Цэндийн Мөнх-Оргил гишүүн ирсэн, Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн ирсэн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн ирсэн, Цэндийн Сандаг-Очир гишүүн ирсэн, Цэдэвийн Сэргэлэн гишүүн ирсэн, Ням-Осорын Учрал гишүүн ирсэн, Батгөмөрийн Энхбаяр гишүүн ирсэн, Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, “Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар явуулсан Улсын Их Хурлын хяналтын сонсгол”-ын тайланг хэлэлцэж сонсоно.

Хоёрдугаарт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл.

Гуравдугаарт, Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

Дөрөвдүгээрт, Байнгын хорооны тогтоолын төсөл.

Тавдугаарт, Байнгын хорооны тогтоолын төслийг бид ярина.

Дөрөвдүгээр асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тухай асуудлыг хэлэлцэх юм.

Тав дахь асуудал. Байнгын хорооны тогтоолын төсөл нь “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх,

санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий бас ажлын хэсгийг байгуулах тухай асуудал яригдах юм.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу?

Саналтай гишүүд байхгүй бол хэлэх хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг. “Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар явуулсан Улсын Их Хурлын хяналтын сонсгол”-ын тайлан

Нэгдүгээр асуудал. “Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар явуулсан Улсын Их Хурлын хяналтын сонсгол”-ыг Ц.Мөнхцэцэг гишүүн танилцуулна.

Ц.Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг нарын 20 гишүүнээс Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хандан “Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудлаар ерөнхий хяналтын сонсгол явуулах санал гаргах тухай” 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 03/77/49 дугаар албан бичиг, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан нарын 17 гишүүнээс “Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүргийн байгууллагад үйл ажиллагаатай танилцах, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн хэрэгжилтийн асуудлаар сонсгол явуулах тухай” 03/77/50 дугаар албан бичгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.4 дэх хэсэгт заасны дагуу Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулах шийдвэр гарсан.

Хууль зүйн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн

хуралдаанаараа дээрх асуудлыг хэлэлцэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хурлын дэгийн тухай хуулийн 118 дугаар зүйлд заасны дагуу сонсголын тов тогтоох, сонсгол зарлагчийг сонгох тухай Байнгын хорооны 11 дүгээр тогтоолыг баталж, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Цэрэнжамцын Мөнхцэцэгийг томилсон.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хурлын дэгийн тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.2 дахь хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.4 дэх хэсэгт заасны дагуу хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар хяналтын сонсголыг зохион байгуулах тов мэдээллийг 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс 23-ны өдрийн 17.00 цаг хүртэл олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлж сонсголд оролцогчдыг бүртгэсэн.

Сонсголыг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д заасны дагуу Хууль зүйн байнгын хорооны 19 гишүүнээс Ш.Адъяаа, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Н.Учрал, Б.Энхбаяр, Ж.Сүхбаатар, Ш.Раднаасэд нарын 7

гишүүн хүрэлцэн ирснээр сонсголыг хүчинтэйд тооцож хяналтын сонсгол эхэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы ны хуралдааны дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйл, Нийтийн сонсголын тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаар сонсгол зохион байгуулах болон үндэслэл, зорилго, оролцогчдын ирц, сонсголын дэг, дараалал, сонсголд оролцогчдын эрх, үүргийг сонсгол даргалагч Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Ц.Мөнхцэцэг танилцууллаа.

Сонсголд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Соёлын яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хүний эрхийн анх Үндэсний хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн ерөнхий газар зэрэг төрийн байгууллага.

Мөн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын болон Монгол Ардын намын бүлэг зэрэг улс төрийн намын төлөөлөл, “Хүний эрх дэвшилт бодлын хүрээлэн” төрийн бус байгууллага, “Иргэн та ХҮЧ” залуусын санаачилга, Монгол Улсын Их Сургууль, Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны хүрээлэн, “Алтан гэрэгэ” хуулийн фирм, “Монголын Хүүхдийн эрхийн үндэсний төв” төрийн бус байгууллага, “Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээ” төрийн бус байгууллага, Монголын идэрчүүдийн төв холбоо, “Гижигтэй Инээд” төрийн бус байгууллага, Хүүхдийн хөгжил, мэдээллийн “Учрал төв”, Залуусын давлагаа клуб, “Буяа энд Партнерс” компани, Олон улсын “Улаанбаатар” их сургууль, “Өнөр бүл” хүүхдийн төв,

“Хөөрхөн зүрх” төрийн бус байгууллага, “Бүх нийтийн боловсролын төлөө Иргэний нийгмийн үндэсний эвсэл” төрийн бус байгууллага, Хүний эрхийн судалгааны “Чандмань сэтгэл төв”, Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдүүдийг нөхөн сэргээх төв, “Үжин” төв, Боловсролын судалгааны арга зүйн төв, Багануур дүүргийн Ардчилсан эмэгтэйчүүдийн холбоо, Нийслэлийн Ардчилсан эмэгтэйчүүдийн холбоо, “Граф Нэтворк” /Graph.mn сайт/ компани, иргэдийн төлөөлөл зэрэг нийт 90 гаруй оролцогч оролцсон болно.

Сонсголын ажиглагчаар хуульч С.Мөнхнаран, хуульч П.Баттулга, “Бүх нийтийн боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн төлөөлөл Б.Батчимэг, “Охидын түүх” төрийн бус байгууллагын төлөөлөл Б.Сайнзаяа, Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагын төлөөлөл Э.Амарбаясгалан, Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагын Хүүхэд хамгаалал, оролцоо хариуцсан мэргэжилтэн О.Дариймаа, иргэн Ц.Түвдэндорж, Б.Уянга, Ц.Уянга, С.Нандинболор, М.Ивээл нар оролцлоо.

1.Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллүүдээс хийсэн илтгэл мэдээлэл:

Төрийн байгууллагаас Монгол Улс дахь хүүхэд хамгааллын тогтолцоо, тулгамдсан асуудал сэдвээр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дүгнэлтийг Комиссын гишүүн Х.Мөнхзул,

Хүүхдийн эрхийн тулгамдсан асуудал шийдэх сэдвээр Отгонтэнгэр Их Сургуулийн багш Р.Очирбал,

Монгол Улс дахь Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт сэдвээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хүний эрхийг хангах улсын хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Б.Болорсайхан,

Төрийн бус байгууллагаас Хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилт, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмж, тулгамдаж байгаа асуудлын талаар Буян энд Партнерс компанийн хуульч, өмгөөлөгч Б.Буянжаргал,

Хүүхэд хамгааллын тухай хуулийн төсөлд өгсөн санал, дүгнэлтийн талаар Хүний эрх дэвшилтэт бодлогын хүрээлэн төрийн бус байгууллагын захирал Х.Баасанжаргал нар тус тус танилцууллаа.

2.Танилцуулга мэдээлэлтэй холбогдуулан тавьсан Улсын Их Хурлын гишүүдийн асуулт:

Хүүхдийн эрхийг хамгаалах хангахтай холбоотой асуудлаар хийсэн илтгэл, мэдээлэлтэй холбогдуулан

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Нэг талаас хууль тогтоомжийн хэрэгжилтийг, нөгөө талаас хүүхдийн эрхийг хамгаалах, хангахад нөлөөлж буй суурь шалтгаан нь юу вэ гэдгийг харах ёстой. Гэхдээ Хүний эрхийн Үндэсний Комиссын мэдээлэл энэ талаар хангалтгүй байсан. Хүүхдийн эрхтэй холбоотой асуудлаар дагнасан зөвлөмж гаргаж байх санал хэлсэн.

Мөн одоо байгаа хамтарсан багийн ачаалал маш их байхад үр дүн гарах уу. Энд хамтарсан сан багийг төрийн бус байгууллагуудаар бэхжүүлж,

мэргэшүүлээд, төрөөс тэдэнд дэмжлэг, туслалцааг нь үзүүлж гэрээ байгуулах боломжийн талаар.

Мөн Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүүхдийн эрхийн конвенцоос хүүхдийн эрх зөрчигдөөд байгаа үндсэн суурь шалтгаанаа тогтоох шаардлагатай.

Энэ талаарх санал олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, сошиалын асуудал, хүүхдийн хүмүүжилд хэрхэн нөлөөлөх тухай.

Түүнчлэн хүүхдийн хоолны асуудал ирээдүйн суурь өвчний үндэс болох учраас энэ асуудлыг шийдвэрлээгүй нөхцөлд хүүхдийн боловсрол, эрүүл мэндийн асуудлыг ярих нь үр дүнгүй болох учраас хүүхдийн хоол, хүүхдийн эцэг, эхийн хариуцлагын асуудлыг давхар шийдүүлэх талаар үг хэлсэн.

Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа цагдаагийн байгууллага, хүүхэд, гэр бүлийн сошиал нөлөөллийн аяныг цаг үетэйгээ их тохируулж ажиллаж байгааг сайшааж Нэгдсэн Үндэстний Байгууллагаас манай улсын хүүхэд хамгааллын тогтолцооны зураглалаар яг юу нь болохгүй байгааг тодорхойлж өгсөн.

Энд зааж өгсөн хүүхдийн эрхийн улсын байцаагч төрийн албан хаагч байх нь буруу.

Мөн хүрэлцэхгүй байгаа бүтэц, орон тоонд мэргэжилтэн бэлтгэгдэж ажиллах нь хугацаа алдах учраас төр зарим ч бичиг үүргээ төрийн бус байгууллагад хариуцуулах нь илүү үр дүнтэй талаар.

Хүүхдийн тэтгэмжийн асуудал мөн хүүхдийн эрх зөрчигдөх, гэр бүлийн хүчирхийллийн асуудлын нэг болж байгаа тухай.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын эмэгтэй гишүүдтэй хамтран Хүүхэд хамгааллын төсөв дээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сантай хамтран судалгаа хийлгэснээр Монголд хүүхэд хамгааллыг бодитой хийхэд шаардлагатай санхүүжилтийн хэмжээг гаргаж, энэ чиглэлээр санаачилга гарган он оны төсөв дээр шийдвэрлүүлэн ажилласнаар өнөөдөр хүүхэд хамгааллын төсөв тодорхой хэмжээнд хангалттай байгаа боловч анхан шатанд хүний нөөц нэмэгдэж, үр дүн гарахгүй байгаа.

Мөн нийгмийн ажилтны хүүхэд хамгаалах чиг үүргийг гүйцэтгүүлэхгүй, орон тоог нэмэхгүй байгаа, төрийн албан хаагчдад хариуцлага тооцдог болох тухай, нийгмийн ажилтны орон тоо, цалин бага байгаа нь мэргэших, тогтвор суурьшилтай ажиллах боломжгүй байгааг.

Мөн камержуулалтын асуудал маш чухал. Энэ тал дээр авах арга хэмжээний талаар.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа өмнөх сонсголуудаас гаргасан шийдвэрүүдийн тайлан, үр дүнг ярих шаардлагатай.

Мөн өмнөх сонсголын дараа төрийн бус байгууллагын төлөөллүүдтэй уулзаж, хүүхэд рүү чиглэсэн үйл ажиллагааг хэрхэн үр дүнд хүргэх, төрийн энэ үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх талаар хүсэлт тавьж ярилцсан ч энэ талаарх үр дүн өнөөдрийг хүртэл гараагүй байгаа.

Мөн өсвөр үеийнхний эмнэлгийн тусламж, үйлчилгээг сайжруулах, холбогдох дүн шинжилгээг тогтмол хийж, хэрэгжилтийг хангах тухайд.

Мөн хүүхэд хүчирхийлэл, хүүхэд хамгааллын чиглэлээр нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэх, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх хүүхэд хамгааллын зөрчил болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд мэдээлэл түгээх, сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулахад төрийн бус байгууллагуудын оролцоог дэмжих.

Сайн дурын хөтөлбөрийг үр дүнтэй болгох, холбогдох яамд нөлөөллийн ажлыг хийх гэсэн үүрэг өгч байсан. Энэ талаар холбогдох яамд хэрхэн үр дүнтэй ажилласан талаар.

Мөн радио, телевиз, хэвлэл мэдээллээ ашиглаж, сошиал орчин дахь нийгмийн сэтгэл зүйг эрсдэлтэй байдал руу дагуулаад байгаа асуудлаар хэрхэн ажиллаж, энэ талаарх хөрөнгө оруулалтаа сайжруулах, хүчирхийлэлд өртсөн, хүчирхийлүүлсэн хүүхдийн сэтгэл зүйд нөлөөлөх олон давталттай байцаалт, орчин зэрэг нь хүүхдийг улам сэтгэл зүйн дарамтад оруулж байгаа асуудалд ямар шинэчлэл хийсэн зэрэг асуудлаар.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан бид өмнө зохион байгуулсан хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн үндэсний чуулганаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүүхдийн эрхийн конвенцод хүлээсэн үүрэг болох хүүхдийн язгуур эрх ашгийг дээдлэх.

Мөн Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсгийг биелүүлэхээр Хүүхдийн

төлөө үндэсний зөвлөлийн гишүүд амалсан.

Энэ зөвлөлийн гишүүд болох сайд нар, Төрийн нарийн бичгийн дарга нар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд залуучуудын газар арга зүйгээр нь хангаж Хөдөлмөрийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэхэд санаачилгатай ажиллахыг.

Мөн хүүхдийн хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлэх үед мэдээлэл, контентыг хориглох тухай санамж бичгийн хүрээнд төрөөс тусгай зөвшөөрөл авч байгаа телевизүүдийг цэгцлэх ажлыг үнэхээр шуурхайлах, хүүхдийг хэл соёлын хувьд, эрүүл мэндийн хувьд хамгаалах бодлогыг холбогдох яаманд боловсруулахыг, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа нэрээр төсвийн мөнгийг зарцуулж байгаа асуудалд анхаарах.

Төрийн бус байгууллагуудыг тогтвортой чадваржуулан ажиллуулах тал дээр холбогдох байгууллагууд хэрхэн ажиллаж байгаа тухайд.

Хүүхдийн эрхийг хамгаалах, хангах асуудлаар ажиллаж байгаа улсын байцаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангалтгүй, ажлын байрны дарамт, шахалт, ёс зүйн асуудлыг анхаарах талаар.

Улсын Их Хурлын гишүүн, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин Хүүхэд хамгааллын асуудалд бид маш явцуу хандаж байгаа тухай.

Энэ асуудалд хүүхдийн хоолны шим тэжээл, хүүхдийн хоолны асуудал ихэнх цагаа өнгөрөөж байгаа хүүхдийн цэцэрлэг, сургууль дахь агаарын орчны бохирдлын асуудал, хүүхдийн эрүүл мэндийн асуудал, Монгол Улс эмчилж

чадахгүй байгаа хүүхдүүдийн эцэг, эхийг хэрхэн дэмжиж нэг ч гэсэн монгол хүний эрүүл болох талаарх асуудал.

Мөн хүүхдийн сэтгэл зүй эрүүл байна уу гэсэн асуудлыг авч үзэх.

Эдгээр асуудлыг яамд тус тусдаа биш нэгдэж олон талаас нь хандах.

Мөн энд оролцож байгаа төрийн бус байгууллагууд иргэдийн санал, тэдний гарц, шийдлийг түлхүү сонсох боломж олгох талаар тус тус асуулт асууж санал хэлсэн.

Улсын Их Хурлын гишүүдийн асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Соёлын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны хүрээлэн зэрэг байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтнуудад хариулт өглөө.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хурлын дэгийн тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.1.4-д заасны дагуу хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа уламжлалт хүмүүжлийн арга эцэг, эхчүүдийн болон сурган хүмүүжүүлэгчдийн үүрэг, хариуцлагын талаар ямар шийдэл гаргах ёстой.

Мөн сургууль, гэр бүлийн орчинд цахим хэрэглээ, ухаалаг гар утасны асуудлыг хууль зүйн хүрээнд хэрхэн шийдэх талаар бас үг хэлсэн болно.

Мөн сонсголд оролцогчдоос төрийн бус байгууллагууд болон иргэд, ялангуяа ахмадууд, хүүхэд үйл ажиллагаанд дэмжин оролцох бүрэн боломжтой.

Төрөөс эрх зүйн орчин болон эдийн засгийн дэмжлэг үзүүлэх тал дээр анхаарах, хохирогч хүүхдийн асуудлыг хууль хяналтын байгууллагуудад шалгахдаа хүйсийн мэдрэмжтэй хандах, хамтарсан багт ажиллах төлөөллийн эрх зүйн зохицуулалтыг нээж өгөх, хүүхдийг хүн байх боломжийг бүрдүүлэх, хүүхдэд мэдээлэл, мэдлэг олгох асуудалд анхаарах нь хамгийн үр дүнтэй хамгаалал болох болоход анхаарах.

Хүүхдийн асрах төвд дарамт болж байгаа жил бүр сурах бичиг өөрчилж санхүүгийн дамжин авчруулж байгаа зэрэг асуудлыг шийдвэрлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг чанаржуулах, нийгмийн ажилтанд тавигдах шаардлагыг бууруулж, хүрэлцэхгүй байгаа хүний нөөцийг ахмадууд, хүүхдийн төлөө гэх сэтгэлтэй хүмүүсийг ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг асуудлаар санал гаргаж, мөн үг хэлсэн болно.

3.Хяналтын сонсголын хаалт:

Улсын Их Хурлын гишүүн хүний эрхийн дэд хорооны дарга, сонсгол даргалагч Ц.Мөнхцэцэг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгахын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийг үндэслэн сонсголын тайланг Хууль зүйн байнгын хороонд танилцуулж, шаардлагатай бол чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах.

Мөн сонсголын явцад гаргасан саналыг Улсын Их Хурлаар хүүхэд хамгааллын чиглэлээр хэлэлцэх

холбогдох хуулийн төслүүдэд тусган ажиллахаа илэрхийлж сонсголыг хаасан.

4.Хяналтын сонсголын нэгдсэн санал, дүгнэлт:

Монгол Улс хүүхэд хамгааллын хүрээнд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн тусламжийн утас, хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хүүхдийн эрхийн улсын байцаагч, нийгмийн ажилтан зэрэг тусгайлсан бүтэц байгуулан хүүхэд хамгааллын цогцоог бэхжүүлэн эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа ч бүрэн дүүрэн хэрэгжихгүй, хэрэгжүүлэх явцад тулгарч байгаа асуудал байгууллага хоорондын болон хууль эрх зүйн уялдаа холбоогүй зарим зөрчилтэй зохицуулалтууд байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой хяналтын сонсголд оролцсон Улсын Их Хурлын гишүүд бусад оролцогчдоос гарсан санал, дүгнэлтийг нэгтгэн дараах байдлаар танилцуулж байна. Үүнд:

Нэг.Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахад шаардлагатай мэргэжлийн тогтолцоог бүрдүүлэхэд гарч байгаа хүндрэлтэй асуудлаа судлан тогтоож, шаардлагатай бол хууль, эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт оруулах замаар төрийн бус байгууллагатай хамтран болон гэрээлэн ажиллах арга замыг судлах.

Хоёр.Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахад нөлөөлж буй суурь шалтгааныг тогтоох.

Хүүхдийн бие бялдрын хүмүүжлийн асуудлаас гадна цахим хэрэглээ, оюуны боловсролын асуудалд

нөлөөлөх арга хэмжээг бодлогын түвшинд тогтоож, үүнээс үүдэлтэй эрсдэгчийн асуудал урьдчилан сэргийлэх талаар үе шаттай арга хэмжээ авах.

Гурав.Хүүхдийн эрх зөрчилдөхөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг, мэдээллийг олгох.

Энэ чиглэлээр сургалт, сурталчилгаа, бусад арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай эрх зүйн зохицуулалтын уялдааг хангах, үе шаттай арга хэмжээ авах, боловсронгуй болгох талаар шаардлагатай арга хэмжээг авах.

Дөрөв.Хүүхдийн эрхийг хамгаалах, хангах тухай асуудлыг өргөн хүрээнд авч үзэж, цогц байдлаар шийдвэрлэх нь ирээдүйд бий болох хүн амын нийгмийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийн чанарын асуудал чухал болохыг анхаарах.

Тав.Хүүхэд хамгааллын чиглэлээр зарцуулсан төсвийн зарцуулалт, түүний үр дүнгийн талаар холбогдох байгууллагуудын мэдээллийг сонсох зэрэг болно.

Улсын Их Хурлын гишүүн сонсгол даргалагч Ц.Мөнхцэцэг.

Д.Цогтбаатар: Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар Улсын Их Хурлын хяналтын сонсголын тайлантай холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү?

С.Бямбацогт гишүүнээр тасаллаа.

Б.Энх-Амгалан гишүүнд микрофон өгье.

Б.Энх-Амгалан: Энэ бага насны хүүхдийг алах болон хүчиндэх энэ гэмт хэргийн ялыг чангатгах асуудал дээр

2019 онд гэхэд 4 хүүхэд, 2020 онд 8 хүүхэд 2021, 2022 онд 7 хүүхэд энэ гэмт хэргийн хохирогч болсон байна.

-2019 онд 481 гэмт хэргийн **169**;
-2020 онд 505 гэмт хэргийн **248**;
-2021 онд 439 гэмт хэргийн **278**;
-2022 онд 550 гэмт хэргийн **362**-т

нь хүүхэд өртөж хохирчээ.

Энэ бол хүчиндэх гэмт хэрэг.

Тэгэхээр энэ гэмт хэрэгтэй холбоотойгоор энэ ялын бодлогыг чангатгах асуудал дээр хуулийн төсөлд ямархуу зүйл орж ирэв? **Нэг.**

Хоёрдугаарт, хүүхдүүдийн үзэж байгаа, сонсож байгаа, тоглож байгаа цахим тоглоомуудыг цэгцлэх бололцоо боломж бид нарт байгаа.

Энэ үзэж байгаа сөрөг контентыг хориглох, кино, телевиз нэвтрүүлгүүдийг хүүхдүүдийн сэтгэхүйд буруугаар нөлөөлөх тийм сөрөг зүйлүүдийг хориглох бололцоо, боломж бид нарт байгаа. Энэ дээр ямар арга хэмжээ авах вэ?

Бид хүүхдүүдийн сурч байгаа орчин, идэж байгаа хоол хүнс, сургалтын чанар, үр нөлөөнд бас анхаарах цаг болсон. Энэ дээр ямар арга хэмжээ авах гэж байна?

Сургуулийн орчин буюу хүүхдүүдийн дунд буруугаар нөлөөлж байгаа тэр хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бэлгийн хүчирхийлэл, буруу үлгэр дуурайлуудыг яаж цэгцэлье гэж бодож байна вэ? Энэ дээр сонсголоос ямар зүйл гарав аа?

Өсөж байгаа гэр бүл, эцэг эх, ах дүү, хамаатан садан нь энэ хүүхдийн

хүмүүжилд онцгой үүрэгтэй оролцох ёстой. Үүнийг Улсын Их Хурлаас гаргасан Хүүхдийн эрх хүүхэд хамгааллын асуудлаар явуулсан сонголт дээр ямар шийд гарав.

Мөн нийгмийн хамгаалал, хүүхдийн цахим халдлагыг хамгаалах, хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаар өмнө нь бас нэг мэдээлэл орж ирээд Их Хурал дээр тэр буцсан.

Хүүхдийн эрхийг хамгаалах, буруу мэдээлэл тараахгүй байх, худал мэдээлэл тараахгүй байх, хүүхдийг цахим халдлагаас хамгаалах энэ асуудлыг цаашид ер нь яах вэ?

Энэ талаар дахиж тэр мэдээлэл, тэр хууль эргэж орж ирэх үү, үгүй юу? Энэ хэдэн асуултад хариулаадхаач.

Д.Цогтбаатар: Ц.Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнхцэцэг гишүүн ээ, энд чинь ер нь оролцох ажлын хэсэг юм байхгүй юу? Та өөрөө л танилцуулаад л хариулаад явах нь байна тийм үү?

Цахимыг Н.Учрал гишүүн хариулна гэж үү? Н.Учрал гишүүнд микрофон өгье.

Н.Учрал: Энэ ерөнхий хяналтын сонголын үеэр яг энэ сөрөг контенттой холбогдуулаад Их Хурлын гишүүд нэлээдгүй олон асуултуудыг асуусан.

Одоо Харилцаа, холбооны Зохицуулах Хороо энэ өргөн нэвтрүүлгийн телевизүүд дээр тавигдах шаардлага батлаад, ингээд энэ шаардлагынхаа дагуу харилцаа холбооны хяналтын улсын ерөнхий байцаагчаар ахлуулсан ажлын хэсэг сөрөг контент дээр шаардлага тавиад явж байгаа.

Мөн дээрээс нь бид олон улсын гэрээ, конвенцод нэгдсэний дагуу **ЮНЕСКО**-гийн хүүхдэд сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээлэл, контенттой холбогдуулж **IWF** [www.iwf.org.uk] /**Internet Watch Foundation**/ дээр ийм репортуудыг авдаг болсон.

Тэгээд одоо яг **ekids.mn** гэдэг ийм сайт ажиллаж байгаа. Үүнийг бид сүүлд **e-mongolia**-д нэгтгэсэн. Тэгээд хүүхдүүд **e-mongolia** руу ордог болсон.

Одоо тэр **IWF**-тэй холбогдуулаад хэрвээ энэ сөрөг контент байна, энэ гэмт хэргийг сурталчилж байна гэж үзэх юм бол шууд тийшээ репорт илгээж байгаа.

Мөн **black-list.mn** гээд нөгөө хар листэд хэрвээ гэмт хэрэгтэй холбогдуулсан, гэмт хэргийг сурталчилсан контентыг агуулсан веб хуудсууд байх юм бол түүнийг нь **black-list** рүү илгээгээд үүнийг нь цагдаагийн байгууллага шууд хэлэлцдэг ийм сувгийг бид гаргаад ажиллуулж байгаа.

Дээрээс нь **e-mongolia** дээр **ekids** буюу нөгөө насанд хүрээгүй хүүхдүүд ордог болсон. **“ДАН систем”**-ээр таниад эцэг, эхийн зөвшөөрлөөр холбогдоод **e-mongol**-д нэвтэрдэг болсонтой холбогдуулаад хүүхдүүд шууд цагдаагийн байгууллага руу хүсэлтээ илгээх боломжийг нь emergency дуудлага маягаар цагдаагийн байгууллагын системтэй холбоод ажиллуулж эхэлсэн.

Тэгэхээр хүүхдүүд онцгой тохиолдолд шууд цагдаагийн байгууллага руу хүсэлтээ илгээхэж байгаа гэсэн үг.

Сая Европын Холбоо **The Digital Services Act (DSA)** гээд бие даасан баримт бичгээ гаргачихлаа. Олон нийтийн сүлжээнд хэрхэн хүний эрхийг

хамгаалах юм, хүүхдийн эрхийг хамгаалах юм, хүүхдэд сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээллээс яаж хамгаалах юм бэ гээд.

Тэгэхээр сая хүүхэд хамгааллын энэ Засгийн газраас барьсан хууль дээр цахим орчинд хүүхэд хамгааллын асуудал орж ирж байгаа юм байна.

Тэгээд ажлын хэсэг дээр гишүүд тодорхой саналуудаа тусгаад явах нь зохимжтой.

Гэхдээ хүүхэд хамгааллын асуудал зөвхөн төрийн байгууллагын үүрэг гэхээсээ мэдээж энэ бол эцэг, эх, багш гээд олон талын хамтын ажиллагааны үр дүнд бий болно.

Төр зөвхөн хууль хяналтын байгууллага руу холбогдох сувгуудыг нь гаргах, хариу арга хэмжээ авах нөхцөл бололцоонуудыг нь бүрдүүлж өгөх нь зохистой гэдэг утгаараа төрийн зүгээс **ekids.mn**-ээр дамжуулаад бүх репортуудаа авч байна. Хууль хяналтын байгууллагууд хүсэлтүүдээ авч байна. Хариу арга хэмжээнүүдээ авч байна.

Дээрээс нь тэр **blacklist**-д бүртгэгдсэн тэр **IP** хаягууд дээр нь хязгаарлалт хийх, хяналт хийх боломжуудыг бүрдүүлж байна.

Бусад олон нийтийн сүлжээ эрхлэгч **Facebook**, **Twitter**, **Instagram** гэсэн холбогдох хаягуудтай **“Ногоон суваг”**-аар дамжуулаад харилцаж байна.

Хүүхдэд сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээллээс хамгаалах асуудлыг бүх олон нийтийн сүлжээний компаниуд өөрсдийнхөө коммунити стандартын дагуу хиймэл оюун ухаан ашиглаад шууд хязгаарлалт хийдэг дэвшлүүдийг гаргаад ирсэн. Харьцангуй хяналтууд сайжирсан.

Монгол хэлтэй ажилтнуудыг хүртэл **Facebook** компани ажилд аваад ажиллуулж байгаа гэдгээ өнгөрсөн долоо хоногт хийсэн уулзалтынхаа үеэр илэрхийлсэн.

Тэгэхээр **Government-Case-Work-Channel** гээд бид **“Ногоон суваг”**-аар дамжуулаад энэ олон нийтийн сүлжээ эрхлэгч байгууллагуудтай харилцаад, хамтраад ажиллаад явж байна.

Д.Цогтбаатар: Н.Учрал гишүүн нэлээн нарийвчилж хариулт өгч байна. Энэ чиглэлээр олон ажил хариуцсан яам хийгээд байгаа.

Тийм учраас энэ дээр манайхан мэдээлэлтэй байж байх нь зөв.

Ер нь Н.Учрал гишүүнд хэлэхэд, ялангуяа хүүхэд хамгаалалттай холбоотой саяын ярьсан зүйлээ товчхон танилцуулга болгоод Байнгын хорооны гишүүдэд өгчихмөөр байна. Энд байхгүй байгаа гишүүд ч гэсэн тэр мэдээллээ авч байх нь зөв байх.

Ц.Мөнхцэцэг гишүүн нэмэлт хариулт өгье. **Ц.Мөнхцэцэг** гишүүний микрофоныг.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр хүүхэд хамгааллын сонсголоос хамгийн чухал яригдсан зүйл бол хүүхдийн эрх гэдгийг бид их өргөн хүрээтэй төрөлжүүлэн авах шаардлагатай байна.

Тэгэхгүй зөвхөн нөгөө хүүхдийн эрхийг гэдгийг хүүхдийн хүчирхийллийн асуудлаар явцууруулан тайлбарлаж, энэ тал дээр хэт их анхаарах нь хүүхэд эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, авьяас чадвараа хөгжүүлэх гээд Хүүхдийн эрхийн конвенцод заасан

бусад эрхүүдийг орхигдуулах, энэ чиглэлээр төрийн бодлого, хамгаалалт, оролцоо дутагдахад хүргэж магадгүй гэсэн саналыг маш олон экспертүүд, хуульчид маань хэлсэн.

Ер нь хүүхдийн эрхийг, хүүхэд хамгааллыг тусдаа авч үзэх шаардлагатай байна.

Тэр хүүхдийн эрхийг ухамсарлах, хүүхдийн эрхийг хамгаалах үйлсэд оролцоо төрийн бус байгууллагууд, эцэг эх, сурган хүмүүжүүлэх байгууллага, бүх төрийн яамдын оролцоог илүү өргөжүүлэх энэ шаардлага их чухал тавигдсан.

Дээрээс нь маш олон төрийн бус байгууллагууд хүүхдийн эрхийг хамгаалах мэргэжилтэн, нийгмийн ажилтанд зөвхөн хуульч байна гэдэг юм уу, эсвэл яг тодорхой мэргэжил заагаад явцууруулахгүйгээр ер нь өргөн хүрээтэй энэ чиглэлээр ажиллаж байсан ахмад багш нар, ахмадууд, хүний эрхийн зүтгэлтнүүд зэргийг гэрээлэн ажиллуулах, зөвхөн төрийн байгууллагуудын оролцоо гэхээс илүү төрийн бус байгууллагуудынхаа оролцоог хамтран нэмэх шаардлагатай гэдгийг онцолсон байгаа.

Тэгээд манай Хууль зүйн байнгын хороон дээр яг одоо хэлэлцэгдэж байгаа Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль болон Эрүүгийн хуулийн тодорхой өөрчлөлтүүд дээр ялын бодлого чангарна. Хүүхдийн эрх зөрчсөн, хүүхдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэрэгт олгох бодлогуудыг чангатгаж байгаа.

Энэ талаар манай ажлын хэсгийн дарга Ц.Сандаг-Очир гишүүн дэлгэрэнгүй хариулт өгөх байх.

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Б.Энх-Амгалан гишүүний асуулт бол өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудлын хоёр дахь асуудал дээр байгаа.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дагалдах хуулийн төслүүдийн хамтаар Засгийн газраас өргөн баригдсан.

Энэ хуулийн төсөл дээр хүүхдийг алах, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялыг хэрхэн яаж чангалж байгаа вэ гэдэг асуудал маш тодорхой яригдана.

Засгийн газраас өргөсөн хуулийн төсөлд бага насны хүүхдийг хүчиндэх, алах, мөн бэлгийн мөлжлөгийн эсрэг энэ гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг дээд зэргээр чангалж байгаа.

Хорих ялын хугацааг нэмэгдүүлж байгаа. Мөн энэ төрлийн гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй байх. Энэ төрлийн гэмт хэрэгт хугацаанаас нь өмнө магадлангаар суллахгүй байх гээд энэ бүх ялын бодлогыг чангалж байгаа асуудал хоёр дахь асуудал дээр дэлгэрэнгүй яригдана гэдгийг Б.Энх-Амгалан гишүүнд хэлчихье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Хариулт хангалттай юу? Тэгвэл Д.Ганбат гишүүнд микрофон өгье.

Д.Ганбат: Баярлалаа. Та бүхнийхээ амар амгаланг айлтгая.

Ингээд хүүхдийн талаар нээлттэй сонсгол явуулсан нь зөв зүйтэй их сайхан зүйл болжээ.

Тэгээд сонсгол явуулаад, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулаад ингэчихээрээ тэгээд бүх зүйл болчхож байгаа, бүтчихэж байгаа гээд ингэж ойлгож болохгүй л байх л даа.

Тэгээд энэ бол зүгээр л арга ядсан л арга юм уу л гэж бодож байна. Би бол. Цаана чинь тэгээд хүүхдүүдийн эрх маш их зөрчигдөж байна л даа. Хүүхдүүдийг зодож байна. Тэгээд болох бүтэхгүй бүх л юм хүүхдүүдэд тохиолдож байна.

Тэгээд ер нь иймэрхүү маягаар яачихад ингээд болж байна, бүтэж байна гэж ойлгож байгаа юм уу? Ямар байгаа юм бэ?

Энэ 7 жил. Одоо 8 дахь жилдээ орж байна. Бараг энэ Улсын Их Хурлын 90 хувийг эзэлж байгаа нэг намынхан.

Тэгээд энэ хугацаанд хийсэн ажил ердөө л энэ үү? Нэг ангид чинь 50, 60 хүүхэд байна. Авлига, ядуурал, энэ бүх зүйлүүд чинь хэр хэмжээнээсээ хэтэрчихсэн байна.

Энэ бүх юм чинь нөлөөлөөд энэ байдал нь зүгээр л хамгийн хамгаалах чадваргүй хүнд хэцүү байгаа хүүхдүүд дээр тусгалаа олж байна л гэж би үзэж байгаа.

Зүгээр энэ сонсгол хийгээд, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулснаар зүгээр л хүмүүсийг бүх юм өөрчлөгдөх нь ээ гэсэн нэг тийм хүлээлтийн байдалд оруулаад, сэтгэл санааг нь амраагаад ийм байдалтай болгочихгүй юу. Энэ талаар Та бүхэн ярилцана уу? Судалгаа байгаа юу?

Тэгээд ер нь хэчнээн их мөнгө төгрөг зарцуулдаг юм? Ямар байдаг юм? Энэ нь хангалттай байдаг юм уу, үгүй байдаг юм уу?

Ер нь тэгээд Засгийн газар, энэ холбогдох албан тушаалтнууд чинь энэ хугацаанд хэр ажилласан байдаг юм? Ер нь хариуцлага хүлээж байгаа ямар хүмүүс байна? Яаж хариуцлага хүлээлгэв? Яаж энэ байдал дээрдэв? Эсвэл жилээс жилд цаашаа дордохоор байна уу гэсэн ийм дүгнэлтүүд байна уу?

Зүгээр нэг “**нүглийн нүдийг гурилаар хуурав**” гэдэгтэй адилхнаар иймэрхүү маягаар өнгөрөөгөөд байвал асуудалд тустай биш ээ. Улам ужгирч, гүнзгийрч, хүмүүсийг тайван байдалд оруулж, асуудлыг шийдчихсэн мэт байдалд оруулах зүйл байна уу, байхгүй юу?

Эсвэл асуудлыг үндсээр нь шийдээд юм сайжирчихаар байна уу?

Үгүй ядаж нөгөө “**Бамбарууш**” кафе маань ашиглалтад орсон уу? **Хүүхдийн төлөө** тэгээд “**За**” гээд л дуугараад л. Ингээд юу байгаа юм бэ? Хүүхдэд зориулсан өнөөдөр юу байна?

Өнөөдөр тэр аутизмтай хүүхдүүд, тэр 29 дүгээр дунд сургууль. Хамгийн наад талын шаардлага анхаарал тавих ёстой тэр хүүхдүүдэд шаардлагатай анхаарал халамж тавигдсан уу?

Өнөөдөр илчлэгтэй хоол унд тэр юмаа авч чадаж байгаа юу? Энэ дээр л бас нэг ингээд яримаар байх юм. Зүгээр нэг байдаг. Эрх биш нэг ингэж өнгөрөөсөн маягаар ингэж хандаж болмооргүй байх юм. Би тиймэрхүү маягтай л ингээд л өнгөрөөсөн ийм л үйл ажиллагаа болоод байна уу даа л гэж бодож байна.

Асуулт авчхаад тодруулна.

Д.Цогтбаатар: Ц.Мөнхцэцэг гишүүнд микрофон өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Д.Ганбат гишүүний асууж байгаа энэ асуудлаар үнэхээр үндэслэлтэй чухал асуудал байгаа.

Ер нь энэ хүүхдийн эрх зөрчигдөөд байгаа, Монгол Улс олон улсын болон хүүхдийн эрхийг хамгаалах бүх гэрээ, конвенцод нэгдэн орсон. Хүүхэд хамгааллын хуулиа баталсан боловчиг яг бодит амьдрал дээр орон нутагт, нийслэл ерөөсөө газар зүйн байдлаас үл шалтгаалаад тодорхой нөхцөлд хүүхдийн эрх зөрчигдөж байна. Гэмт хэрэг хүүхдийн эсрэг хүчирхийлэл, сурч болзох эрх нь зөрчигдсөн, сургууль завсардсан хүүхдүүд их олон байна.

Тийм учраас бид зөвхөн нэг хуулийг батлаад гэдэг юм уу, эсвэл хүүхдийн эрхийн тодорхой нэг асуудлаар шийдэл гаргаад үр дүнд хүрэхгүй. Энэ дээр яах аргагүй суурь шалтгаануудыг арилгах ёстой.

Мөн сонсголын үеэр яригдсан манай гишүүдийн тодорхой саналууд ч бас байна.

Ер нь хүүхдийн эрх хамгаалах үндсэн суурь шалтгаан юу юм бэ? Энэ дээр нэгдсэн том мэдээллийн бааз бүрдүүлэх, суурь шалтгааныг олох судалгаануудыг хийх шаардлагатай.

Хүүхдийн эрх гэдгийг бид зөвхөн явцууруулаад нэг эрхийн асуудлаар кэйсийг хөөж ярьж болохгүй.

Тийм учраас хүүхдийн эрхийг Үндсэн хуулийн гол концептууд юу байна? Суурь шалтгаан, боловсрох, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, нийгэмд үнэлүүлэх, нийгмийн ажилд хүүхдүүд маань оролцох зэрэг бүх л эрхийг судлах шаардлагатай байгаа.

Тийм учраас энэ асуудлаар бид Монгол Улсад хүний эрхээ хангах гол үндэсний механизм болсон Хүний эрхийн Үндэсний Комиссыг илүү шахааж ажиллах, комиссын судалгаа, дүгнэлт, зөвлөмжүүдийг илүү өргөн хүрээтэй болгох тал дээр ер нь анхааруулсан ийм тогтоол гарах нь зүйтэй байх.

Тэгээд дээрээс нь **“хүний эрхийн мэдрэмжтэй төсөв”** гэдгийг ер нь бүх шатдаа анхаарах ёстой юм байна.

Нэлээд олон аймаг, орон нутаг дээр Засаг даргын өргөн барьсан хүүхэд хамгааллын төсвийг иргэдийн Хурал нь баталдаггүй. Тэгээд тухайн газар, нэгж дээр нөгөө хамтарсан баг маань тодорхой хүүхдийн эрхийн зөрчил дээр ажиллах төсөвгүй болчихдог. Эсвэл тухайн хамтарсан баг дээр ажиллах хүний нөөц нутагтай байгаа.

Тийм учраас **“хүүхэд хамгааллын мэргэжлийн тогтолцоо”**-гоо бүрдүүлье ээ гэдэг хоёр дахь том асуудал гэдгийг сая сонсголын үр дүнгээс харагдсан.

Тэгэхдээ ер нь Монгол Улсын одоо байгаа хүний нөөцтэй уялдуулаад багш нар, мэргэжилтнүүд, энэ чиглэлээр ажиллаж ирсэн хүмүүсээ бүгдийг нь дайчлах шаардлагатай байна.

Хүний эрхийн чиглэлээр ажилладаг маш олон төрийн бус байгууллагууд байна. Тэд нартайгаа урт болон дунд хугацааны гэрээ байгуулаад гэрээлэн ажиллуулж хүүхдийн эрхийг хамгаалах хүний нөөцөө илүү өргөн хүрээнд бэхжүүлье гэдэг саналуудыг маш олон хуульч нар тавьсан.

Үүнийг бид хийх шаардлагатай байгаа. Тэгээд дээр нь Д.Ганбат гишүүн төсвийг асууж байна.

Ер нь хүүхэд хамгааллын төсөв жил жилийн төсөв дээр нэмэгдэж байгаа. Тэгэхдээ энэ хангалтгүй. Бид зөвхөн төсвийг нэмсэн ч гэсэн яг нөгөө хүүхэд хамгаалах суурь тогтолцоо маань яг тэр газар дээрээ үр дүнтэй ажиллаж чадахгүй бол төсөв хэдийгээр нэмсэн ч гэсэн тэнд үр дүн гарахгүй.

Тийм учраас хүүхэд хамгааллын төсвийг дагалдуулан тэнд ажиллах тогтолцоо, механизм нөгөө хорооны нэгж дээр байгаа хамтарсан багийн ажилтнуудаа илүү чадваржуулах, шаардлагатай үед дайчлан ажиллуулах нэмэлт хүний нөөцийг төрийн бус байгууллагуудаасаа олж гэрээлэн ажиллах зэргийг хийх шаардлагатай байна.

Тогтолцоо нь өөрөө ажиллахгүй байгаа тохиолдолд зөвхөн нийгмийн хамгаалал, хүүхдийн хамгааллын төсвийг нэмээд энэ үр дүнд хүрэхгүй юм байна. Энэ нь олон кэйсээсээ харагдаж байна.

Тэгээд хүний эрх хамгаалах мэргэжилтнүүд маань хэлээд байгаа.

Ер нь бид ойрын 3-аас 5 жилдээ яг хүүхэд хамгааллын тогтолцооны төсөв ийм байна гэдгийг тогтвортой бүрдэж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ингээд 5, 6 жилийн дараагаас нөгөө тогтолцоо маань үр дүнтэй ажиллана.

Д.Цогтбаатар: Д.Ганбат гишүүнд микрофон өгье. Тодруулья.

Д.Ганбат: Уг нь нэг хүүхдийг тосгоноороо л хүмүүжүүлдэг, улс орноороо л хүмүүжүүлдэг гэдэг.

Гэтэл манайд тийм юм байхгүй байна. Хүүхдүүд ерөөсөө анхаарлаас, төр, засгийн анхаарлаас ер нь ангид байгаа юм шиг. Зүгээр нэг уриа лоозон, хурал цуглаанаар ингээд асуудал шийдэгдэж байгаа юм шиг байна.

Энэ нь ч өнөөдрийн хурлын уур амьсгал, бид бүхний асуудалд хандаж байгаагаас харагдаж байна.

Ганц л эмэгтэй гишүүн. Байгаа байдал нь нэг хурал цуглаан хийгээд л. Өөрийнхөө хэмжээнд л бас чадан ядан ингээд хөөцөлдөж байх шиг байна.

Бид бүхэн одоо энэ дээр анхаарал тавих нь зүйтэй гэж ойлгож байна.

Ер нь яаж төр, засаг анхаараад байна. Танай намын бодлого чинь ямар байна. Цаашдаа юу болох юм бол. Одоо энд та л хариулах байх даа. Өөр хариулчих хүн байгаа юм болов уу, үгүй юм болов уу. Тийм.

Д.Цогтбаатар: Ц.Мөнхцэцэг гишүүн хариулах уу?

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Монгол Ардын намаас хүний эрхийг хангах, хүний эрхийн одоо байгаа үндэсний механизмыг илүү үр дүнтэй ажиллуулах чиглэлээр нэлээд олон ажлууд санаачлан хийж байгаа.

Тухайлбал, өнгөрсөн жил Монгол Улсад үйлчилж байгаа бүх хуулиуд дээр хүний эрхийн томоохон анализ судалгаа хийсэн байгаа. Энд манай мэргэжлийн маш олон хуульчдын томоохон баг ажилласан.

Ингээд хууль дээр хийсэн энэ дүгнэлтээс харахад одоо үйлчилж байгаа гол хуулиудын маань нэлээд хэсэг нь цаг хугацааны хувьд хоцрогдсон. Энэ хууль батлагдсанаас хойш нийгмийн процесс болон технологийн дэвшил нэлээн өөрчлөлтүүд гарсан.

Тийм учраас шинэчлэх шаардлагатай заалтууд их олон байна.

Хоёрдугаарт, нь, одоо, шинээр, оруулах эрх зүйн зохицуулалтууд нэлээн байна. Тухайлбал, хүний эрхийг хамгаалах чиглэлээр үйлчилж байгаа бүх эрх зүйн хууль тогтоомжуудад нэлээд олон саналуудыг хуульчид маань гаргасан байгаа.

Монгол Ардын намын хүний эрх хөгжил.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Нэмж хариулах уу? Ц.Мөнхцэцэг гишүүнд нэмж хариулах боломж олгоё уу? Микрофон он өгье.

Ц.Мөнхцэцэг: Тухайлбал, хүүхдийн эрхийн асуудлаар хүчирхийлэлд өртсөн хүүхдэд урт хугацааны нөхөн сэргээх сэтгэл зүйн болон бусад үйлчилгээ үзүүлэх механизм хэрэгтэй байна.

Хүүхдийн боловсрол, өсөж хүмүүжих, нийгэм, сэтгэл зүйн орчин гээд бүх талаас нь авч үзэх шаардлагатай.

Энэ чиглэлээр ажиллаж байгаа төрийн механизмуудыг бүрэн ажиллуулах, хүүхдийн эрхийн болон хүний эрхийн мэдрэмжтэй төсвийг бүрдүүлэх. Өөрөөр хэлбэл төсөв батлах анхнаасаа бүх процесс маань хүний эрхийн мэдрэмжтэй байх ёстой. Тэгж байж бид энэ үйлчилж байгаа хууль тогтоомждоо хүний эрхийг хамгаална.

Тогтолцоогоо бүрэн үр дүнтэй ажиллуулах санхүүгийн нөөцийг хуваарилах боломжтой болно.

Тэгээд дээрээс нь Гэр бүлийн хууль, Хөдөлмөрийн хууль, Хүүхэд хамгааллын хуульд хүүхдийг хамгаалах олон улсын сайн жишиг Монголд нутагших боломжтой.

Д.Цогтбаатар: С.Бямбацогт гишүүнд микрофон өгье. С.Бямбацогт гишүүн асуулт асуухгүй юм байна.

Тэгвэл сонголын тайлантай холбогдуулан асуулттай гишүүд асуулт асууж дууслаа.

Тайлантай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Д.Ганбат гишүүнээр тасаллаа. Ж.Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Тэгэхээр сая Ц.Мөнхцэцэг гишүүн хэлж байна л даа. Хүүхэд хамгааллын асуудал дээр тогтвортой санхүүжилт, төсвийн асуудлыг шийдэх ёстой гэж байгаа юм.

Ерөөсөө хэргийн учир ер нь хоёр юм дээр л гол юм байгаа шүү дээ.

Нэгдүгээрт, санхүүжилт төсвийн тогтвортой асуудал шийдэх.

Хоёрт нь, хүний нөөц, боловсон хүчний асуудал байгаа юм.

Ер нь хүний нөөцийн тогтвортой байдал юм уу, мэргэшсэн биш байдал, тэгээд санхүүжилтийн тогтолцоо хоёроос хамаараад удирдлага зохион байгуулалтынх нь хүүхэд хамгааллын тогтолцоо бас нэг тийм сайн зүгширч өгөхгүй байгаад байгаа юм.

Яг өнөөдөр хүүхэд хамгааллаар манлайлал талаас нь иргэний нийгэм гэдэг юм уу, төрийн бус байгууллагууд талаас нь харах юм тодорхой хүмүүс байгаад байдаг. Яг манай төрийн байгууллагын талаас нь харах юм бол их олон хүн солигдож холигдсон. Тэгээд л 8 тэрбум төгрөгийн л асуудал ярьдаг. Сүүлийн хоёр, гурван жил ярьдаг юм.

Тэгэхээр энэ утгаараа би энэ сонссоны дагуу төрийн бодлого ер нь цаашдаа урт удаан хугацаандаа хүүхэд хамгааллын чиглэлийнхээ талын төрийн талынхаа мэргэшсэн тэр хүмүүсийг бэлтгэх, тэд нарыгаа дэмжих, тэгээд тэр санхүүгийнхээ тэр боломж баталгаа байх тэр талд нь нь бид цаашдаа онцлон анхаарахгүй бол мянга хуулиуд сайн гаргаад тэр хуулиуд чинь амьдрах гол хөрс нь хүн. Тэгээд санхүүжилт хоёр байхгүй юу.

Тэгэхээр үүнийг нь би онцолж тэмдэглэж үзэх нь зүйтэй байх. Бид тайлан дүгнэлт гээд хүмүүс сонссон, харсан.

Тэгээд ямар нэгэн юм хийхийг шаардаад л байдаг.

Гэтэл ер нь өнөөдрийн олон асуудлуудыг бид шийдэж чадахгүй байгаагийн чинь гол үндэслэл нь төрийн чадамжтай холбоотой шүү дээ. Тэгээд төрийн чадамж нь хууль биелүүлэх чадвар, тайлбарлан таниулах, хуулийг биелүүлэх тэр тогтолцоо нь сул байгаа, тэр хүмүүс нь сул байгаатай. Ялангуяа сүүлийн үеийн Монголын төрийн бүх шатан дахь асуудал бол хүний нөөцийн хомсдол, тогтворгүй байдал, мэргэшсэн хүмүүсийнх нь баталгаа, тэр орон байр, ажлын нөхцөлүүд чинь тааруу байгаатай л холбоотой шүү дээ.

Үүнийгээ анхаараагүй нөхцөлд бодлого яг зөв явж чадахгүй.

Тийм учраас хүүхэд хамгааллын чиглэлийнхээ мэргэшсэн боловсон хүчнийхээ тогтолцоон дээр бид Төрийн албаны зөвлөл байгаатай адилхан ер нь энэ чиглэл чиглэлийн дутагдалтай юман дээрээ боловсон хүчний тэр листүүд, жагсаалтуудыг гаргамаар юм шиг байгаа юм.

Сүүлийн 10 жил хүүхэд хамгааллын чиглэлээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, бусад яам дээр яг мэргэшсэн хэдэн хүн тогтвортой ажиллав. Судалгаа хэрэгтэй. Доод дунд шатад ямар хүмүүс тогтвортой ажиллав.

Үүнийгээ дүгнэх тал дээр, бид ажиллаж байгаа хүмүүс рүү чиглэсэн судалгаа, тооцоо юм ер нь сонсогдохгүй байгаа шүү. Тэгээд үүнийгээ анхаарах хэрэгтэй.

Тэгэхгүй мөнгө заръя гэхээр хүмүүс тэгээд байна шүү дээ. Хэнд, юунд зарах гээд байгаа юм гээд. Тэр хүүхэд хамгаалалд зарна. Тэгэхдээ хэнд итгэх вэ гэхээр одоо эргээд л янз бүрийн асуудал болж байхад цаад ажиллах гэж байгаа хүмүүст нь л хүн итгэж л мөнгөө зардаг юм байна шүү дээ.

Тэгэхээр энэ утгаараа би энэ хүүхэд хамгааллын тогтолцоонд Их Хурал дүгнэлтээ хийж, энэ дээр манай Их Хурлын гишүүд хуулийнхаа юман дээр анхаарал хандуулахаас гадна яамдын асуудал дээр.

Ингээд харахад нэлээн хүмүүс шүүмжлэлтэй, бухимдалтай өнгө аясаар ярьж байгаа. Тэгэхдээ шүүмжлээд, бухимдаад асуудал засагдахгүй шүү дээ.

Түрүүн Ц.Мөнхцэцэг гишүүний хэлээд байгаа асуудал дээр санхүүжилт, хүн хүчний нөөцийг тогтвортой барих, хадгалах явдал чухал гэдгийг тэмдэглэж хэлье.

Д.Цогтбаатар: Тайлантай холбогдуулаад гишүүд, Д.Ганбат гишүүн. Уучлаарай.

Д.Ганбат: Яах вэ, би яарч байгааг ойлгож байна. Тийм.

Гэхдээ асуудал маань өөрөө их чухал юм л даа. Энэ чинь хүүхэдгүй хүн нэг ч байхгүй. Тийм.

Ерөөсөө Монгол Улсын ирээдүй, энэ бүх зүйл чинь хүүхэдтэй л холбоотой шүү дээ. Тэр тусмаа Монгол чинь **“залуучууд, хүүхдүүдийн орон”** гэж нэрлэгддэг.

Нам, засгаас маш их анхаарал тавьж байгаа юм байна гэж ойлгож байна.

Манай энэ ширээ тойроод их олон гишүүн сууж байна. Бас энэ дотроос хоёр, гурван гишүүн асуулт асуугаад энэ асуудлуудын хажуугаар бас үгээ хэлээд явж байгаа нь их бахархуштай зүйл.

Ер нь энэ болохгүй, бүтэхгүй байгаа зүйлийн хажуугаар дуугүй өнгөрнө гэдэг чинь тэрийг хүлээн зөвшөөрч байна, дэмжиж байна л гэсэн ойлголт болчих гээд байгаа юм. Би тэгж боддог. Бас гадуур тэгж ярьдаг.

Та бүхэн маань дотроо маш их сэтгэл чинь эмзэглэж байгаа байх. Гадуур олон мянган төгрөгийн хулгай, авлигал энэ бүх зүйлүүдтэй. Үүний илэрхийлэл нь хүүхэд дээр л тусаж байгаа юм л даа.

Өнөөдөр бид нарын нам, засгаас үнэхээр хангалттай анхаарал тавиад өдий

хэмжээнд оччихов уу? Ямар байгаа юм бэ? Ер нь хийсэн ажлын маань үр дүн ингэж гараад байна уу?

Нэг ангид 50-аас 60 хүүхэд байж байна. Энэ төрөх эмнэлгүүд дүүрэн байдаг. Шалан дээр төрөх дөхсөн жирэмсэн эмэгтэй байж байна.

Үнэхээр аягүй сэтгэл эмзэглэмээр дүр зургууд харагдаж байна л даа.

Тэгээд одоо эндээс чинь бид ямар ирээдүй байна вэ? Хүн юу хүлээх вэ? Хүүхдэдээ анхаарал тавьж чадахгүй байгаа ийм улс орон.

Тэгээд 200, 300 мянган төрийн албан хаагчтай. 1 сая хүрэхгүй хүүхэдтэй.

Тэгээд тэр тусмаа Монголчууд чинь цөөхүүлээ шүү дээ. 3 сая 500 мянган хүн байгаа.

Яах вэ тэр социализмын үед би түрүүн хэллээ. Бас аав, ээжийгээ дагаж ирээд нөгөө **“Бамбарууш”** кафед Улаанбаатарынхан орсноороо бахархаж ярьдаг.

Ерөнхий сайд анхаарал тавиад **“Бамбарууш”** кафегаа ямар ч байсан бүрэн эрхийнхээ хугацаанд ашиглалтад оруулна гэж ярьж байгаа. Энэ бас их сайн. Энэ хүн бас өөрөө ингээд үлгэр жишээ үзүүлээд явж байна.

Бусад нь юу хийж байна вэ? Бүгд л сэтгэлээ тээгээд л сайн сайхан болгох гээд бодоод явдаг боловч үр дүн аягүй тийм хангалттай биш байна. Жилээс жилд бид төсөв хэдэн их наядаар. Бараг Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 40, 50 хувийг улсын төсөв болгоод баталж байна.

Гэтэл үр дүн нь ямар байна вэ? Дэлхий яг дундаж түвшинд очсон тийм сургалтыг хүүхдүүддээ явуулж чадаж байна уу? Зүгээр л баахан л хүүхдүүдийг нэг танхим чихээд өдөр хоног өнгөрүүлээд дуусаж байна уу?

Өнөөдөр хүүхдийн мэргэжлийн эмч гэхэд алга байна шүү дээ. Тийм сургаж байгаа тогтолцоо нь ч алга байна. Гэх мэтчилэнгийн.

Тэгээд өлөн зөлмөн ийм хоол ундтайгаар олигтой сургаж мэдүүлсэн юм байхгүй ийм л хэмжээнд явж байна гэсэн дүгнэлтүүдийг олон улсын байгууллага, судлаачид хэлээд байна л даа.

Бид болохоор аягүй их юм хийчихсэн юм шиг, хийж байгаа юм шиг. Зүгээр ам хэлээрээ л яриад байдаг. Амьдрал дээр энэ зүйл нь харагддаггүй, мэдрэгддэггүй. Нөгөө хүүхдүүд маань анхаарлаас ангид байгаа болохоор.

Багшийн цалин чинь өнөөдөр хэд байна вэ? Тэгтэл 3 сая төгрөгийн цалин өгөхгүй бид татганаад л байгаа шүү дээ. Бид ч юу байх вэ энэ нам, засаг маань. Тийм.

Энэ эмч нарын цалин ямар байгаа билээ. Тэр гайгүй эмч, багш нар чинь бүгдээрээ гадагшаа гараад явах гээд байна л даа. Виз нь олдохгүйгээс. Виз нь олдож байгаа хэсэг нь яваад байна.

Тэгээд энэ бүх болж байгаа асуудлуудын хажуугаар бид болж байгаа, бүтэж байгаа юм шиг ингээд нэг сонсгол хийж байгаа нь сайн л даа. Тэгээд энэ хуулийн нөхцөл, энэ юмыг сайжруулж байгаа нь бас л сайн байх.

Тэгээд сонсгол хийсэн гишүүний хариулж байгааг харахад үүгээр нэг их үр

дүн харагдахгүй ээ л гэж хэлж байна. Би ч гэсэн санал нэг байна. Зүгээр асуудлыг ингэж хохирогч болохгүй.

Ер нь манай Байнгын хороо санал, санаачилга гаргаад.

Д.Цогтбаатар дарга аа,

Та тэр юм үзэж нүд тайлсан хүн. Тийм. Өндөр ч боловсролтой байх. Энэ хүүхдүүд чинь бас тан шиг боловсролтой болмоор байгаа байх.

Тэгэхээр бид бас зохих хэмжээнд.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Би бас тайлантай холбогдуулаад нэг товчхон зүйл хэлчихье.

Хэлэх үг бол Б.Энхбаяр сайд руу хандаж би хэлмээр байна.

Нэгдүгээрт, их чухал асуудал яригдаж байгаа юм. Гэхдээ Б.Энхбаяр сайд аа, нэг ийм юмыг анхаарах хэрэгтэй байна.

Ер нь бид сенсацаас сенсацад. Сенсац болонгуут түүнд хариу бариад байгаа юм шиг ийм байдлаар ажиллаж байна. Хуулийн чиглэлийн хууль хэрэгжүүлэх ажил сенсацаар явахгүй ээ.

Та сайдын албан тушаалаа авахдаа **“Би хүний эрхийг дээдэлсэн сайд байна”** гэж хэлсэн. Энэ бол хуульч хүний хамгийн эрхэм зүйл.

Тэгэхээр энэ дээр би нэг зүйлийг хэлмээр байна.

Хүний эрх дотроо өөрийнхөө эрхийг хамгаалах чадавх хамгийн сул дорой байгаа хүүхдүүдийн эрх дээр нээрээ онцгой анхаарах ёстой.

Энэ тайлангийн дагуу одоо яг эндээс ямар ямар юмнууд олж мэдэв ээ, хаана ямар дутагдал байна вэ. Дутагдал маш их байгаа шүү дээ.

Гэхдээ юм хийхгүй байгаа биш хийж байгаа. Энэ дунд аягүй олон хийдэл, цоорхой гараад байна гэж яриад байна шүү дээ. Сөрөг хүчин маань ч бас яриад байгаа.

Тэгэхээр энэ дээр нь анхаарч ажиллах хэрэгтэй. Хүүхдийн эрх дээр та тэгэхээр онцгой анхаарч ажиллах ёстой.

Энэ дагуу яг тодорхой, одоо энэ хийгдээгүй байгаа, хийгдэх ёстой байсан боловч хийгдээгүй, цаг алдчихсан байгаа энэ арга хэмжээнүүд дээр онцгой анхаараад яаралтай арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй. Нэг зүйл.

Хоёр дахь нь, Д.Ганбат гишүүн та хоёр түрүүний Байнгын хорооны хурал дээр Мөнх-Эрдэнэтэй холбогдуулан очиж газар дээр нь танилцаад надад ирж үр дүнгийнхээ талаар тайлан тавиарай гэж Байнгын хорооноос үүрэг өгсөн.

Би хүлээж байгаа шүү.

Та хоёр яваад ямар ч гэсэн Д.Ганбат гишүүн очсон байна лээ.

Тэгээд надад орж ирж асуудлаа танилцуулна гэсэн.

Нэг нэгээрээ байх уу, хоёулаа байх уу. Хамаагүй. Гэхдээ энэ асуудлыг танилцуулах ёстой шүү.

Тайлантай холбогдуулж үг хэлэх гишүүд үгээ хэлж дууслаа.

Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаарх Улсын

Их Хурлын хяналтын сонсголын тайлан, Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг өөрөө танилцуулна.

Ямар ч тогтоолын төсөл орж ирсэнгүй. Зүгээр бид танилцаж байгаа шүү дээ.

Тийм тогтоол санаачилъя гэж байгаа бол.

Ц.Мөнх-Оргил гишүүн ээ,

Тийм учраас тогтоол байхгүй учраас би сая Б.Энхбаяр сайдад үүрэг өгч байгаа байхгүй юу.

Энэ тайлангийн дагуу хаана юу хоцорчихсон, юу орхигдсон байна, үүгээр юу хийх вэ гэдэг энэ саналаа надаа танилцуулаарай гээд байгаа нь тэр.

Гэхдээ нээрээ тогтоол гаргах бол. Та тогтоол санаачлах эрхтэй шүү дээ.

Гэхдээ одоо энд орж ирээгүй байна шүү дээ.

Ц.Мөнх-Оргил гишүүнд микрофон өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Горимын санал байна.

Өнөөдөр тайлангийнхаа тухай сонсчихлоо.

Нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны дүгнэлтийг танилцуулахаас өмнө магадгүй энэ долоо хоногт яарч танилцуулахгүйгээр дараагийн долоо хоног хүртэл хойшлуулаад Ц.Мөнхцэцэг гишүүн энэ хэлэлцүүлэгт оролцсон гишүүд, төрийн бус байгууллагынхантай санал солилцоод тайлангийн мөрөөр

Улсын Их Хурлын нэг тогтоолын төсөл гарах уу, үгүй юу гэдэг асуудлыг нэг тийш нь болгочихмоор байна.

Тэгээд гарахгүй юм байна гэвэл энэ долоо хоногтоо оруулчихъя. Гарах юм байна гэвэл дараагийн долоо хоногт нэгдсэн хуралдаанд оруулаад тогтоолынхоо төслийг Байнгын хороон дээрээ товчхон ярих хэрэгтэй байгаа юм.

Тэгж байж бид нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын ийм тогтоолын төсөл гээд.

Би тогтоолын төсөл орох нь зүйтэй юм болов уу гэж бодоод байна.

Хэлэлцүүлэг дээр хүмүүс хоёр л юм яриад байгаа шүү дээ. Нэг талаас төсөв яриад байгаа юм.

Гэтэл сая яг Ж.Сүхбаатар гишүүн бид хоёр тэр хэлэлцүүлэг дээр ч гэсэн хэлээд байгаа юм нь тэр байгаа байхгүй юу.

Төсөв яриад байгаа мөртлөө механизм ажиллахгүй байна, хамтарсан баг ажиллахгүй байна, хоосон эргээд байна гэххээд тэр дээрээ ахиад мөнгө нэмэхээр чинь утгагүй болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр механизмаа яаж сайжруулах юм бэ?

Тэр хамтарсан багаа яаж бүрдүүлэх юм?

Тэр төрийн бус байгууллагынхны оролцоог яаж нэмэгдүүлэх юм ч гэдэг юм уу. Тийм ээ.

Энэ юмнуудаа бүгдийг нь нэг тогтоолын төсөл болгоод Байнгын хороон дээрээ танилцуулаад нэгдсэн

хуралдаанд оруулаад, Засгийн газарт үүрэг өгөх юм бол сая бидний тайлан сонссон, сонсгол хийсний үр дүн гарах гээд байна. Ийм горимын санал байна.

Д.Цогтбаатар: Тэгвэл ингэе. Яг түрүүн Б.Энхбаяр сайдад би хандаж үг хэлсэн шүү дээ. Энд ингээд үүний дагуу хийх ажлуудаа та нар боловсронгуй болгоод танилцуулаа гэсэн.

Тэгэхээр нөгөө хуулийнхаа хугацаанд энэ тайлангаа нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх ёстой учраас үүнийг Ц.Мөнхцэцэг гишүүн Улсын Их Хурлын нэгдсэн чуулган тайлангаа танилцуулна.

Тусдаа энэ дагуу хэлэлцүүлснийхээ дараа Б.Энхбаяр сайдтай ярьж байгаад тогтоолын төсөл санаачилж оруулж ирээрэй гэсэн ийм чиглэл өгөөд энэ асуудлыг хаая. /алх цохив/

Гэхдээ би асуудлаа нээхгүй шүү. Одоо би асуудлаа нээхгүй. Зүгээр та үгээ хэлчих. Тэгье. Б.Пүрэвдорж гишүүнд микрофон өгье.

Б.Пүрэвдорж: Хүүхдийн эрхийн асуудлаар нийтийн сонсгол хийсэнд их баярлаж байгаа.

Ялангуяа манай намын гишүүд маш идэвхтэй, манай эмэгтэйчүүд маш их идэвхтэй оролцож олон нийтэд дуу хоолойгоо хүргэх асуудлыг, энэ Их Хурлын танхимд хийх боломжийг гаргаж өгсөн Та бүхэнд баярлалаа.

Тийм учраас энэ асуудлаар дахиад ажлын хэсэг гаргахдаа ялангуяа хүүхдийн асуудлаар маш их идэвхтэй ярьдаг н.Булгамаа, тэр бас нэг эмэгтэй байгаа. н.Жаргалан энэ тэрийг бас эндээ оруулж Та бүхэн яг энэ хүүхдийн эрхийн

асуудлаар маш сайн ярьдаг тэр хүмүүсийн санал бодлыг нь заавал сонсохыг хүсэж байна.

Д.Цогтбаатар: Энэ харин зөв санал байна. Би ингэе.

Тогтоол оруулж ирэхдээ энэ хүмүүстэй нь яриад санаа оноог нь тусгаад оруулж ирээрэй, Ц.Мөнхцэцэг гишүүн ээ.

Хоёрдугаар асуудалдаа оръё.

**Хоёр.Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн
хуулийн төслүүд**

*/Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/*

Хоёрдугаар асуудал. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн болно.

Хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 12 дугаар тогтоолоор байгуулан ажлын хэсгийн ахлагчаар миний бие, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяа, Г.Амартүвшин, Ц.Мөнхцэцэг,

Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар, Б.Энх-Амгалан нар орж ажилласан болно.

Түүнчлэн ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй ажлын дэд хэсгийг байгуулж, холбогдох судалгаа, мэдээлэл гаргуулан ажиллалаа.

Ажлын хэсэг 1 удаа, ажлын дэд хэсэг 2 удаа хуралдсан болно.

Төслийг **D-Parliament.mn** цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авсан болно.

Байнгын хорооны ажлын хэсэг 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж, зарчмын зөрүүтэй саналын томъёолол, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх найруулгын саналын томъёоллыг хэлэлцэн дэмжиж, Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Тухайлбал, насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хохирогчийг 18 насанд хүрсний дараа тоолж эхлэхээр, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийг өөрчлөн найруулахаар

хуулийн төслийн саналыг хасахаар, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж, долоо хоногоос 30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулахаар тусгаж Зөрчлийн тухай хуулиас торгуулийн шийтгэлийг хасахаар томьёоллоо.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын шүүгч Б.Батцэрэн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, Улсын ерөнхий прокурорын орлогч, Төрийн хууль цаазын шадар зөвлөх М.Чинбат, Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвлөх Д.Мөнх-Эрдэнэ, Улсын ерөнхий

прокурорын туслах прокурор, Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга О.Мөнхбаатар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дэд дарга бөгөөд Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны дарга Х.Ариунболд, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хууль, тогтоомжийн хэлтсийн дарга Э.Бадамсамбуу, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Т.Нарантунгалаг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн Ц.Лхагвацэнд, Тээврийн цагдаагийн албаны Мөрдөн шалгах хэлтсийн дарга В.Хосбаяр, Тээврийн цагдаагийн албаны Зөрчил шалган шийдвэрлэх хэлтсийн дарга Ц.Чинзориг гэсэн хүмүүс оролцож байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн [1 дүгээр зүйл](#)-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Д.Ганбат гишүүнээр тасаллаа.
Ц.Мөнх-Оргил гишүүнд микрофон өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Шийдвэр гүйцэтгэлийнхнээс асуух гэсэн юм.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд, ялангуяа хорих ял эдлүүлэх ажиллагаанд ямар

нэгэн байдлаар хүндрэл гарах зүйл байна уу?

Би зүгээр тэр юуг л хараад байна л даа. Тэр бүх насаараа хорих ял шийтгэгдсэн хоригдлууд 25 жилийн дараа шүүхээр орж суллагдах асуудал ярих байхад одоо 5 жилээр сунгагдаж байна шүү дээ. Тийм ээ.

Энэ хорих ял эдэлж байгаа хүмүүст шууд үйлчлэх гээд байна уу, үйлчлэхгүй юу? Үйлчилбэл ямар нэгэн хүндрэл үүсгэх үү, үүсгэхгүй юу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, манай шүүхийнхнээс л асуудаг байх даа. Мэдээж ял чангаруулж байгаа нь зөв л дөө. Одоо энэ гэмт хэрэгтэй бид өөр тэмцэх арга замаа хайгаад л ядаад л олон замын л арга хайж байна.

Тэгэхдээ шүүхийн практикт “**бүх насаар нь хорих ял эдлүүлэх**” ялыг ер нь хэр давтамжтай оногдуулдаг юм бэ? Одоо нөгөө нөлөө нь ямар байдаг юм бэ?

Одоо жишээлбэл, сая 20 жилийн хорих ялыг бид 25 болгож байна шүү дээ. 5 жилээр нэмэхийн нэг сайн болон давуу тал дээр манай шүүхийнхэн тайлбар байвал бид нарт хэлээд өгөөч.

Тэгээд яг энэ зүйлтэй хамаагүй юм. Тэгэхдээ нэгмөсөн асуучихъя тэгэх үү.

Энэ дээр дараа нь мартагдчихаж магадгүй. **“Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ”** гэж өөрчилсөн байгаа байхгүй юу. Сая Засгийн газраас орж ирэхдээ.

Хуучин **“согтууруулах ундаа, мансууруулах бодисын нөлөөнд**

автагдсан” билүү, юу билээ. **“Хэрэглэсэн”** гэсэн үг байхгүйгээр байсан шүү дээ. Тийм ээ.

“Хэрэглэсэн” гэдэг үг үгүйгээр. Үүнийг яг яагаад ингээд өөрчилчихсэн юм бэ? Энэ дээр нэг тайлбар хэлэх хүн байна уу? Хууль зүйн яамныхан хэлэх үү.

“Хэрэглэсэн үедээ” гэж оруулж ирчхээд байгаа шүү дээ. Тодотгол. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Асуулт дууссан уу? Хариулт өгье. Хэддүгээр микрофон байна? 7 дугаар микрофон өгье. 7 руу суучих.

Та нар багтахгүй юм чинь 7 дээрээ солиод солиод суучхаарай. 7 дугаар микрофон өгье.

Э.Бадамсамбуу: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хууль тогтоомжийн хэлтсийн дарга, дэд хурандаа Э.Бадамсамбуу асуултад хариулъя.

Хууль үйлчилж эхэлснээс хойш тооцож эхлэх учраас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор байр, орчин нөхцөлийн хувьд хүндрэл үүсэхгүй байх гэж бид урьдчилан харж байгаа.

Цаашдаа тухайн зүйл, ангиар ял шийтгүүлсэн хүмүүсийн тоо нэмэгдэхтэй холбогдуулаад тухайн жилийнхээ төсөв дээрээ нэмэлт санхүүжилтээ аваад явчихад байгууллагын зүгээс хүндрэлтэй зүйл үүсэхгүй гэж харж байгаа. Нэгдүгээр асуултын хувьд.

Д.Цогтбаатар: Хариулт хангалттай юу? Д.Ганбат гишүүн.

Шүүхээс Б.Батцэрэн шүүгч хариулах уу? Ажлын хэсгийн 5 дугаар микрофоныг өгье.

Б.Батцэрэн: Тийм. Тэгэхээр Ц.Мөнх-Оргил гишүүний асуусан асуулттай холбогдуулаад одоо үүнийг шууд буцаан хэрэглэнэ, хэрэглэхгүй гэж бас хэлэхэд төвөгтэй нөхцөл байдал үүсэж байна.

Яагаад гэвэл гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг 2020 онд өөрчлөлт оруулсан. Ингээд тоолно, тоолохгүй гэдэг ийм хууль зүйн маргаан явсан. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт хүртэл гарсан.

Улсын Дээд шүүх тайлбар гаргахдаа хэдийгээр энэ хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам нь Эрүүгийн хуульд хуульчлагдсан ч гэсэн энэ процессын шинж чанарыг агуулсан хэм хэмжээ.

Тэгэхээр батлагдсан үеэсээ мөрдөж ажиллана гэсэн ийм агуулга бүхий тайлбар гаргасан.

Тэгэхээр энэ хууль батлагдахаас өмнө гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн хувьд тэр гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг шинээр батлагдсан журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэснээр хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй байхаар ингэж хэрэглэсэн.

Тэгэхээр яг энэ бүх насаар хорих ял шийтгүүлсэн хүмүүст энэ журмыг тэр өмнөх 25 жилээр явах уу, эсвэл шинээр батлагдсан 30 жилээр явах уу гэдэг Улсын дээд шүүх нийт шүүгчийн хуралдаанаар бас хэлэлцэж нэгдсэн шийдэл гаргахгүй бол би одоо яг энэ талд нь ингэж хэрэглэх ёстой гэж хэлэх боломжгүй байна.

Бүх насаар хорих л шийтгүүлэх гэмт хэрэг Эрүүгийн хуульд 15 байгаа. Хүнийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар алах, бага насны хүүхдийг хүчиндэх, мөн бэлгийн мөлжлөг, хүний наймаа зэрэг ийм онц хүнд хэргүүд дээр байгаа. Энэ тодорхой хэмжээнд хэрэглэгдэж байгаа ийм заалт юм.

Д.Цогтбаатар: Ц.Мөнх-Оргил гишүүн тодруулъя.

Ц.Мөнх-Оргил: Би техникийн шинжтэй гэх юм уу, эсвэл үүний цаана та нар ажлын хэсэг, Засгийн газар хуулийн төсөл өргөн барихдаа их нарийн учир шалтгаан олж харчхаад энэ үг хэлийг нь өөрчилчхөв үү.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн 27.10 дээр ингэсэн байгаа байхгүй юу. Нөгөө **“авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих”** гээд. Тэгээд үүнийхээ хоёрт нь, энэ гэмт хэргийг 2.1-д **“согтуурсан, мансуурсан үедээ”** гээд гуравхан үг байсан байхгүй юу.

Үүнийг **“согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ”** гээд өөрчилчхөөд байгаа юм.

Тэгээд ерөнхий ингээд харахад агуулга адилхан юм шиг мөртлөө энэ чинь бас их эрх зүйн зөрүү гарч ирээд байна шүү дээ.

Хуучин мансуурсан байх уу, үгүй юу л гэдэг асуудал гол нь байна шүү дээ. Донтсон уу, мансуурсан уу.

Одоо энэ шинэ юугаар яах юм бол бид хэрэглэсэн үү, үгүй юу гэдэг асуудал ярих гээд байна шүү дээ. Тийм ээ.

Тэгээд “мансуурсан уу”, “донтсон уу” гэдгийг чинь тогтооход үлээлгээд л тэр хүний бодиг юугаар нь л яачхаж байгаа шүү дээ. Объектив, гадна талаасаа ямар байдалтай байна, биеэ авч явж чадаж байна уу, үгүй юу гэдгээр нь л тогтоочхож байгаа шүү дээ.

Одоо хэрэглэсэн үү, үгүй юу гэдгээр нь яах гээд байна л даа.

Хэдийгээр хойно нь тайлбар хийгээд тэдэн миллилитр этилийн спирт агуулсан бол энэ тэр гээд тайлбарлачихсан байгаа ч гэсэн.

Тэгээд энэ дээр их тийм нарийн ширийн юм олж хараад өөрчилчхөв үү? Эсвэл зүгээр “хэрэглэсэн” гэдэг үг хэрэглэх нь хэрэгтэй юм байна гэж бодоод та хэд өөрчилчихөв үү?

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? 2 дугаар микрофоныг өгье.

Д.Мөнх-Эрдэнэ зөвлөх.

Д.Мөнх-Эрдэнэ: Ц.Мөнх-Оргил гишүүний асуултад хариулья.

Одоо Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих гэж Зөрчлийн хуулийн 14.7 дугаар зүйл дээр ийм зөрчлийн төрөл байгаа.

Тэгээд энэ дээр 14.7.3 дахь хэсэг дээр жолооч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон гэж ийм томъёолол байгаа.

Тэгээд бид Зөрчлийн хууль дээр байсан томъёоллыг энэ Эрүүгийн хууль дээр хуулийн нэмэлт, өөрчлөлтийнхөө төсөл дээр авч хэрэглэсэн. Энэ дээр ямар нэгэн байдлаар мэдээж сэтгэцэд согтуурсан байна уу, мансуурсан байна

уу гэдэг эдгээр согтууруулах ундаа ч юм уу, эсвэл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж байж л бий болох учраас гээд энэ томъёоллыг хэрэглээд явчихсан байгаа юм. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Ахиад нэмэлт яах уу? Ц.Мөнх-Оргил гишүүнд өгье.

Ц.Мөнх-Оргил: Д.Мөнх-Эрдэнэ зөвлөх өө, өмнөх томъёолол нь зөв байсан юм болов уу л гэж бодоод байгаа байхгүй юу.

Яагаад гэвэл тэнд согтуурсан уу, мансуурсан уу гэдэг нь л гол байгаа байхгүй юу. Одоо болохоор “ундаа хэрэглэсэн үү”, “мансууруулах эм хэрэглэсэн үү”, “сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үү” гэдэг нь чухал болчхоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ гурваас чинь гадна өөр юм хэрэглэжхээд мансуурчихсан байж болно шүү дээ. Өөр юм хэрэглэжхээд согтуурчихсан байж болно шүү дээ.

Өмнөх хуулиар ерөөсөө юу хэрэглэсэн нь хамаагүй. Согтуурсан уу, мансуурсан уу гэдэг нь л гол байсан байхгүй юу. Одоо хүчин төгөлдөр хуулиар чинь.

Ингээд засчихаар чинь энэ гурвын нэгийг заавал хэрэглэсэн л байж байж согтуурсан юм уу, мансуурсан болох ёстой болчхоод байгаа байхгүй юу. Өөр юм хэрэглээд мансуурчихсан байвал яах вэ. Одоо бидний мэдэхгүй юм хэрэглээд гэдэг л зүгээр яах вэ нэг талын онолын юм л даа. Практик дээр их л цөөхөн тохиолдол дээр гарна.

Гэхдээ энэ бүгдийг бид яг л энэ Байнгын хороон дээрээ л ярьж, та нар Хууль зүйн яаман дээрээ ярьж үр

дагаврыг нь тооцож байх ёстой байхгүй юу. Тэр утгаар нь л асуугаад байгаа юм.

Д.Цогтбаатар: Нэмж хариулах уу? Д.Ганбат гишүүнд микрофон өгье.

Д.Ганбат: Би хоёр, гурван юм асууя.

Энэ хуульд яг энэ хэсэгт нь яагаад өөрчлөлт оруулах болов гэдэг зүйлийг асуумаар байна.

Өөрчлөлт оруулсны дараа ямар үр дүн гарах юм бэ? Өөрчлөлт оруулахгүй бол яах юм?

Өмнө нь энэ хууль эрх зүйн орчин чинь болохгүй байсан юм уу? Ер нь цаашдаа яг энэ маягаараа Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах ямар ямар зүйлүүд байгаа вэ?

Бас миний ойлгож байгаагаар уг нь прокурор гэж байна, мөрдөн байцаах гэж байна, шүүх гэж байна.

Ингээд хараад байхад яг тэр өгөх ёстой ялыг нь өгч чадахгүй байна уу? Амьдрал дээр.

Нөгөө ял чинь, одоо энэ бүх юм чинь бас таарсан ялыг нь хэрэгтэнд өгөөд, нөгөө хүнээ сурган хүмүүжүүлээд, засаад, нийгмийг бас сайн сайхан тал руу нь явуулах энэ талаар л ийм бодлого байдаг байх л даа.

Тэгээд яг энэ бодлоготойгоо нийцэж байгаа юу? Ямар байгаа вэ гэдэг зүйлүүдийг тодруулмаар байна.

Тэгэхгүй бол бас гадна, дотнын ямар нэгэн байдлаар дуулиан шуугиан болонгуут л нэг Эрүүгийн хуулийн зүйл, заалтыг ингэж өөрчилье. Дараа нь дагалдуулаад ийм юм болно гээд л. Яг

бид байгаа онож чадаж байна уу, чадахгүй байна уу?

Зүгээр л хамгийн хурдан, амархан шийдэж болох нийгмийн уур амьсгалыг залах ийм чиглэлд яваад байна уу, эсвэл яг үр дүнтэй, хэрэгтэй, зөв зүйтэй чиглэлд явж чадаж байна уу гэдгийг энэ газар газрын мэргэжилтнүүд орж ирээд суучихсан байх шиг байна л даа. Эхлээд би тэрийг нь сонсчихмоор байна.

Д.Цогтбаатар: Ц.Сандаг-Очир гишүүнд микрофон өгье.

Ц.Сандаг-Очир: Д.Ганбат гишүүний асуултад хариулья.

Үндсэндээ хуулийн төслийн хууль зүйн үндэслэлийг асууж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.7-д “Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилсан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно” гэж заасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 77-д “нийгмийн хор аюул, үйлдэгдэж байгаа арга, хэлбэрээс хамаарч зарим гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагыг оновчтой болгох зорилгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж орж ирсэн” гээд энэ асуудлыг бас.

Мөн сүүлийн үед практик хэрэгцээ шаардлага дээр хүн алах гэмт хэрэг, хүн

хүчиндэх гэмт хэрэг. Тэр дундаа энэ хоёр төрлийн гэмт хэрэг дээр бага насны хүүхдийг алах, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн гаралтууд буурахгүй байгаа учраас Засгийн газраас энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангаруулахаар яаралтай горимоор хэлэлцүүлэхээр өргөн барьсан.

Энэ хүрээнд бага насны хүүхдийг алах, хүчиндэх, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, хүн худалдаалах гэмт хэргүүдэд оногдуулах ялын бодлогыг чангаруулахаар хуулийн төслийн үзэл баримтлал боловсрогдсон. Тийм.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хариулах нэмж хариулах хүн байна уу? Б.Батцэрэн шүүгч.

Б.Батцэрэн: Эрүүгийн хуульд хорих ялын хэмжээг 5 жилээр нэмэгдүүлж 30 жил болох энэ төслийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцсэн.

Ингээд 2017 оноос дагаж мөрдсөн Эрүүгийн хууль хэрэгжээд 6 жил болж байна. Энэ хэрэгжилтэд бас дүн шинжилгээ хийх, хорих ялыг 5 жил нэмэгдүүлснээс гарах тэр эерэг, сөрөг үр дагаврыг тооцох ийм шаардлагатай гэж үзэж байгаа.

Эрүүгийн хуульд энэ хүчиндэх гэмт хэргээс гадна хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг, эсвэл үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг зэрэг бас ийм ноцтой хүнд хэргүүд бий.

Тэгэхээр энэ ялын бодлогыг бусад хэргүүдтэйгээ уялдуулж ингэж цогц байдлаар авч үзэх нь зүйтэй байх. Үүнийг хэдийгээр ялын бодлогыг тодорхойлох нь хууль тогтоогчийн онцгой эрхэд

хамаарах боловч судалгааг зайлшгүй харгалзан үзэх хэрэгтэй гэсэн ийм саналыг уламжилсан.

Д.Цогтбаатар: Д.Ганбат гишүүнд микрофон өгье. Тодруулъя.

Д.Ганбат: Яах вэ, ерөнхийдөө бас бид энэ Эрүүгийн хууль үр дүнтэй үйлчлэх ийм шаардлагатай байна л даа.

Гэмт хэргийг багасгах, ял нь гарцаагүй байх гээд олон янзын юунууд байдаг. Тийм ээ. Тэрийг яриад байвал бараг л олон цаг авах байх.

Өмнө нь яг энэ зүйл ангиар ямаршуухан ялын санкцтай байсан юм бэ? Тэр санкц нь яг хэчнээн хүнд яаж үйлчлээд, тэр хүмүүс нь гараад ямар ямар байсан юм бэ? Тийм судалгаа, тооцоо байна уу?

Ингээд 30 жил болгосноороо энэ гэмт хэрэг нь яаж багасах юм бэ? Хэдий хувиар багасах вэ? Дандаа тэгээд яг ийм ялыг өгөх үү? Гэмт хэргүүд чинь их олон янз л байгаа л даа. Үйлдэгдэж байгаа тэр орчин орчин нөхцөл нь.

Бид яг л нэг л юмаар ингээд ойлгоод байж болохгүй. Тэр нарийн ширийнийг нь сонсоод байдаг. Яг одоо энэ юм юундаа байна? Яллаж байгаадаа байна уу? Тэр шүүхээс гаргаж байгаа шийдвэртээ байна уу? Эсвэл одоо энэ Эрүүгийн хуульдаа байна уу гэсэн ийм зүйлийг л асуумаар байна.

Д.Цогтбаатар: Хэн хариулах вэ? Д.Мөнх-Эрдэнэ зөвлөх. 2 дугаар микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Энэ хуулийн төсөлтэй холбогдуулаад Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан бэлтгэсэн байгаа.

Энэ тайлан дээр яг таны асуугаад байгаа энэ ялын бодлогын зөрүү, ял оноож байгаа байдал гэх мэт.

Тэгээд бас гаднын улсын жишиг гэж харьцуулж судалсан байгаа.

Ингээд үзэхээр 2002 оны Эрүүгийн хуулийн энэ бага насны хүүхдийг алах, хүчиндэх гэмт хэрэгт оногдуулж байсан ялын бодлого 2015 оны Эрүүгийн хуулийн бодлогыг харьцуулаад үзэхээр ялын бодлого багасаж зөөлөрсөн байгаа юм.

Жишээ нь, хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах хорих ялын доод хэмжээ 2 жилээр, хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн тохиолдолд оногдуулах хорих ялын доод хэмжээ 3 жилээр, дээд хэмжээг 5 жилээр тусгаж багасгасан байгаа.

Тэгээд цаазаар авах ялыг халж, онцгой энэ ялын оронд бүх насаар хорих ялыг оруулж ирсэн байгаа.

Ингээд бага насны хүүхдийг алах гэмт хэрэгт оногдуулж байсан ялын бодлого, шүүхээс сэргийлж байсан ялын бодлого гээд харахаар 2002 оны Эрүүгийн хуулиар дунджаар 22.2 жилийн хугацаагаар хорих ял, эсхүл цаазаар авах ял оногдуулж байсан бол 2015 оны Эрүүгийн хуулиар дунджаар 14.2 жилийн хугацаагаар хорих ял оногдуулж ялын бодлого 7.9 жилээр суларсан ийм дүнтэй байгаа.

Эсрэгээрээ түрүүн бас асууж байсан. Энэ ялын бодлоготой холбогдуулаад ингээд харахад энэ жишээ нь, бага нас.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Яах вэ, гүйцээгээд хариулах уу? 2 дугаар микрофон өгье.

Д.Мөнх-Эрдэнэ: Ингээд статистик тоон мэдээллийг харахад жишээ нь, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг 2015 оноос хойш тогтмол өссөн байгаа.

-2015 онд 54,
-2016 онд 63,
-2017 онд 79,
-2018 онд 111,
-2019 онд 122,
-2020 онд 105,
-2021 онд 147,
-2022 онд 184 гээд энэ гэмт хэргийн тоо өсөж байгаа.

Дээр нь бас нэг онцгойлж хэлэх зүйл бол энэ өмнө нь ял шийтгүүлсэн хүмүүсээс 2020, 2021 оны статистик мэдээллийг харахад **68** хүн энэ хэргийг дахин үйлдсэн байдаг. Ийм статистик тоон мэдээллүүд байгаа.

Товчхондоо хэлэх юм бол 2002 оны Эрүүгийн хууль, 2015 оны Эрүүгийн хуулийг харьцуулаад үзэхэд бага насны хүүхдийн эсрэг үйлдэж байгаа саяын хэлсэн онц хүнд гэмт хэргүүдийн хувьд ялын бодлого суларсан байна. Эсрэгээрээ энэ гэмт хэргийг үйлдэж байгаа тоо өссөн байна гэсэн ийм статистик тоон мэдээллүүд байгаа.

Д.Цогтбаатар: Хоёр удаа л болно шүү дээ. Та нэг тодруулчихсан. Одоо хоёр дахиа тэгвэл тодруулчих.

Д.Ганбат: Та нар мэргэжилтнүүд. Бид энэ хуулийг сайжруулаад, бас үр

дүнтэй ийм байлгах хэрэгтэй л дээ. Нэгэнт хэлэлцэж ярилцаж байгаа учраас.

Тэгэхээр би ийм юм хэлэх гээд байна. Ял, ялын бодлого чангаруулах нь зөв байх. Чангаруулснаараа үр дүн нь ямар байх юм? Гэмт хэргийн илрүүлэлт чинь багасах уу?

Энэ чинь одоо тэгээд гэрчийг устгадаг, бүр хүнд байдалд ордог, илрэхгүй болдог.

Сая тоо нь ингээд нэмэгдээд байсан байна шүү дээ. Тэр тоо нь нэмэгдээд байна гэдэг чинь энэ хэргүүд чинь ил гараад байсан байхгүй юу. Тэр хүмүүс нь бас шийтгэлээ авч байна гэсэн үг. Нэг талдаа.

Тэгэхгүйгээр одоо наадах чинь бүгд далд ороод нөгөө архины хуурай хууль гэдэг шиг ингэж эсрэгээрээ үйлчилдэг юм болох вий.

Тэгээд хохирсон хүнийг, хохирсон бага насны хүүхдүүдийг бүр алдаг, гэрчийг үлдээдэггүй болгодог ийм зүйл рүү явуулах вий.

Орчин тойронд нь байсан хүмүүсийг устгадаг. Энэ дээр хүрээлэн ингэж мэдээлсэн байна. Энэ тэр гэж хандаж болохгүй. Та нар.

Зүгээр нэг өдөр нэг сайд ч юм уу, нэг Засгийн газар нь олон түмний бухимдлыг дарахын тулд бүх юмыг чангаруулаад байж болохгүй ээ. Чангаруулах юмаа чангаруулж, гэмт хэргийн илрэлтийг ил болгох энэ нөхцөл байдлыг байлгах ёстой шүү дээ.

Зөвхөн энэ дээр биш. Бусад асуудлууд дээр ч гэсэн гэж хэлэх гээд байгаа юм л даа. Би.

Д.Цогтбаатар: 4 дүгээр микрофон.

Б.Энхболд: Та бүгдэд өглөөний мэнд хүргэе.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос ажлын хэсэгт орж байгаа Б.Энхболд гишүүн байна.

Тэгээд Д.Ганбат даргын асуусан асуулт.

Ер нь эрүүгийн хариуцлагын цогц бодлогыг Хүний эрхийн Үндэсний Комисс дэмжиж байгаа.

Тэгээд яг энэ ялын бодлогыг бид цогцоор нь авч үзэж байж, эрүүгийн хариуцлагыг илүү их олон талаас нь авч үзэж байж энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх шинжлэх ухааны үндэслэл нь бүрдэх юм гэж харж байгаа.

Тэгэхээр энэ дээр нэг санал гаргах, бас анхаарч үзэх ёстой нэг зүйл бол энэ хүчиндэх гэмт хэргийг үйлдээд байгаа энэ хүмүүсүүдийн тоо жилээс жилд нэмэгдэж байгаа. Энэ хүмүүс өөрөө олон улсын жишиг, туршлагаараа гэдэг юм уу ямар нэгэн сэтгэцийн эмгэгтэй байх магадлал маш өндөр байдаг.

Энэ сэтгэцийн шинжилгээг хийж өнөөдөр Эрүүгийн хуульд байгаа эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ гэдэг энэ эрүүгийн хариуцлагын арга хэмжээг хорих ял оногдуулахын зэрэгцээ хэрэглэдэг энэ механизмыг бас суулгаж өгөх нь энэ эрүүгийн хариуцлагын бас тийм олон талт, үр нөлөөтэй, шинжлэх ухаанаар тогтоогддог ийм арга байгаа юм.

Тэгэхээр үүнийг анхаарч үзэхийг бас ажлын хэсэг, мөн Улсын Их Хурлын

гишүүдэд Хүний эрхийн Үндэсний Комисс санал болгож байгаа.

Дээр нь Эрүүгийн хуулийн ялыг урт болгож чангаруулснаараа урьдчилан сэргийлж чадна гэдгийг өнөөдөр бодитой шинжлэх ухааны судалгаа, дүгнэлтүүд гараагүй байгаа учраас үүнийг бас их болгоомжтой авч үзэх нь зүйтэй юм болов уу гэдгийг зориуд тэмдэглэхийг хүсэж байгаа юм.

Д.Цогтбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ажлын хэсгээс.

Одоо ингээд санал хураалтдаа оръё.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эхэлъе.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналуудын томъёоллыг уншиж танилцуулья.

1 дүгээр зүйл.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.10 дугаар зүйлийн 10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн энэ хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 12.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 13.1 дүгээр зүйлийн 2.1-д заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхэлнэ.” гэсэн томъёоллоор санал хураалт явуулья.

Санал хэлэх үү? Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгъе.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны дарга энэ “12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг” гэснийг “12 дугаар зүйлийн 2.1, 3.2 дахь заалт гэж өөрчлөхөөр илүү нарийн тодорхой болгож оруулж ирэхээр ингэж өөрчлөх саналыг оруулж байна.

Насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн энэ хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 12.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг гэж байгаа.

Тэгвэл тэрийг “12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2.1, 3.2 дахь заалт” гэж бүр тодруулаад. Тэгээд 13.1 дүгээр зүйлийн 2.1-д заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг 18 насанд хүрсний дараа тоолж эхэлнэ гэдгээр.

Д.Цогтбаатар: Энэ чинь ажлын хэсгийн ахлагч өөрөө оруулж ирсэн томъёолол дээрээ тодотгол хийж байна шүү дээ.

Тэгэхээр би таны хийсэн тодотголтойгоор тэгвэл уншаад тэгээд санал хураалтаа явуулчихъя. Тэгэх үү. Тэгвэл би эхнээс нь уншлаа шүү.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.10 дугаар зүйлийн 10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн энэ хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 12.3 дугаар зүйлийн 2.1, 3.2 дахь заалт, 13.1 дүгээр зүйлийн 2.1-д заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхэлнэ.” гэсэн ийм томъёоллоор санал хураая.

Тэгэхдээ би нэг зүйл Б.Батцэрэн шүүгчээс санал хураахын өмнө асуумаар байгаа юм.

Энд хөөн хэлэлцэх хугацааг ингээд 18 насаар зогсоогоод, хохирогчийг 18 нас хүрсний дараа тоолж эхэлнэ гэдэг чинь хохирогч тэрнээс өмнө гомдлоо гаргах эрх нь нээлттэй байгаа юм байгаа биз дээ? Өөр ямар нэгэн эрх зүйн зөрчил энэ дагуулахгүй байгаа биз?

5 номерын микрофон өгье.

Б.Батцэрэн: Тийм. Яг таны хэлснээр 18 насанд хүрээгүй хүн энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд гомдол гаргах эрх нь хэзээ ч нээлттэй байна.

Гэхдээ энэ хүүхдүүд өөрсдөө энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсноо ойлгоогүй, эсвэл бусдын хууль бус нөлөөлөлд автаж гомдол гаргахгүй байх, сэтгэл зүйн хувьд, оюун санааны хувьд тэр гомдол гаргах эрх зүйн тэр бүрэн чадамжтай болох хүртэл нь хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг нь зогсоож хойшлуулдаг ийм зохицуулалт бусад оронд байдаг. Энэ жишгийн дагуу энэ томьёолол орж ирж байгаа.

Гэхдээ энд нэг зүйлийг анхаараасай гэж хүсэж байна. Жишээлбэл, 12.1.4 гэдэг бол одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар бага насны хүүхдийн эсрэг хүчиндэх гэмт хэрэг. Энд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолдоггүй.

Гэтэл энэ яагаад 12.1.4 ороод ирж байна вэ гэхээр энд шинээр зүйл, хэсэг нэмэхээр хүндрүүлэх бүрэлдэхүүнүүд нь доошоо ингээд гүйгээд байгаа юм.

Тэгэхээр техникийн хувьд би энэ 12.1.4 гэдгийг ингэж гүйлгэхгүйгээр

шинээр томьёолох гэмт хэргээ тэр 12.1.5 гэж томьёолж явах нь зүйтэй байх гэсэн санал оруулж байна.

Тэгэхгүй бол 12.1.4-т шийтгүүлсэн маш олон хүн байгаа. Ингээд энэ хүмүүсийн хэрэг чинь шинэ хуулиар 12.1.5 болчих юм байна.

Тэгэхээр энэ хүмүүсийн эрх зүйн байдалд энэ цаашдаа нөлөөлнө. Одоо ялын тэгшитгэл хийх ч юм уу, эсвэл хугацаанаас өмнө суллах асуудлыг шийдвэрлэх дээр их хүндрэлүүд гарах байх.

Тийм болохоор энэ 12.1.4 буюу бага насны эсрэг үйлдэгдсэн хүчингийн хэрэг өмнө нь ч, одоо ч, ирээдүйд яг энэ зүйл, хэсгээрээ тогтвортой ингэж нэрлэгдэж явах нь хууль зүйн техникийн хувьд зүйтэй болов уу гэж бодож байна.

Хөөн хэлэлцэх хугацаа тоолоход бид 3 жил гэдэг ийм шинэ зохицуулалтыг оруулахдаа дунд нь оруулаагүй. Дунд нь оруулах юм бол бүгд гүйчих гээд байсан учраас хуулийн тэр зүйл 1.10-ынхаа хамгийн сүүлд аваачаад хийчихсэн.

Ингэснээрээ тийм хүндрэлүүд практикт гарахгүй байдаг. Үүнийг Та бүхэн маань бас нэг харгалзаж үзээсэй гэж хүсэж байна. Тийм.

Д.Цогтбаатар: Б.Батцэрэн шүүгч ээ, энэ чинь одоо би үүгээр ингээд уншаад.

Та одоо энэ дээр чинь юм оруулж болохгүй болчихоод байна шүү дээ. Ажлын хэсэг маань өөрсдөө оруулж ирчхээд ийм юм. Гишүүдээс эсвэл санал оруулж ирэхгүй бол би наадхыг чинь таны саналаар энд оруулж санал хураалгаж болохгүй болчихоод байна шүү дээ.

Д.Мөнх-Эрдэнэ зөвлөх. 2 дугаар микрофон өгье.

Д.Мөнх-Эрдэнэ: Энэ дээр нэг тайлбар хэлэх гэсэн юм.

Энэ Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй гээд Эрүүгийн хуулийн ерөнхий анги дээр зачихсан байдаг. Тэгээд яадаг вэ гэхээр яг тухайн үед үйлчилж байсан Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, заалтыг хэрэглэж явдаг.

Тэгэхээр тухайн, одоо энэ сая жишээ дурдагдсан хүмүүсийн хувьд яг л энэ нэг хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдахаас өмнө мөрдөгдөж байсан Эрүүгийн хуулийн зүйл, заалтын дагуу ялаа авсан. Тэр ялынхаа дагуу ялаа эдлээд явж байгаа. Шийтгэлээ хүлээгээд явж байгаа.

Тэгэхээр одоо юу гэдэг юм зүйл, заалт ингээд нэмэлт, өөрчлөлт ороод, өнөөдөр 2023 онд нэмэлт, өөрчлөлт ороод 2024 оны 01 сарын 01-нээс мөрдөгдөж эхэллээ гэхэд энэ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн хуулийн зүйл, заалтын дагуу гэмт хэрэгт шийтгүүлсэн хүн тэр зүйл, заалтынхаа хүрээнд л ялаа эдлээд шийтгэлээ хүлээгээд явна.

Тэгэхээр айхтар зөрүү гарахгүй ээ гэдгийг бас хэлье. Энэ бол угаасаа 2002 оны Эрүүгийн хуулиар тухайн үед хүчин төгөлдөр үйлдэгдэж байсан хуулийн дагуу гэмт хэрэг үйлдээд ял шийтгүүлээд явж байгаа хүн тухайн хуулийнхаа л зүйл, заалтын хүрээнд л хэрэглэгдээд явж байгаа шүү дээ. Тэнд чинь шал өөр дугаарлалт, шал өөр зүйл, заалт хэрэглэгдээд явж байгаа.

Д.Цогтбаатар: Тэгэхдээ Д.Мөнх-Эрдэнэ зөвлөх өө, өөрийн чинь ярьж байгаа ийм нарийн асуудал дээр бараг

зөрүү гарахгүй гэдэг наад үг чинь намайг жинхэнэ болгоомжлуулж байна шүү.

Наадах чинь нэг хүнд юун бараг байтугай. Нэг хүн дээр наад асуудал чинь гарах юм бол энэ чинь асуудал байхгүй юу.

Тэгэхээр бараг гэдэг бол үнэхээр юу биш.

Гэхдээ одоо яалт ч үгүй та нар ажлын хэсэг дээрээ ийм томъёоллолтой Б.Батцэрэн шүүгчээ оруулаад ирчихсэн. Энд чинь би өөр гишүүд санал оруулж ирэхгүй бол үүгээр нь хураалгахаас өөр үг алга.

Гэхдээ ажлын хэсгийн даргад хандаж хэлэхэд энэ дээрээ дараагийн хэлэлцүүлэг дээр тэгвэл хэдүүлээ энэ юмнуудаа бас нэг харъя. Тэгэх үү? Яг үүгээр санал хураалт явуулъя. /алх цохив/

Нийт гишүүдийн 73.3 хувь нь дэмжсэнээр энэ санал дэмжигдлээ.

Дараагийн томъёолол.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.12 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “2,” гэснийг хасаж, “22 дугаар бүлэгт” гэснийг “22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт” гэж өөрчлөх. Санал хураалт. /алх цохив/

Нийт оролцсон гишүүдийн 73.3 хувь дэмжиж, энэ санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн [2 дугаар зүйл](#)-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Ц.Мөнх-Оргил гишүүнээр тасаллаа. Ц.Мөнх-Оргил гишүүнд микрофон өгье.

Ц.Мөнх-Оргил: Ганцхан товчхон асуулт байна.

Энэ тээврийн хэрэгсэл жолоодоод зөрчил гаргаад, хэрэг хийгээд байгаа хүмүүст ял чангаруулах нь зөв л байх л даа. Зөв л дөө. Ер нь.

Энэ дээр “тээврийн хэрэгслийг хураах шийтгэл” гэж ер нь байдаггүй билүү? Тийм юм ер нь та хэд бодол уу, бодоогүй билүү? Одоо энэ хэрэглэж байгаа юм байна уу?

Бусад оронд яг тэр хэрэг үйлдсэн техникийн хэрэгслийг нь хураах, өмч хураах чинь бас их тийм том сигнал дохио болж байгаа шүү дээ.

Энэ дээр нэг товчхон тайлбар өгөөч. Би эсвэл дутуу хараад байна уу?

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хариулъя. Хэн хариулах вэ? Тээврийн цагдаагаас хариулах уу? Хэн хариулах вэ? Д.Мөнх-Эрдэнэ зөвлөх. 2 дугаар микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Ц.Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя.

Ер нь яг манай төсөл дээр яг энэ асуудал тусгагдаагүй. Зүгээр бусад Эрүүгийн хуульд заасны дагуу бас энэ гэмт хэрэг үйлдсэн эд зүйлийг хурааж авдаг ийм шийтгэл, албадлагын арга хэмжээ байгаа.

Тэгэхээр манай яг энэ төсөл дээр бид энэ асуудлыг тусгаж оруулж ирээгүй.

Д.Цогтбаатар: Б.Батцэрэн шүүгч түрүүн хариулъя гээд тэгж байсан. 5 дугаар микрофон.

Б.Батцэрэн: Тэгэхээр эрүүгийн хариуцлагыг дотор нь “ял”, “албадлагын арга хэмжээ” гэж хоёр хувааж байгаа.

Албадлагын арга хэмжээний нэг төрөл нь “хөрөнгө хураах”. Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд хувьчлагдсан.

Гэмт хэрэг үйлдэхэд ашигласан хэрэгсэл, мөн тээврийн хэрэгслийг хураах ийм зохицуулалт бий.

Энэ бол бүх төрлийн хэрэг дээр баримталдаг ийм хэм хэмжээ.

Энэ хөрөнгө хураах асуудлыг зохицуулсан энэ зохицуулалтыг боловсронгуй болгохоор Хууль зүйн яамны дэргэдэх байнгын ажиллагаатай ажлын хэсэг томъёоллоо бэлдчихсэн байгаа. Тэр одоогоор өргөн баригдаагүй байгаа байх.

Яг энэ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон. Ингэхдээ бусдад эрүүл мэндэд болон эд хөрөнгөд хохирол учруулсан хэргийн хувьд тээврийн хэрэгслийг нь хурааж байсан тохиолдол байхгүй.

Зүгээр шүүхийн практикт тэр хохирлыг нь нөхөн төлүүлэхийн тулд тээврийн хэрэгслийг нь хохиролд оруулан тооцож худалдан борлуулж үнийг тэр хохирогчид шилжүүлэх ийм шийдвэр гарч байсан тохиолдлууд бий.

Д.Цогтбаатар: Ц.Мөнх-Оргил гишүүнд тодруулах боломж өгье. Ц.Мөнх-Оргил гишүүний микрофоныг.

Ц.Мөнх-Оргил: Байнгын ажиллагаатай ажлын хэсэг гэдэг чинь нөгөө Хууль зүйн яаман дээр ажиллаж байгаа ажлын хэсгээ яриад байна шүү дээ? Тийм ээ.

Хэрвээ тийм санал бэлэн байгаа бол Б.Энхбаяр сайд ээ, энэ согтуугаар, эсвэл мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодоод бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан бол, тэгээд төсөл чинь бэлэн байгаа, судалгаа чинь бэлэн байгаа бол тээврийн хэрэгслийг нь хураадаг, улсын орлого болгодог, эсвэл тэр хохирогчид нь хохирлыг нь барагдуулж олгодог зохицуулалт санаачлаад оруулаад ирмээр юм биш үү.

Наадах чинь том хөшүүрэг болно шүү дээ. Би нэг торгуулаад, эсвэл баривчлагдаад өнгөрөхгүй юм байна.

Ер нь өмч хөрөнгөөсөө ч салах юм байна гэдэг чинь олон хүнд сигнал дохио болж согтуугаар машин барих сонирхлыг нь бууруулна даа.

Ер нь машин барих эрхийг бид тийм хүний эрх гэж ойлгоод байх шиг байгаа юм. Энэ бол давуу эрх шүү дээ. Үүнийг Хууль зүйн яам, манай Хүний эрхийн комисс сайн сурталчилмаар байгаа юм.

Энэ төрөөс олгож байгаа давуу эрх байгаа байхгүй. Бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй өндөр эрсдэлтэй нарийн механизмыг жолоодох эрх авна гэдэг чинь маш том давуу эрх эдэлж байгаа юм. Бусдын өмнө.

Тэгээд давуу эрх эдэлж байгаа бол илүү хариуцлага хүлээх ёстой. Өөрийнхөө өмч хөрөнгөөрөө ч хариуцлага хүлээх ёстой, эрх чөлөөгөөрөө ч хариуцлага хүлээх ёстой,

хөрөнгө мөнгөөрөө ч хариуцлага хүлээх ёстой.

Тэгээд энэ талаас нь нэг сайн ойлгуулаад өгөх юм бол энэ тал талаасаа. Ер нь нийгэм дэмжинэ. Тэгээд үүнийг давуу эрх юм байна гээд ойлгочих юм бол тэр согтуугаар машин барьж байгаа хүн ч гэсэн би бол ер нь эрхээ эдэлж байгаа юм биш юм байна шүү, би давуу эрх эдэлж байгаа юм байна шүү гэдэг ойлголттой хандах юм бол хандлага их өөрчлөгдөх болов уу гэж бодоод байна.

Тэгээд би тийм санал хэлж байна. Б.Энхбаяр сайдад тийм хуулийн төсөл боловсруулаад ороод ирэх юм бол манай Байнгын хороо дэмжихэд би хувьдаа жишээ нь дэмжихэд бэлэн байна шүү.

Д.Цогтбаатар: Саяын саналыг Б.Энхбаяр сайд аа, та нар бас бодоод үзнэ биз.

Ярилцаж байх үед би ч гэсэн энэ тээврийн хэрэгслийг нь ер нь хураадаг болох. Ялангуяа ийм ноцтой зөрчил гаргаж байгаа тохиолдолд хүн хаширч байж л хаширдаг байхгүй юу.

Өөрийнх нь биш бол тэгээд хураах ямар ч боломжгүй шүү дээ. Тийм. Тэгэх юм бол бусад хуулиараа хариуцлагаа хүлээгээд л явчихна. Бусад заалтаараа.

Энэ дээр зарчмын зөрүүтэй өөр санал байхгүй учраас [3 дугаар зүйл](#) рүү орёе. 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Гишүүд санал өгөх гишүүн алга байна. Асуулт асуух гишүүн.

Тэгвэл би томьёоллоор нь юу яачихъя уншаад явчихъя.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 12.1 дүгээр зүйлийн 3 дахь

хэсгийн 3.8, 3.9 дэх заалтыг хасаж, 5 дахь хэсэг, Тайлбарын “арван дөрвөн насанд хүрээгүй хүний” гэснийг “бага насны хүүхдийн” гэж өөрчлөх.

Санал хураалт явуулъя. /алх цохив/

Гишүүдийн 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир гишүүн дэмжсэн. Механизм нь ажиллаагүй байна. Тэгэхээр дэмжсэнд бүртгэж аваарай.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг хасах. Санал хураалт. /алх цохив/

Энэ санал дэмжигдсэнгүй. Тийм. Гишүүд ээ, та нар ойлгож байгаа. Тийм ээ.

Энэ чинь ингээд өргөн барьсан төслөөрөө үлдэж байна шүү.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 27.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хэрэгслийн жолооч” гэснийг “хэрэгслийг жолоодох эрхээ хасуулсан хүн” гэж өөрчлөх.

Энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

60.0 хувиар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн томъёолол руу орёе.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалтын 27.10 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Энэ” гэсний дараа “зүйлийн 3 дахь хэсэгт заасан” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай дараах Тайлбар нэмэх:

“Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй хүн” гэдэгт тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх аваагүй, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан, тээврийн хэрэгсэл жолоодох эрхтэй боловч тухайн ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй хүнийг ойлгоно.

“Тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн” гэдэгт согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн үйлдлийн улмаас тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүнийг ойлгоно.

“Тээврийн хэрэгсэл” гэж механикжсан тээврийн хэрэгслийг ойлгоно.”

Дэмжье гэсэн томъёололтойгоор санал хураалт явуулъя.

Санал хураалтыг түр хойшлуулъя.

Ц.Мөнх-Оргил гишүүн асуулт асууя гэж байна. Ц.Мөнх-Оргил гишүүнд микрофонд өгье.

Энэ санал хураалт хүчингүй шүү.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ “тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй хүн”, эсвэл “тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн” ингээд машин бариад яваад байна шүү дээ. Аваар хийхгүй ч байж болно, хийсэн ч байж болно.

Энэ хүн эрхгүй, эсвэл эрхээ хасуулсан хүн машин бариад яваад байна гэдэг чинь согтуу хүнтэй ер нь ялгаа

байна уу? Мансуурсан хүнээс ялгаа байна уу?

Тэгээд энэ дээр Б.Энхбаяр сайд аа, ял жоохон чангарах ёстой юм биш үү?

Одоо тэгээд торгуулаад л өнгөрчихдөг. Тэгээд сүүлдээ энэ чинь явсаар байгаад эрхгүй, тэгэхдээ согтуугаараа машин бариад явах, эрхтэй согтуугаараа машин бариад явах хоёрын хооронд ер нь ялгаа гарах юм уу?

Яг адилхан согтуурсан, мансуурсан гэдэг. Өөрөөр хэлбэл бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд адилхан л аюул учруулж байна шүү дээ. Тэр талаас нь оруулах бололцоо байхгүй юу?

Үүнийг хоёрдугаар хэлэлцүүлгийн үеэр ярих бололцоо байна уу? Манай ажлын хэсгийнхэн саналаа хэлээч.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр гишүүнд микрофон өгье.

Б.Энхбаяр: Ц.Мөнх-Оргил гишүүний хөндөж тавьж байгаа энэ асуудлыг, хуулийн төслийг өргөн барихын өмнө Засгийн газар дээр нэлээн ярьсан.

Зарим нь ерөөсөө энэ “тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд”, эсвэл “эрхээ хасуулсан этгээд” тээврийн хэрэгсэл жолоодохыг гэмт хэрэгт тооцёе буюу Зөрчлийн хуулиас авч гэмт хэрэгт бичье гэдэг саналыг бас гаргаж байсан юм.

Миний хувьд энэ дээр нэлээн тийм тооцоо, судалгаатай хандахыг хичээж хойш нь тавьсан.

Таны ярьсан асуудал дээр тийм ч, үгүй ч гэдэг байдлаар хариулт өгөөгүй. Яагаад гэхээр энэ дээр Хууль зүйн яамны

дэргэдэх байнгын ажлын хэсэг дээр холбогдох тооцоо, судалгаа их бага байсан.

Тэгэхээр энэ дээр нэлээн тодруулга юмнууд хийх ёстой юм билээ.

Би бодсон. Манайхан чинь ингээд байна лээ шүү дээ. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг гэмт хэрэгт тооцёе гээд орж ирж байхад чинь үгүй ээ, хөдөө гадаа ер нь бараг бүгдээрээ л айраг цагаа уугаад л яваад байдаг юм шүү дээ. Ер нь яах гээд байгаа юм гэж яриад байгаа байхгүй юу. Бүгдийг нь шоронд хийх гээд байна.

Тэгээд ийм “эрхгүй этгээд”-ийг гэмт хэрэгт тооцёе гэвэл бараг хөдөө малчингүй болно шүү дээ гэж ярьж мэдэх юм билээ. Хүүхдүүд чинь бүгд мотоцикл бариад хониндоо явдаг юм шүү дээ. Бүгд приусээрээ бараг ингээд явдаг болчихсон шүү дээ гэж ярих юм билээ шүү. Бас нэг талаас.

Тэгээд энэ дээр би бол үүнийг өөгшүүлж байгаа гэдэг утгаар яриагүй.

Ерөөсөө энэ дээр бас нэг тооцоо, судалгаа хийж авч үзье. Бид өргөн барьсан төсөл дээрээ “эрхгүй этгээд” буюу “эрхээ хасуулсан этгээд” 4 дэх удаагаа баригдвал “гэмт хэрэгт тооцох”-оор оруулж ирсэн байгаа. 4 дэх удаадаа “гэмт хэрэгт тооцох”-оор.

Эхлээд барингуут торгоно. Зөрчлийн хуулиар. 2 дахиар нь дахиад торгуулийг нь бүр нэмээд торгочихно. 3 дахь дээр нь шууд 30 хоног баривчилна. 3 дахиа баригдвал 30 хоног баривчилгаанд орно. 4 дэх дээрээ гэмт хэрэгт тооцно гэдэг ийм хувилбараар хуулийн төслөө оруулж ирсэн байгаа.

Тэгээд яг энэ зарчмаар хэлэлцэгдээд явж байгаа энэ асуудал.

Д.Цогтбаатар: Ажлын хэсэг Б.Батцэрэн шүүгчид 5 дугаар микрофон.

Б.Батцэрэн: Б.Энхбаяр сайдын сая танилцуулсан томьёолол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийн томьёолол байгаа юм.

Үүнийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар бас хэлэлцсэн.

Ингээд согтууруулах ундаа хэрэглэсэн хүн анх удаа ийм зөрчил гаргасан нь тогтоогдвол шууд гэмт хэрэгт тооцох саналыг бас нэг эргэн хараад. Эхлээд Зөрчлийн тухай хуулийнхаа тэр хэрэгслийг ажиллуулъя. Тэгээд энэ үйлдэл нь байнгын шинжтэй байх юм бол гэмт хэрэгт тооцдог байвал яасан юм бэ. Одоо гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй яг адилхан.

Урьд нь Зөрчлийн тухай хуулиар энэ зөрчилд нь арга хэмжээ авна. Энэ нь өөрөө байнгын шинжтэй байх юм бол гэмт хэрэгт тооцдог байх энэ зарчмаар өөрчилбөл яасан юм бэ гэсэн ийм санал хууль санаачлагчид хүргүүлсэн.

Өчигдөр дэд ажлын хэсэг хуралдаад энэ асуудал дээр зарчмын нэг ийм саналын томьёолол бэлтгэсэн юм.

Энэ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд хүлээлгэх хууль зүйн хариуцлагыг чангатгая.

Ингэхдээ “эхлээд торгодог, эрхийг нь хасдаг биш”, “эхлээд шууд баривчилдаг, эрхийг нь хасдаг” ийм байдлаар Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд өөрчлөлт оруулъя гэдэг ийм томьёолол бэлтгэсэн.

Ингээд энэ эрхээ хасуулчихсан хүн эрх нь сэргэгдээгүй байхад дахиад согтууруулах ундаа хэрэглээд тээврийн хэрэгсэл жолоодох юм бол үүнийг харин гэмт хэрэгт тооцож Эрүүгийн хуулийн 27.10 дугаар зүйлд томьёолъё гэж ийм нэгдсэн шийдэлд хүрээд ингээд саналын томьёолол бэлтгэж Та бүхэнд танилцуулахаар оруулсан байгаа.

Д.Цогтбаатар: Тэгэхээр саяын асуултад хариулт өгчихлөө.

Д.Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Үгүй ээ, энэ чинь одоо Д.Ганбат ажлын цаг дууссаны дараа айраг уугаад явж байгаа биш шүү дээ. Энэ ордон дотор. Тэр бол өөр хэрэг.

Энэ малчин айраг ч ууж болно, архи ч ууж болно, тэгээд мотоциклоо унаж болно гэсэн тийм юм байж болохгүй ээ.

Б.Энхбаяр сайд бид хоёр жаахан маргалдаж байсан юм. Энэ талаар. Тийм ээ. Тийм юм байхгүй ээ.

Тийм л шаардлагатай морио унаад явж болно шүү дээ. Сонголт байгаа байхгүй юу. Тийм. Үхэр тэргээ унаад явж болно, морио унаад явж болно.

Түүнээс биш мотоциклоо унаад, тэр приусээ бариад, тэр үедээ тэр айргаа ууж болно, архиа ууж болно гэсэн юм байхгүй шүү дээ.

Үүнийг нэг мөр шийдэж өгөхгүй бол ийм утгаараа та нар ч яриад байдаг, мэргэжилтнүүд, шүүхийнхэн, манай Засгийн газар ч ингэж яриад байж болохгүй ээ.

Ерөөсөө болохгүй гэдгийг нь л хэлээд өгчих хэрэгтэй. Хөдөө нэг болдог,

энд нэг болдог. Эхлээд уучхаад, дараа нь үргэлжлүүлчихвэл ингээд шат дараатай юм шиг. Тийм ээ. Ингэж явах нь болохгүй шүү дээ. Харин тийм. Тэгээд шийтгэх л ёстой шүү дээ. Үнэмлэхгүй байвал улам шийтгэх ёстой.

Тэр гэр бүлийн хүчирхийлэл дээр гэхэд чинь бас тэр хамгаалах ёстой ойр дотнын хойд эцэг нь хүчирхийлэл бүр хатуу байх ёстой шүү дээ. Тийм.

Анхнаасаа та нар чинь нэг болох ч юм шиг. Тийм ээ. Хөдөө малчингүй болчихно ч гэх шиг. Тийм юм ярьж болохгүй шүү дээ. Морь нь байж л байна шүү дээ. Тийм.

Тэр морьтойгоо өөрөө мориноосоо чиргүүлдэж үхнэ үү тэр нь өөрийнх нь сонголт байхгүй юу. Тийм. Айргаа ууж байгаад.

Түүнээс биш приусээ унаад, мотоциклоо унаад хүнийг дайрч болно гэсэн юм байхгүй шүү дээ. Ингэж болохгүй ээ. Тэр дайрах магадлал нь ихэснэ шүү дээ. Тийм. Дайрч болохгүй. Тэгээд эхнээсээ болохгүй гэдгийг нь хэлчих. Тийм.

Д.Цогтбаатар: Д.Ганбат гишүүн ээ, сая Б.Батцэрэн гишүүн наад дээр чинь их тодорхой хариулчихлаа.

Засгийн газраас харин харьцангуй уян оруулж ирснийг яг таны ярьсантай адилхан энд чангаруулчихсан байна шүү дээ. Ажлын хэсэг яаж оруулж ирж байна гэхээр эхлээд л шууд баривчлах арга хэмжээ рүү ороод явчхаж байна шүү дээ.

Тэгэхээр ер нь бодлогын хувьд ч энэ нь зөв байх. Их Хурал дээр үүнийгээ ингэж чангал. Угаасаа гишүүдийн байр суурь ингэж гарч ирж байна шүү дээ.

Үүгээр санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор.

Ингээд хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Сая 3-аар санал хураачихсан юм байна.

Хуулийн төслийн [4 дүгээр зүйл](#)-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Б.Энх-Амгалан гишүүнээр тасалъя. Б.Энх-Амгалан гишүүнд микрофон өгье.

Б.Энх-Амгалан: Би энэ дээр хоёр юм тодруулах гээд байгаа юм.

Энэ согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох гэдэг дээр би түрүүн Ц.Мөнх-Оргил гишүүний хэлээд байдагтай санал нэг байгаа юм л даа.

Сүүлийн үед сэтгэцэд нөлөөлдөг эм, бодисын чинь тун их өөр болоод бараг л тэр жагсаалтууд нь их хурдан хурдан өөрчлөгдөөд байгаа байхгүй юу.

Тэгээд тэр жагсаалтад нь байхгүй эм, бодис хэрэглэчихсэн, эсвэл тэр мансууруулах эм тун нь өөр байдаг юм хэрэглэчихсэн.

Манайд одоо ингээд нөгөө Үндэсний хороон дээр байдаг жагсаалтаасаа өөр юм хэрэглэчихсэн байвал энэ сэтгэцэд нөлөөлөх эм, бодис, мансууруулах эм хэрэглэсэн гэж тооцогдох уу, тооцогдохгүй юу? Үүнийгээ бид яг яаж харах вэ?

Яагаад гэхээр би энэ дээр нэг ийм юм хараад байгаа юм. Согтууруулах ундаагаа хэрэглэсэн гэдгийг шалгуулагчийн амьсгал дахь спиртийн агууламж 0.20 хувийн промилл, цусан дахь спиртийн агууламж 0.5 хувийн промилл илэрснийг ойлгоно гэж байгаа юм.

Тэгвэл мансуурсныг яаж ойлгох вэ гэдгийг хэдүүлээ яаж тодорхойлох вэ? Үүнийг нэгдүгээрт нэг хармаар байгаа юм.

Хоёрдугаарт, хэлээд байгаа юм нь энэ давуу эрх эдэлж байгаа гэдгийг хэлээд байна шүү дээ. Яг үүнтэй адилхан давуу эрх олгож байгаа тэр нөгөө эрх эрх олгож байгаа байгууллагууд яах вэ? Жишээлбэл, жолооны курс.

Гэрлээ шилжүүлдэггүй, эгнээ байраа зөв барьдаггүй, хурд хэтрүүлдэг тийм жолооч нарыг бэлтгээд гаргачхаж байгаа. Тэгээд чадваргүй. Ийм жолооч нарыг бэлтгээд гаргачхаж байгаа, давуу эрх олгож байгаа тэр төрийн байгууллага дээр яах вэ гэдгийг хэдүүлээ бас нэг бодох л хэрэгтэй байгаа юм.

Тэгэхгүй бол чадвар муутай жолооч чинь за яах вэ, архи уудаггүй юмаа гэхэд. Энэ бол өөр асуудал л даа. Архи уудаггүй юмаа гэхэд чадвар муутай жолоочоос болоод, шахуулснаасаа болоод юм уу, эсвэл хурц гэрэл өмнөөс нь тавьж байгаад шилжүүлээгүйгээс болоод, эсвэл эгнээ байр буруу эзэлснээс болоод аваар осол гарч байгаа нөхцөл энэ гэмт хэргийн мэдээлэл дээр нэлээн байгаа гэдгийг бас энд хэлэх гээд байгаа юм.

Тэгээд энэ согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисынхоо жагсаалтыг яаж тодорхойлох вэ? Энэ дээр нэг хариулт өгөөч.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? В.Хосбаяр. 3 дугаар микрофоныг өгье.

В.Хосбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Тээврийн цагдаагийн Мөрдөн шалгах хэлтсийн дарга, дэд хурандаа В.Хосбаяр илтгэж байна.

Манай орон 1964, 1972 оны Мансууруулах эмийн тухай конвенцид нэгдэн орсон байдаг.

Тэгэхээр эдгээр конвенцоор нэгдэн орсон гэрээ хэлэлцээрийн дагуу Эрүүл мэндийн яамны мөн сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн жагсаалт гэж мөн байдаг.

Тэгэхээр энэхүү конвенц болон жагсаалтад орсон мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис болон эмийн нөлөөллийн жагсаалтад орсон эдгээр химийн элементүүдийг хэрэглэсэн байвал мансууруулах сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл хэрэглэсэн гэж үздэг.

Үүнийг бид өнөөдөр практикт яаж тогтоодог вэ гэхээр тухайн иргэний, тухайн этгээдийн биеэс, цуснаас биологийн дээж шинжилгээнд хүргүүлснээр Шүүхийн шинжилгээний ерөнхий газар шинжээчийн дүгнэлт гэж ирүүлдэг. Энэ дүгнэлтээр бид хэрэглэсэн асуудлыг нь тогтоож, мөрдөн шалгах ажиллагаа явуулсны үндсэн дээр дараагийн шатад шилжүүлдэг ийм журмаар шийдэгдэж байгаа.

Сая нэмэлтээр ингэж асууж байх шиг байна. Одоо өөр төрлийн бодис хэрэглэчихсэн байвал яах вэ гэж. Жагсаалтанд байхгүй.

Тэгэхээр энэ тохиолдолд яах вэ гэхээр тухайн өөр төрлийн бодис хэрэглэсэн асуудал дээр тухайн иргэний орчиндоо хэрхэн харьцаатай байгаа дээр нь эмнэлгийн байгууллагын нэгдүгээрт дүгнэлт гаргах.

Хоёрдугаарт, тухайн үйлдлийн улмаас ямар гэмт хэрэг, үйлдэл, ямар хор уршиг учирч байна вэ гэдгээр зүйлчилж байгаа.

Д.Цогтбаатар: Асуулт асууж, хариулт авч дууслаа.

Зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя.

8.Төслийн 4 дүгээр зүйлийн “5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хорин” гэснийг “хорин таван” гэж гэснийг, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “хорин тав” гэснийг “гучин” гэж,” гэснийг “10.1 дүгээр зүйлийн Тайлбарын “арван дөрвөн” гэснийг “арван зургаан” гэж” гэснийг, “12.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 2.1 дэх заалтын “арван дөрвөөс” гэснийг “арван зургаагаас” гэж, мөн зүйлийн” гэснийг тус тус хасах.

Үүгээр санал хураалт явуулъя. Энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор.

Ц.Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Горимын санал гаргах гэсэн юм. Би сая хоцроод кнопоо дарчихлаа. Дарга аа. Учлаарай.

Санал буруу гарсан учраас саяын саналыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргаж байна.

Д.Цогтбаатар: Саяын саналыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Манайхан анхааралтай саналаа өгөөрэй.

Г.Амартүвшин гишүүний микрофоныг өгье.

Г.Амартүвшин: Саяын санал хураалтыг хүчингүйд тооцож, дахиж санал хурааж өгнө үү.

Д.Цогтбаатар: Саяын энэ хүчингүй болгоё гэсэн саналыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Одоо түрүүний уншиж танилцуулсан үндсэн саналаараа дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйл-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Асуулт асуух гишүүд алга байна.

Төслийн 6 дугаар зүйл-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Алга байна.

Дагаж өргөн мэдүүлсэн хуулиудын асуудал орж ирж байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.

Төслийн 1 дүгээр зүйл-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Ц.Мөнх-Оргил гишүүнээр тасалъя. Ц.Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Хүний эрхийн Үндэсний Комиссынхоос л асуудаг юм уу даа. Өргөн барьчихсан Засгийн газраас үүнийг тодруулаад ч яах вэ.

Энэ их ноцтой юм орж ирж байна шүү дээ. Манай гишүүд үүнийг анхаарна биз дээ.

Торгуулиа хугацаанд нь төлөөгүй бол **“тусгай зөвшөөрөл”, “зөвшөөрөл хүсэх, сунгах”, “тендер шалгаруулалтад оролцох”, “төрийн жинхэнэ албаны шалгалт өгөх”, “үндэсний гадаад паспорт авах”, “тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах”, “ангилал нэмэх, өөрчлөх, шинээр авах”, “тээврийн хэрэгсэл эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эрх”**-ийг хязгаарлана гэж байгаа юм.

Мэдээж нэгэнт оноочихсон торгуулиа авах хэрэгтэй л дээ. Нөгөөдүүл нь ч төлөх хэрэгтэй.

Тэгэхдээ энэ чинь янз янзын шалтгаанаар жишээ нь торгох ялыг авчхаад нөгөө торгуулиа төлөөгүй байж болно шүү дээ.

Энэ талаас нь та хэд ярьсан, хязгаарласан юм хум байна уу?

Яах вэ, аж ахуйн нэгжийн хувьд, хуулийн этгээдийн хувьд яах вэ ямар

нэгэн байдлаар болдог юм байя гэж бодъё.

Гэтэл хувь хүний хувьд энэ чинь бас янз янзын л асуудал гарна шүү дээ.

Тэр тусгай зөвшөөрөл хүсэх нь ч яах вэ, тендер шалгаруулалтад оролцох нь ч яах вэ. Гэтэл төрийн албаны шалгалтад орох гээд байдаг. Гадаад паспортоо авах гээд байдаг. Жолооны эрхээ авах гээд байдаг. Сунгуулах гээд байдаг. Тэгсэн чинь чи торгууль төлөөгүй гээд.

Тэгэхээр үнэхээр төлбөр төлөх бололцоогүй болчихвол яах вэ гэх мэтийн юмнууд гарах л байх л даа.

Энэ дээр өөр хөшүүрэг байхгүй юм уу? Эсвэл хориглох гээд байгаа юмнуудаа жоохон хязгаарлах юм уу? Тендерээр, тусгай зөвшөөрлөөр хязгаарлах юм уу?

Манай Хүний эрхийн комиссынхон энэ дээр санал бодол байна уу?

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хэн хариулах вэ? М.Чинбат прокурор.

М.Чинбат: Ц.Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя.

Төсөл дээр саяын хэлдгээр зарим эрхийг хязгаарлахаар орж ирсэн юм. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль дээр торгох шийтгэлийг биелүүлэх ажиллагааг зохицуулсан зохицуулалтууд байгаа юм. Заавал энэ эрхэн дээр нь хүрч халдахгүйгээр.

Эрх бүхий албан тушаалтан торгох шийтгэл оногдуулснаар зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа дуусгавар

болоод 15 хоногийн хугацаанд. Тогтоосон хугацаандаа хуулиар 15 хоногийн хугацаа.

Энэ хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгэхээр эрх бүхий албан тушаалтан шүүхэд хүсэлт гаргах ёстой. Шийтгэл биелэгдээгүй тохиолдолд.

Шүүх энэхүү хүсэлтийг ажлын 2 өдрийн дотор шийдвэрлэж, албадан гүйцэтгүүлэхээр гүйцэтгэх хуудас бичиж, энэхүү биелэгдээгүй торгох шийтгэлийн биелэлтийг шийдвэр гүйцэтгэлийн журмаар барагдуулах ийм хуулийн зохицуулалт нь байгаа юм.

Тэгэхээр энэ хуулийн зохицуулалт өнөөдөр амьдрал дээр бүрэн хэрэгжүүлээгүйгээс болж энэ зохицуулалтыг арай өөр ажиллагаагаар ингэж хязгаарлахаар байгаа нь ойлгомжгүй л байдал үүсгэж байгаа юм л даа.

Тэгэхээр энэ хуулийн зохицуулалтаа бид өөрсдөө хэрэгжүүлэх ёстой гэдэг ийм байр суурийг илэрхийлж байгаа юм.

Д.Цогтбаатар: Хүний эрхийн комиссоос. Тийм. 4 дүгээр микрофон.

Б.Энхболд: Ц.Мөнх-Оргил гишүүний асуултад хариулья.

Нэгдүгээрт, өнөөгийн хүчин төгөлдөр хууль тогтоомжийн дагуу энэ торгуулийн арга хэмжээг шийдвэрлэх эрх зүйн орчин, механизмууд нь байгаа.

Үүнийгээ бүрэн ашиглаж чадахгүй байгаа гэдэгтэй санал нэгдэж байгаа. Үүний үр нөлөөг дээшлүүлэх ёстой гэдэг

дээр Хүний эрхийн Үндэсний Комисс байр сууриа илэрхийлж байгаа.

Бүр одоо энэ хязгаарлах үнэхээр зайлшгүй шаардлага үүнээс өөр арга хэмжээ байхгүй гэж үзэж байгаа бол тэр **“төрийн албанд шалгалт өгөх”**, **“гадаадад зорчих”**, **“гадаад паспорт авах”** зэрэг ер нь замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоогүй бусад харилцаа руу хязгаарлалт тогтоохыг Хүний эрхийн Үндэсний Комисс дэмжихгүй байгаа.

Ер нь яг үүнтэй бүүр нарийвчлаад тээврийн хэрэгсэлтэй холбоотой **“машины дугаар шилжүүлэх”**, **“шинээр тээврийн хэрэгсэл худалдаж авах”** гэдэг юм уу тэ энэ асуудлууд дээр хэр зэрэг хязгаарлалтыг тогтоох боломжтой вэ гэдэг дээр эргэж харах зайлшгүй шаардлага байгаа.

Өргөн хүрээнд тэр маш их хязгаарлалтуудыг Хүний эрхийн Үндэсний Комисс дэмжихгүй байгаа.

Д.Цогтбаатар: Ц.Мөнх-Оргил гишүүн тодруулья.

Ц.Мөнх-Оргил: Уг нь одоо байгаа механизмаа л бүрэн ашиглаж сурмаар.

Тэгээд тэнд болохгүй байгаа юмаа янзлах л асуудал байгаа юм л даа.

Тэгэхгүй ингээд төрөөс үзүүлж байгаа зөрчилтэй нь огт холбогдоогүй, хамаагүй үйлчилгээнүүд дээрээ хясан боогоод, тэгээд өөр төрлийн торгууль төлүүлэх гээд шахаад байх нь байгууллага, тэр хувь хүний цаана байгаа харилцаанд орж байгаа бусад олон этгээдүүд, ар гэрийнхэнд нь ч гэсэн энэ чинь хүндрэл учруулахаар зовлонтой л юм байна л даа.

Үүнийг хоёрдугаар хэлэлцүүлгийн үеэр ярьж байгаад хэдүүлээ дахиж ажлын хэсэг дээрээ нэг яриад, өөр ямар хувилбарууд байж болох вэ нэг ярья.

Одоо энэ чинь торгууль ноогдууллаа. Сая М.Чинбат шүүгч маш тодорхой хэллээ шүү дээ. Тийм ээ.

Торгууль ноогдууллаа. 15 хоногийн дотор төллөө. Төлөөгүй 2 хоногийн дотор шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж гарлаа. Тэгээд шийдвэр гүйцэтгэлийн журмаараа явж байна шүү дээ.

Энэ чинь төрийн механизм яг номоороо ажиллаад явж байгаа байхгүй юу. Дэс дараатай. Тэр эрхэд нь халдаагүй. Тэр зөрчил гаргасан юутай нь огт хамаагүй, эрхэнд нь халдахгүйгээр явж байгаа байхгүй юу.

Тэгээд би Хүний эрхийн комиссоос асуугаад байгаа нь энэ албадлагын арга хэмжээний шинж чанар нь Хүний эрхийн комиссынхны харж байх ёстой, хянаж байх ёстой, нүдний цөцгий мэт хамгаалж байх ёстой тэр үнэт зүйлстэй чинь нийлж байна уу, үгүй юу гэж асуугаад байгаа юм.

Мэдээж торгууль төлүүлэх бүхий л аргыг хэрэглэх нь зүйтэй л дээ.

Хоёрдугаар хэлэлцүүлгийн үед тал талаас нь хэдүүлээ сайн ярья.

Д.Цогтбаатар: Ц.Мөнх-Оргил гишүүний хэлж байгааг ажлын хэсэг анхаарах хэрэгтэй байх. Ялангуяа Хүний эрхийн комисс дэмжихгүй байна шүү дээ.

Тэгэхээр үүнийг нь бас бид бодолцож үзэх ёстой байх.

Миний зүгээс ажлын хэсгээс асуумаар нэг асуулт байна л даа. Жишээлбэл, одоо хэдүүлээ паспорт олгох юуг нь хязгаарлах гээд байна шүү дээ. Хүн паспортоо авах гээд очдог. Тэгсэн энэ дээр та ийм өртэй байна гээд. Та үүнийгээ төлөх ёстой гээд.

Тэгэнгүүт би төлчхөд тэр даруй миний паспорт авах эрх хурдан сэргэж чадах уу? Наад систем чинь тэгж хурдан ажиллах уу? Нэг хүн гадаад явах гээд л сандарчихсан амьтан очно шүү дээ.

Мэдээжийн хэрэг тэр торгуулиа төлөх ёстой. Би түүнд эргэлзэхгүй байна. Ямар нэгэн байдлаар төлүүлэх гэж та нар хичээгээд байгааг ойлгож байна.

Тэгэхдээ энэ дээр гарч байгаа асуулт чинь тийм байхгүй юу. Яг нэг хүн маргааш нисэх гэж байдаг. Тэгтэл торгуулиа тэр доор нь төлчихлөө. Тэгсэн нөгөө эрх нь сэргэж өгдөггүй. Паспортыг нь гаргаж өгөхгүй байх ийм нөхцөл бүрдэх юм биш биз дээ? Нэг асуудал.

Хэр хурдан буцаад ажиллагаандаа орох боломжтой болох вэ?

Хоёр дахь миний асуулт.

Ийм юм бодож болох уу? Би зүгээр чөлөөтэй сэтгэж байгаад асууж байна шүү.

Хэрэв одоо ингээд торгууль нь хуримтлагдсан хүн байж байлаа гэхэд бензин колонк дээр очоод бензин авах гэж байхад нь бензин авахдаа бид НӨАТ төлж байгаа шүү дээ. Тэр чинь төрийн татвар. Тэр бензин авахдаа төлж болоод байна. Тэр татварыг шатахуун түгээх станц төрийн өмнөөс авч өгөөд байна шүү дээ.

Тэгвэл түүнтэй адилхан танд ийм өртэй юм байна. Та үүнийгээ энэ дээр нэмээд төлчих гээд. Дараа нь шатахуун түгээх станцаасаа төр аваад байх тийм боломж байдаг уу?

Ажлын хэсгээс хэн хариулах вэ?
Д.Мөнх-Эрдэнэ зөвлөх. 2 дугаар микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Д.Цогтбаатар даргын асуултад хариулъя.

Бид хуулийн төсөл дээрээ яг таны хэлсэн, асуусан зүйл хөндөгдөж болзошгүй гээд эрх хязгаарлах эрх бүхий албан тушаалтан шүүх болон бусад байгууллагууд мэдээлэл солилцох журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтран баталсан журмаар зохицуулахаар оруулж төсөл дээр тусгачихсан байгаа.

Тэгэхээр яг ингэж юу гэдэг юм хүний эрхэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар хурдан шуурхай мэдээлэл солилцох энэ боломжийг журамлахаар төсөлд тусгачихсан байгаа.

Хэрвээ төсөл дэмжигдэх юм бол бид журам дээрээ нэлээн нарийвчлан тусгаж, төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох хурд, хугацаа, журмыг нэлээн нарийвчлан тусгана гэж тооцож оруулж ирсэн байгаа.

Д.Цогтбаатар: 2 дугаар микрофон тодруулъя.

Ц.Чинзориг: Тээврийн цагдаа. Дэд хурандаа Ц.Чинзориг.

Түрүүн М.Чинбат прокурорын хэлж байгаа асуудал нөгөө шийтгэл оногдуулж байгаа эрх бүхий албан тушаалтнуудыг зөрчлийн материал дээр

ялгаваршуулсан журмаар шийдэж байгаа зөрчлүүдээр яригдаж байгаа.

Торгуулиа авч чадахгүй байгаа асуудал 2013 оноос хэрэгжиж эхэлсэн бэлэн бус хэлбэрээр торгууль, шийтгэл оногдуулж байгаа хэлбэр.

Засгийн газрын тогтоол гарахдаа бэлэн бус хэлбэрээр шийдвэрт оногдуулахыг хязгаарлах заалт анхны тэр тогтоол дээр орсон.

Ингээд Хууль зүйн сайдын 2015 оны бэлэн бус хэлбэрээр торгууль, шийтгэл оногдуулах журам байгаа. Энэ журам дээр мөн адил яг энэ торгууль, шийтгэлийг биелүүлэхээр хязгаарлалтууд орсон.

Энэ дээр татвар, даатгал ч гэдэг юм уу хязгаарлалтуудыг оруулж өгсөн боловч 2021 онд шийтгэлийн болон шийтгэлийн хуудас чөлөөлөх маягт хэрэглэх журам гээд шинэ журам гарсантай холбоотой бэлэн бусын журам хүчингүй болчихсон.

Ингээд хууль эрх зүйн орчинд энэ торгууль төлөөгүй иргэдийн торгуулийг нь төлүүлэх энэ эрх зүйн орчин, хязгаарлалт юмнууд байхгүй болсноос болж одоо энэ оны эхний 10 сарын байдлаар бэлэн бус хэлбэрээр торгуулсан нь 26.5 хувьтай байгаад байгаа юм.

Тэгэхээр төрийн хязгаарлалтууд орж өгч байж энэ бас сахилгажих юм байна, хариуцлагжих юм байна, хугацаанаасаа хэтэрсэн тохиолдолд төлөх юм байна гэдэг ийм ойлголт байгаа юм.

Д.Цогтбаатар: Тэгэхдээ миний асуултад байна шүү дээ, Д.Мөнх-Эрдэнэ зөвлөх өө. Ийм болчхож байна шүү дээ.

Та нар яг паспортоо авах гээд амь тулчихсан хүн очиход торгуулиа тэр дороо хүн төлчхөөд паспортыг нь гаргаж өгч чадахааргүй юм ярьж байна шүү дээ. Яагаад гэвэл мэдээлэл солилцох юм яриад байгаа байхгүй юу.

Жишээлбэл, тэр паспортод хязгаарлалт хийлээ гэхэд тэр хүн төлбөрөө төлж очоод би төрийн энэ дансанд шилжүүлчихлээ гээд хэлэхэд шууд тэр хүний хувьд тэрийг нь аваад паспортыг нь гаргаж өгөх нөхцөл бүрдчихэж байгаа бол наадах чинь газар дээрээ шийдэгдэж байна гэсэн үг.

Тэгээгүй бол төлчихлөө гээд тэр нь дараагийн нөгөө одоо замын цагдаа дээрээ очоод тэндээсээ ногоон гэрлийг нь өгөөд тэгээд паспортыг иргэний бүртгэл мэдээллийн газар дээр ирнэ гэх юм бол яарсан зөндөө хүн авч чадахгүй юм байна гэсэн үг байхгүй юу.

Мэдээлэл солилцоо та яриад байна шүү дээ. Надад.

Тэгэхээр ингэх юм бол Ц.Мөнх-Оргил сайдын ярьж байгаа чинь зөв шүү. Наадах чинь жинхэнэ асуудал болоод гараад ирж байгаа юм.

Хоёр дахь асуултдаа би бас хариулт авмаар байна.

2 дугаар микрофон.

Д.Мөнх-Эрдэнэ: Д.Цогтбаатар даргын асуултад хариулъя.

Энэ торгууль төлөлттэй холбоотой мэдээлэл “e-mongolia” апп болон нийслэл дээр байгаа “smartcar” гээд апп дээр бүх мэдээлэл явж байдаг юм.

Уг нь бид мэдээлэл солилцох журам дээрээ тодорхой тусгаад торгууль

төлсөн тохиолдолд тэр чинь угаасаа бид апп дээрээ мэдээлэл нь оруулчгаж байгаа байхгүй юу. Ямар ч дурын хүн татаад харахад энэ хүн торгуулиа төлчихсэн гэсэн мэдээлэл гараад ирнэ.

Тэгэхээр яг энэ мэдээлэл оруулж байгаа, үүнийг харах гэж байгаа энэ юугаа л таны хэлж байгаа Гадаад хэргийн яамны паспорт олгож байгаа хүмүүс хардаг энэ зохицуулалтуудаа л хийчих юм бол.

Яг мэдээлэл солилцох нь, оруулах нь тийм их хэцүү удаан зүйл биш. Төллөө тэр мэдээлэл нь шууд л апп дээр нь гараад ирж байгаа. “Smartcar” аппликэйшн бараг 2018 оноос хойш 5 жил хөгжүүлчихсэн нэлээн сайн аппликэйшн болчихсон байгаа. E-mongolia дээр ч байж байгаа.

Тэгэхээр яах вэ, мэдээж эрсдэл, хүндрэл гарахыг үгүйсгэхгүй. Тэгэхдээ бид саяын энэ технологийн шийдлүүдийг ашиглаад журмаараа нарийвчлан зохицуулах боломжтой гэж харж байгаа.

Бензин авах. Таны хувийн хэвшлийг татаж оролцуулах боломжийн хувьд бид шууд болно, болохгүй гэж хэлэхэд түвэгтэй байна.

Ер нь хуульдаа тодорхой тусгаад, журамдаа ингэвэл бас огт болохгүй зүйл биш. Нарийн судалж байж танд эргэж хэлье. Тэгэхгүй бол хувийн хэвшилд үүрэгжүүлэх гэж байгаа учраас энэ шууд тэгнэ, ингэнэ гэж хэлэхэд. Судалж байж хэлье. Тэгэх үү. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Зөв зөв. Хувийн хэвшил дээр би ойлгож байгаа.

Гэхдээ хувийн хэвшил чинь НӨАТ-ыг чинь авч өгөөд байгаа шүү дээ.

Төрийн ажлыг хийгээд байгаа байхгүй юу. Тэртээ тэргүй.

Тэгэхээр тэр өнцгөөс нь бодоорой.

Д.Мөнх-Эрдэнэ зөвлөх өө, энд Н.Учрал сайд сууж байна. Н.Учрал сайд аа, нэг юмыг та нар маань бодоорой.

Би өөрөө яг биеэрээ үзсэн. Нотариат дээр очиж би гарын үсгийн юу авах гээд. Цаг хүлээгээд би авч чадалгүй явсан. Надад өгсөн хариулт нь. Яг ордны энэ хажууд шүү. Цахим e-mongolia-д манай энэ нотариатын бүртгэлийн үйл ажиллагаа шилжээд жил болж байна гэлүү, жил хагас болж байна. Та одоо болтол ойлгоогүй байгаа юм уу гээд.

Тэр хүн тэгснээрээ хурдан болох ёстой гэж ойлгоогүй. Тийм учраас ингэж удаж байгаа шүү дээ. Та одоо болтол үүнийг мэдээгүй байгаа юм юм уу гэсэн харцаар над руу харж байгаа байхгүй юу.

Тэгэхээр зарим юман дээр өөрөө аягүй гоёор сэтгээд байна шүү дээ. Тэгтэл үнэн хэрэг дээрээ наадах чинь жинхэнээрээ хүндэрчихсэн байгаа.

Би сая шүүхийн ажиллагаатай очоод танилцахад 14 платформ байна лээ. Нэг мэдээллийг 14 удаа хийж байгаа. Ажил чинь хөнгөрсөн биш бүр хүндэрчихсэн байж байгаа.

Тэгэхээр технологийн шийдэл чинь шийдэл биш хүндрэл болоод хувирчихсан байгаа болохоор бид энд ярихдаа гоё төсөөллөөр биш газар дээрээ бууж наадах чинь яг хүнд ямар хүндрэл учруулах вэ гэдгийгээ харах ёстой.

Энд Ц.Мөнх-Оргил гишүүн горимын санал гаргая гээд байна. Ц.Мөнх-Оргил гишүүний микрофоныг.

Ц.Мөнх-Оргил: Тодруулга л юм даа. Байнгын хороон дарга аа.

Сая манай Замын цагдаагийн газрын даргын тайлбараас хуульдаа асуудал биш, ерөөсөө яамны сайдын чинь тушаал хүчингүй болчихсон юм уу, Засгийн газрын тогтоолууд чинь хүчингүй болчихоод л асуудалд орчихоод байгаа юм байна шүү дээ.

Тэрийгээ л зас л даа. Засгийн газрынхаа хэмжээнд сайдынхаа тушаалыг гарга, Засгийн газрынхаа тогтоолыг гарга. Тэгээд асуудлаа шийд л дээ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ оруулж ирж байгаа нэмэлт, өөрчлөлт чинь хуулийн 3.4 буюу торгох шийтгэл гээд бүх төрлийн торгох шийтгэлд хамаарчхаад байгаа байхгүй юу.

Жишээ нь, одоо юу гэдэг юм зөвхөн замын хөдөлгөөний дүрэм зөрчөөд торгуулчихсан. Манай замын цагдаагийнхны нөхдүүд хэлж байгаа. Тийм ээ. Замын хөдөлгөөнд ороод, хөдөлгөөн зөрчөөд торгуулчихсан бол тэр машиных нь бүртгэл юм уу, сунгах дээр нь хязгаар хориг тавихад болж байгаа байхгүй юу. Утгатай байгаа байхгүй юу. Яагаад гэвэл чи замын хөдөлгөөнд зөрчихсэн.

Тийм учраас энэ машинд чинь зөвшөөрлийг чинь өгөхгүй, сунгахгүй гээд логиктой байгаа байхгүй юу.

Тэгэхгүй замын хөдөлгөөний дүрэмд ороод нөгөө Засгийн газрын тогтоол нь хүчингүй болчихсон ч юм уу, сайдын тушаал нь гараагүйгээс болоод, та нар торгуулиа авч чадахгүйгээс болоод тэр хүн гадаад явах гэж байдаг ч юм уу, эсвэл тендерт оролцох гэж байдаг, эсвэл төрийн албан шалгалтад оролцох гэхээр

эрхийг чинь хаачихсан гээд огт хоорондоо уялдаагүй л юм яригдаад байна шүү дээ.

Тэгээд энэ заалт одоо бид баталсан ч гэсэн цэц дээр очоод би үүнийг унана гэж бодож байна.

Яагаад гэвэл энэ чинь баланс барьж байх ёстой шүү дээ. Гаргасан зөрчил, шийтгэл, тэгээд тэр шийтгэлийг хэрэгжүүлэх гэж байгаа арга хэмжээ гурав чинь хоорондоо нэг тэнцвэртэй, уялдаатай байх ёстой шүү дээ. Тэр уялдаа нь бүрэн алдагдчихаад байгаа учраас энэ бол цэцийн босгыг давахгүй ээ.

Тийм учраас үүнийг бүхэлд нь хасвал яасан юм бэ? Би тийм зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа шүү. Дарга аа. Одоо би санал хураалгачихъя.

Д.Цогтбаатар: Н.Учрал гишүүнд микрофон өгье.

Н.Учрал: Д.Мөнх-Эрдэнэ зөвлөх яриад байх шиг байна. E-mongol-оор зөрчлийн төлбөр тооцоо хийгдээд байгаа юм байхгүй шүү. Одоо бол. Тийм.

Ер нь мэдээлэл нь зөвхөн тэр хот руу орж ирж байгаа пост дээр л, нөгөө орц, гарц дээр л төлбөр тооцоогоо хий гэж мэдээлэл ирж байгаагаас бусад тэр зөрчил ирээд байгаа юм байхгүй.

Ялангуяа авто тээврийн хэрэгслүүдийг бид нэгдсэн байдлаар бүртгээд, тэгээд зөрчил гаргавал ямар хариуцлага хүлээлгэх вэ гээд энэ нь ирээд байгаа юм байхгүй байгаа.

Түүнийг шийдэх гээд нийслэл **RFID**[Radio Frequency Identification] гээд нэг юм яваад байна шүү дээ. Тийм.

Тэгэхээр RFID-ийг сая Засгийн газар дээр нэг дүгнэлт гарга гээд надад хариуцуулсан.

Би юу гэж дүгнэж байгаа вэ гэхээр RFID бол энэ цаг үед тохирсон шийдэл биш ээ л гэж үзэж байгаа юм. Одоо ингээд камержуулж шийдье ээ л гэж л байгаа юм бол тэр RFID хоцрогдсон шийдэл байхгүй юу.

Бүх зөрчил торгуулиа шийдэж чадахгүй байж яаж тэр RFID-гаар бүх машин бүртгээд. Энэ бол тийм боломж байхгүй.

Тэгээд сая Д.Цогтбаатар даргын хэлж байгаа маш зөв.

Ер нь онол, практик хоёр зөрөөд байгаа юм. Тийм ч учраас төрийн байгууллагуудын уялдаа холбоогүйгээс болоод зарим газар төрийн үйлчилгээний дэмжих систем, үндсэн системээр бүртгэгдсэн мэдээллүүдийг цаасаар нэхээд байгаа байдал одоо хүртэл байсаар л байна.

Тийм учраас одоо бүгдээрээ энэ 120 хуулийг яагаад би оруулж ирээд байгаа юм бэ гэхээр ерөөсөө энэ асуудлыг л шийдвэрлэх гэж оруулж ирээд байгаа юм.

Тэгэхээр төр хоорондоо л уялдаж ажиллах хэрэгтэй.

Д.Цогтбаатар: Д.Мөнх-Эрдэнэ зөвлөх хариулчих. Сайд чинь хэрэггүй гэж байна.

Д.Мөнх-Эрдэнэ: “E-Mongolia” дээр торгуулийн мэдээлэл, төлбөр төлөх бүгдээрээ байж байгаа шүү.

Д.Цогтбаатар: Тийм тийм. Уг нь би жишээлбэл дэмжих гээд байна шүү дээ.

Гэтэл наадах чинь тэр шуурхай байдал нь хангагдахгүй тийм эрсдэл байгаа бол иргэдэд зүй ёсны бус хүндрэл учруулаад эхэлж байгаа байхгүй юу.

Тэр нь нөгөө тийм **асимметр**[asymmetric]-тэй хүн яриад байна шүү дээ. Энд гаргасан зөрчилтэй холбоотой л хариуцлага, арга хэмжээ баймаар байна гээд байдаг. Тэгтэл огт асимметричный тийм хандлагатай байгаад байна л гэж яриад байна шүү дээ.

Ингэе. Гэхдээ нэгэнт одоо бид чинь дэгээрээ л явах юм чинь. Би одоо энэ юугаар нь санал хураалгаад тэгээд дараа нь Ц.Мөнх-Оргил гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа юм байна.

Харин дэгээрээ энэ чинь заавал үүнийгээ хурааж байж юм байна шүү дээ.

Одоо тэгэхээр би энэ уншиж байгаа чинь 1.3-ыг чинь би унших гээд байна шүү дээ. юу?

Ц.Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгье.

Ц.Мөнх-Оргил: Өргөн барьсан хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дээр ажлын хэсэг ч санал байхгүй, гишүүд ч санал байхгүй.

1 дүгээр зүйлийн 2 дээр ажлын хэсгээс санал байхгүй.

Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал байгаа юм.

Тийм учраас дарааллаар нь эхлээд хураалгаад өгөөч ээ гэсэн саналтай байгаа юм.

Би энэ өргөн барьсан Зөрчлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг бүхэлд нь хасья гэсэн саналтай байна.

Тэгээд ажлын хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр ажиллаж байгаа байнгын ажиллагаатай ажлын хэсгийнхэн энэ торгуулийн шийтгэлийг гүйцэлдүүлдэг арга механизмыг бүрэн гүйцэд бодож ирээд Засгийн газрынхаа тогтоолыг гаргаад, сайдынхаа тушаалыг гаргаад одоо харин хуульд ийм заалт оруулахгүй бол болохгүй нь ээ гэдэг санал ороод ирэхээрээ нэгмөсөн хэлэлцье гэсэн саналтай байна.

Тийм учраас Байнгын хорооны дарга аа, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг хасья гэсэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалгаж өгөөч ээ гэж хүсэж байна. Томьёолол нь энэ байна.

Д.Цогтбаатар: Саяын энэ торгуультай холбоотой асуудал орж ирээд байна шүү дээ. Зөрчил гарсан тохиолдолд паспортыг нь өгөхгүй.

Ц.Мөнх-Оргил гишүүний гаргаж байгаа зарчмын зөрүүтэй санал нь одоо энэ оруулж байгаа төслийн 1 дүгээр зүйлийн 2-той холбоотой.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дугаар хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Одоо ажлын хэсгээс оруулсан саналыг би уншиж танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх үндэслэл нь энэ хуулийн 5.2, 5.3, 5.4, 5.5, 5.6, 5.7, 5.8, 5.10, 5.11, 5.12, 5.13, 5.14, 5.15, 5.18, 5.20, 6.4, 6.5, 6.6, 6.7, 6.8, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.17, 6.18, 6.20, 6.22, 6.23, 6.26, 6.27 дугаар зүйл, Долдугаар бүлэг, 8.1, 8.6, 8.7, 8.8, 8.9, 9.7, 10.3, 10.7, 10.15, 10.25 дугаар зүйл, Арван нэгдүгээр бүлэг, 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6, 12.8, 12.9, 12.10, 12.11, 13.1, 13.2, 13.4, 13.5, 13.6, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.8, 14.9, 14.10, 14.11, 14.12, 14.13 дугаар зүйл, Арван тав, Арван зургадугаар бүлэг, 17.1 дүгээр зүйлд тус тус заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн [2 дугаар зүйл](#)-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Хуулийн төслийн [3 дугаар зүйл](#)-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Хуулийн төслийн [4 дүгээр зүйл](#)-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Хуулийн төслийн [5 дугаар зүйл](#)-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй санал энэ дээр орж ирсэн байгаа. Би тэрийг уншиж танилцуулъя.

2.Төслийн 5 дугаар зүйлийг өөрчлөн найруулж 3 дугаар зүйл болгон шилжүүлэх.

“**3 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.Жолооч:

3.1.согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

3.2.тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;

3.3.согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

[6 дугаар зүйл](#) дээр саналтай гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн найруулгын саналаар санал хураалт явуулъя.

Нэг.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх найруулгын санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “3.5, 3.6 дугаар” гэснийг “3.5 дугаар” гэж өөрчилж, мөн зүйлд “4/3.6 дугаар зүйл:” гэж нэмж, Төслийн 3 дугаар зүйлийн “1.2, 1.3, 1.4 дэх заалтын дугаарыг “1.3, 1.4, 1.5” гэж,” гэснийг “1.2. 1.3 дахь заалтын дугаарыг “1.3. 1.4” гэж өөрчилж, мөн зүйлийн “3.5-3.8 дугаар зүйлийн дугаарыг “3.7-3.10” гэж” гэснийг “14.7 дугаар” гэснийг өмнө нь шилжүүлж, төслийн 4 дүгээр зүйлийн “”, 14.7 дугаар зүйлийн 5 дахь” гэснийг “хэсэг, 14.7 дугаар зүйлийн 5 дахь” гэж өөрчлөх.

Энэ саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Бас найруулгатай холбоотой санал орж ирж байна. Уншиж танилцуулъя.

Хоёр.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх найруулгын санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “агуулга бүхий зүйл, хэсэг” гэснийг “агуулгатай дараах зүйл, хэсэг” гэж өөрчлөх.

Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ц.Сандаг-Очир гишүүн микрофон өгье. Та наадахаа уншаад танилцуулчих. Санал хураая.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Түүрүүн асуусан асуулт, хариулсан

хариулт дээрээ яриад төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2 дахь хэсгийг нэгтгээд өөрчлөн найруулах гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал байна.

Энэ нь Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэсэн энэ зарчмын зөрүүтэй саналыг хураалгаж өгөөч ээ.

Тэгчихвэл тэр хуулийн нөгөө заалтууд нь, эшлэлүүд нь одоо мөрдөгдөж байгаа хуультайгаа нийцээд ингээд явчих юм байна.

Тэгэхгүй бол одоо ингээд зөрчөөд. Одоо мөрдөгдөж байгаа хууль дээрээ 2 дугаар заалт дээр одоо манай дээр 3 дээр болчихоод байгаа байхгүй юу. Ийм зөрүү гарчхаад байгаа учраас.

Д.Цогтбаатар: Тэгвэл дэмжье гэсэн томьёоллоор саяын саналыг.

Ц.Мөнх-Оргил гишүүн.

Ц.Мөнх-Оргил: Энэ ажлын хэсэг дээрээ Ц.Сандаг-Очир гишүүн ээ, та хэд дахиж нэг ярьчхаад оруулаад ирэхгүй юм уу?

Энэ чинь Засгийн газрын өргөн барьсан концепцоос нэлээн өөр юм болчих гээд байна шүү дээ.

Засгийн газар чинь өргөн барихдаа эхний заалт нь “**бэлгийн харилцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл**” гээд нэг салгаад.

Хоёрт нь болохоор “**бэлгийн харьцаанд орсон бол**” гээд хоёр салгачихсан байхгүй юу. Хоёр өөр зүйлчлэл болгоод оруулаад ирсэн байхгүй юу.

Тэгээд үүнийг чинь буцаагаад бүгдийг нь нэгдүгээр зүйлдээ оруулчихаар энэ чинь ял нь өөр шүү дээ. Хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол 1-ээс 5 жил, хүч хэрэглээд бэлгийн харилцаанд орчихсон 2-оос 8 жил байхгүй юу. Хоёр тусдаа гэмт хэрэг байхгүй юу. Тийм.

Үүнийг чинь нийлүүлчихээр яах вэ тэр хүндрэл гарах нь ойлгомжтой. Тэгэхдээ тэрийгээ засах гэж байна гээд Засгийн газрынхаа оруулж ирсэн энэ концепцыг нь эвдчих гээд байгаа юм шиг санагдаад байх юм.

Тэгээд яг одоо шууд ингээд санал хураачихын оронд энэ бол яг процессоороо, манай дэгээрээ хоёрдугаар хэлэлцүүлгийн үед шийдэгддэг, засдаг асуудлууд л даа. Зарчмыг нь бид зөвшөөрчихлөө шүү дээ.

Тэгээд хоёрдугаар хэлэлцүүлэг дээрээ, ажлын хэсэг дээрээ та хэд ярьж байгаад бүр нэг маапаангүй болгоод ороод ирчих.

Яагаад гэвэл Б.Батцэрэн шүүгч ийм хүндрэл үүсэхээр байна гэж хэлж байдаг. Д.Мөнх-Эрдэнэ зөвлөх болохоор хүндрэл үүсэхгүй гээд байдаг. Би жишээ нь дотроо эргэлзээд л байна л даа. Яг аль нь зөв юм.

Тийм учраас санал хураалгахгүйгээр Ц.Сандаг-Очир гишүүн

ээ, эргэлзээгээ тайлчхаад. Тэртээ тэргүй хоёрдугаар хэлэлцүүлэг хийнэ. Энэ дээр.

Тэгээд нэгдсэн хуралдаан дээр хуралдаан даргалагчаас чиглэл гаргуулаад, чиглэл аваад засчихвал яасан юм бэ. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Б.Батцэрэн шүүгч. 5 дугаар микрофон өгье.

Б.Батцэрэн: Хүчиндэх гэмт хэргийн энгийн бүрэлдэхүүнийг ингэж дотор нь салгаад хоёр хэсэг болгож оруулж ирсэн байна.

Гэтэл энэ бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл гэдэг хууль зүйн ойлголтыг энэ 12 дугаар зүйлийн 1-ийн тайлбар хэсэгт. **Аутентик тайлбар**¹[*authentic interpretation*] хийгдсэн байгаа.

Энэ тайлбарын агуулгыг нь харахад бэлгийн харьцааны шинжтэй хүчирхийлсэн үйлдэл гэдэг бол тэр жам ёсны хурьцал үйлдэх үйлдэл дотроо багтаж байгаа байхгүй юу. Тийм. Хамаарч байгаа.

Тэгэхээр яг ийм хоёр тусад нь зүйлчлэл болгосноороо энэ хоёр зүйлийн диспозиц шинжүүд онцын ялгаа байхгүй болчихоод байгаа юм.

Тэгэхээр энэ томьёолол дээр дахиж эргэн анхаарах, боловсронгуй болгох ийм шаардлага бий. Тийм.

Д.Цогтбаатар: Д.Ганбат гишүүний микрофоныг өгье.

¹ Эрх зүйн актыг батлан гаргасан субъект тайлбарлах тухай ойлголт.

Д.Ганбат: Ер нь зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаагаа дэмжиж байгаа.

Гэхдээ Ц.Мөнх-Оргил гишүүний хэлээд байгаа тэр нарийн ширийн юмыг Эрүүгийн хуулийн бодлого, энэ юм чинь цогц байна гэдгийг. Тийм ээ. Ялангуяа энэ мэргэжлийн хүмүүс нь, тэр Хүний эрхийн Үндэсний Комиссоос ч гэсэн бас ярьж байна шүү дээ.

Тэр пидофил^[pedophilia] нь ямар байх юм? Тэр үнэхээр дахин давтагдаад, хийгдээд, өвчин зовлонтой, цаанаасаа тийм хүмүүсээ яах юм?

Тэгээд өнөөдрийн нийгмийн нөхцөл байдал ямар байна вэ? Бүх л эх, эцгүүд, ялангуяа залуу хүмүүс хүүхдээ орхиод л гадагшаа явчаж байна. Тэгээд гэр бүл салалт их байна. Хойд эцэг гээд нэг хүмүүс гарч байна. Тэндээс хүчирхийлэл маш их явагддаг.

Нөгөө харах хандах хүнгүй манай хүүхдүүд чинь тэр гандан, социалаар гараад байгаа юмыг харахад янз бүрээр л юм явагдаад байна шүү дээ.

Тэр арван хэдтэй, 11, 12-той манай Монгол Улсад болж байгаа явдал мөн ч юм уу, биш ч юм уу. Тийм ээ. Иймэрхүү юмнуудыг одоо нэг иж бүрэн шийдээд. Нэгэнт л Эрүүгийн хуульдаа өөрчлөлт оруулж байгаа юм бол нэлээн сайн ярилцаж байж ингэж хийх ёстой.

Тэгээд Засгийн газраас бас энэ согтууруулах ундаагаар машин тэрэг барих энэ хуулийг хүндрүүлнэ ээ гээд хэлэлцээд эхлэнгүүт л яг тэр орой нь бараг согтуугаар машин барих явдал 50 хувь багасаж байна шүү дээ.

Сая энэ мотоциклтой, приустэй хөдөө гадаа архи дарс уугаад явж

болохгүй ээ. Айраг уусан нэрийн доор ингэж аргалаад явж болохгүй ээ гэдэг энэ үйлдэл гарангуут л энэ хүмүүс чинь зүгээр хөдөө гадаа морь малаа унадаг болно.

Нөгөө XXI зуун, XX зуун хоёр чинь өөр шүү дээ. Тэрийг яг морь мал шигээ мотоциклыг, машиныг бодож болохгүй гээд л. Энэ чинь асар өндөр хариуцлагатай юм байхгүй юу.

Байнгын хорооны дарга Д.Мөнх-Эрдэнэд хэлж байна шүү дээ. Тэр “**бараг**” гэсэн юм байхгүй ээ, энэ дээр бол. “**Бараг**” гэж ярихгүй шүү дээ. Эрүүгийн хуульд. Ийм байна.

Бараг шийдчихсэн байна, бараг шийдэх байх гэж. Гарцаагүй хоёр ойлголт байхгүйгээр л юмыг бид хийж өгвөл үр нөлөө нь бараг үр дүнтэй байна.

Тийм учраас нэлээн сайн мэргэжилтнүүдтэйгээ ярих ёстой. Та нар ч гэсэн олон нийтийн бодлыг дагаад байлгүй яг юмаа хэлж байх ёстой байхгүй юу? Энэ Хууль зүйн байнгын хороон дээрээ, тэр ажлын хэсэг дээрээ.

Тэгэхгүй бол нийгэмдээ ингээд л хоёр тал руу савчхаад л ингэж болохгүй зүйл шүү гэдгийг би бас анхааруулан хэлчихье ээ гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Тэгэх үү? Тэгвэл та саналаа татчих тэгэх үү? Та микрофондоо хэлчих.

Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: Тэгээд саяын 3 дугаар зүйлийн саяын гаргасан зарчмын саналаа бид ахиад ажлын хэсэг дээрээ ярья. Хоёрдугаар хэлэлцүүлгийн үеэр. Тийм.

Тийм учраас энэ удаа зарчмын зөрүүтэй саналаа татаж байна.

Д.Цогтбаатар: Тэгвэл наадахаа нэгдсэн чуулганы үеэр Их Хурлын даргаар дахиж хэлэлцэхээр чиглэл өгүүлээд тэгээд наад асуудлаа та нар ярих нь байна шүү дээ.

Тэгвэл ингээд дараагийн нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа асуудлуудаа ярья.

Ингээд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн **1 дүгээр зүйл**-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Хуулийн төслийн **2 дугаар зүйл**-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Хуулийн төслийн **3 дугаар зүйл**-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Хуулийн төслийн **4 дүгээр зүйл**-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Хуулийн төслийн **5 дугаар зүйл**-тэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулна.

Дараагийн асуудалдаа орёе.

Гурав.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд

/Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг,

Санал, дүгнэлтээ Инновац, цахим бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/

Н.Учрал гишүүний салбартай холбоотой асуудал орж иржээ. Гуравдугаар асуудал.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор

хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй хамт

өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор өргөн мэдүүлсэн Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Н.Учрал гишүүн микрофон өгье.

Н.Учрал: Би Их Хурлын гишүүддээ мэдээлэл өгье.

Хууль тогтоомжийн хуулийн дагуу хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах үндэслэлээр энэ 120 хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өргөн мэдүүлсэн.

Тэгээд Засгийн газраас санаачлаад, хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдсан.

Энэ хуулийг Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Их хурлын дарга чуулганы үеэр Хууль зүйн байнгын хорооны зүгээс санал, дүгнэлтээ байнгын хороонд шилжүүлээ гэдэг ийм чиглэлийг өгсний дагуу өнөөдөр энэ хууль Хууль зүйн байнгын хороогоор орж байгаа.

Ер нь Инновацын байнгын хороон дээр ажлын хэсэг байгуулагдаад, Ж.Чинбүрэн гишүүн ахлаад ажиллаж байгаа.

Энэ ямар учиртай хууль юм бэ гэхээр Нийтийн мэдээллийн ил тод байдлын хууль дээр **“бичгээр”** гэдэг агуулгыг **“цахимаар болон цаасаар”** аль алиныг нь хамааруулна гэж хуульчилсан хэдий ч яг амьдрал дээр ирэхээр яг хууль

дээрээ **“бичгээр өгнө”** гээд заачихсан түүнийг цаасан хэлбэрээр бичгээр өгнө өө л гэж ойлгоод хэрэглээд байгаа нь түрүүн Д.Цогтбаатар даргын хэлдгээр амьдрал дээр нэлээдгүй их хүндрэл бэрхшээл үүсгээд байгаа юм.

Тийм учраас яг энэ хууль дээр энэ органик хуулиуд дээр, салбарын хуулиуд дээр цахимаар болон цаасаар бас аль аль нь байж болно гэдгийг нээлттэй бас зааж өгч байгаа.

Тийм учраас энэ хууль батлагдсанаараа салбарууд бас дотооддоо цахимжилтаа хийхэд нэлээн үр дүнгээ өгнө гэж тооцож байгаа.

Тухайн үед Хууль зүй, дотоод хэргийн яамнаас саналыг аваад анх үзэл баримтлалыг батлуулахдаа энэ Шүүх байгуулах хуулийг бас өргөн мэдүүлэх гэж байгаа. Дээрээс нь Иргэний процесс, Эрүүгийн процессын хуулийг өргөн мэдүүлэх гэж байгаатай холбогдуулаад энэ иргэний процесстой холбоотой, эрүүгийн процесстой холбоотой, шүүхийн цахимжилттай холбоотой асуудлыг энэ 120 хувь л багтаагаагүй.

Тэгээд одоо сая Б.Энхбаяр сайд тэр Иргэний процессынхоо хууль дээр яг энэ шүүхтэй холбоотой цахимжилт, цахимаар тэр нэхэмжлэл авах, процессын шатанд нөгөө цахим баримт бичгийг бас дэмжих энэ тэр гээд сайн зохицуулалтууд оруулаад ирж байгаа юм билээ.

Тэгэхээр заавал одоо бас тэр Хууль зүйн яамны тэр эрхлэх асуудлынх нь хүрээнд тэр асуудал руу нь огт ороогүй. Энэ бол бусад салбарын хууль дээр зөвхөн **“бичгээр”** гэсэн нэр томъёог **“цаасаар болон цахимаар байж болно”** гэдэг ийм л өөрчлөлтүүдийг хийсэн.

Түүнээс биш тийм агуулгын том өөрчлөлт, салбарын том өөрчлөлт ийг энэ хуулиар хийсэн зүйл огт байхгүй. Зүгээр “бичгээр” гэдгийг л “цахимаар болон цаасаар байж болно” гэдэг ийм л агуулгыг хөндөж байгаа учраас тийм хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгахаар л өргөн мэдүүлсэн.

Түүнээс биш шинэчилсэн найруулга ч биш, ямар нэгэн салбарын өөрчлөлт ч огт биш.

Тийм учраас Хуульчийн эрх зүйн байдлын хуулиас авхуулаад, энэ Хууль тогтоомжийн хуулиас авхуулаад дотор нь жишээ нь цахим хэлбэрээр саналаа ирүүлж болно оо л гээд ингээд зааж байгаа юм.

Хэрвээ энэ “цахим хэлбэрээр байж болно” гэдгийг зачих юм тус салбар өөрөө цахимжилтаа явуулаад, Б.Энхбаяр сайдын ярьж байгаагаар тэр компьютероо аваад бэлэн болчихдог юм бол ядаж цахимаар бичиг хэргээ авахад ажилд нь хүнд суртал багасах юм байна л гэдэг утгаар нь хуулийн хувьд бас нээж өгч байгаагаараа л онцлогтой шүү гэдгийг бас тодотгож хэлье.

Д.Цогтбаатар: Ц.Мөнх-Оргил гишүүнд микрофон өгье.

Тэгэхдээ яах вэ хэлэлцэж эхлэхээс өмнө яах аргагүй юу гараад байна л даа. Тэр боломжийг өгье. Ц.Мөнх-Оргил сайдад. Тийм.

Ц.Мөнх-Оргил: Асуух асуулт байна л даа.

120 хуулиас хэд нь манай Байнгын хороонд ороод ирэв ээ? Тэрийг яаж сонгож авав аа? **Нэгдүгээрт.**

Хоёрдугаарт, ингээд гүйлгээл харахаар Байнгын хорооны дарга аа, энэ дээр хэдүүлээ нэг жижигхэн ажлын хэсэг гаргаад хоёр өдөр суумаар ч юмнууд харагдаад байх юм.

Жишээ нь, төрийн байгууллагууд хоорондоо харилцаж байгаа юмнууд дээр цахим хэлбэрээр явуулах бол болж байгаа байхгүй юу. Тийм үү.

Гэтэл яг хүний өмч хөрөнгөтэй холбоотой. Жишээ нь, одоо юу гэдэг юм, үл хөдлөх хөрөнгийн хэлцэл хийж байна шүү дээ. Тэрийг жишээ нь цахимаар юм уу, эсвэл нотариатын үйлдлүүдийг цахимаар гэдэг юм уу, эсвэл тэр Үндсэн хуулийн цэцийн шүүгч тусгай саналаа цахимаар өгч болно оо ч гэдэг юм уу. Иймэрхүү юмнууд ялгаж салгахгүй бол болохгүй болчхоод байгаа байхгүй юу.

Тэгээд энэ яаралтай, бүр тийм хурдан яаралтай биш бол дараагийн долоо хоногийн хурлаар хэлэлцээд нэг жижигхэн ажлын хэсэг гаргаад Б.Энх-Амгалан гишүүн бид хоёр Цахим, инновацийн ажлын хэсгийнхэнтэй хамтарч сууж байгаад энэ 38 хууль дээрээ нэг хараадахъя тэгэх үү?

Жишээ нь, тэр үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой юман дээр хэчнээн цахимаар байж болсон ч гэсэн цаана нь заавал цаас үлдэх ёстой шүү дээ.

Цахимаар байж болохгүй байхгүй юу. Сүүлд нь нөгөө цахим чинь алга болчихвол яах вэ. Тийм ээ. Гэх мэтийн хөрөнгө мөнгөтэй холбоотой, ар гэрийн харилцаатай холбоотой юмнуудаа хэдүүлээ ялгаж салгах хэрэгтэй байгаа юм.

Иргэний процесс дээр ч гэсэн ганц нэг юмнууд байх шиг байх юм.

Саналыг нь би 100 хувь дэмжиж байгаа юм.

Ганцхан хуульдаа бид бололцоог нь гаргаад өгчихдөг. Нөгөө цахим систем маань жигдэрч амждаггүй, аюулгүй байдал нь хангагдаж амждаггүй, хүмүүс нь сурч амжаагүй байтал энэ хооронд хийдэл үүсэх вий дээ. Хүмүүсийн эрх хохирох вий дээ.

Үүнийг хэдүүлээ яаж салгах вэ. Дэс дараатай байх уу. Заримыг нь шууд эхлээд хэрэгжүүлээд явчихъя. Заримыг нь хуульдаа хийчихье.

Тэгэхдээ энэ заалт нь 2025 оны 01 сарын 01-нээс ч гэдэг юм уу ингэж ялгаж салгах шаардлага гарч магадгүй л гэж бодоод байна.

Одоо дөнгөж сая ингээд ийм том цаас тараачхаар чинь бас харж амжихгүй байна шүү дээ.

Д.Цогтбаатар: Н.Учрал гишүүн.

Н.Учрал: Өмчлөлтэй холбоотой асуудлыг хөндөөгүй.

Жишээ нь, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хууль дээр гэхэд зүгээр л хуулийн этгээдийн хувийн хэргийн лавлагааг цаасан, эсхүл цахим хэлбэрээр. Эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтны бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан хүсэлтээр олгох лавлагаанд гэдэг ч юм уу ингээд ерөнхийдөө цаасан, эсхүл цахим хэлбэрээр гэдэг л өөрчлөлт хийж байгаа юм.

Өмнө нь ерөөсөө л бүгд цаасан хэлбэрээр байна л гээд заачихсан.

Зүгээр энэ өөрчлөлтүүдийг яагаад ингэж анх оруулж ирсэн юм бэ гэхээр анх

энэ хуулийн төслийг санаачлахад. Үгүй ээ үгүй. Харин би эсэргүүцээгүйг мэдэж байна шүү дээ. Үгүй ээ үгүй. Ялгаж болно.

Тэгэхдээ энэ хүсэлтүүдийг болохоор тухайн байгууллага өөрсдөө л өгсөн юм.

Жишээ нь, Улсын бүртгэлийн газар өөрсдөө л энэ саналаа өгсөн. Хуульчдын холбоо өөрсдөө л энэ саналаа өгсөн. Бэлэн болсон эсэхээ өөрсдөө л дүгнээд л бид энэ түвшинд байгаа юм гэдгээ өөрсдөө л хүсэлтээ өгөөд л түүнийг нь нийцүүлээд л явж байгаа.

Мэдээж тэр иргэний процесс, эрүүгийн процесс, тэр өмчлөлтэй холбоотой, суурь бүртгэлтэй холбоотой тэр харилцаануудыг огт хөндөх нь зохимжгүй. Үүнийг мэдээж Хууль зүйн яам өөрсдөө санаачлаад тэгээд Хууль зүйн байнгын хороогоор шийдэх ёстой юм байна.

Бусад төрлийн харилцаан дээр л. Одоо жишээ нь хууль зүйн туслалцаа авахад цахимаар зөвлөгөө өгч бас болох л юм байна. Хууль тогтоомжийн хууль дээр гэхэд л нэг тайлан хүсэлтийг цахимаар бас өгч болох л юм байна.

Тэгээд л Хуульчийн эрх зүйн байдлын хууль дээр гэхэд Хуульчдын холбоо өөрсдөө жишээ нь Хуульчдын их хуралд хүрэлцэн ирэх боломжгүй бол саналаа ядаж цахимаар битүүмжлэлээ ирүүлчхэж болдгийг нээгээд өгчхөөч. Тэгэхгүй бол заавал биеэр ирээд байх бас төвөгтэй байна ч гэдэг юм уу. Онлайннар хууль зүйн зөвлөгөө өгөхийг одоо бас нээгээд өгчхөөч. Бид бас өгье өө ч гэдэг юм уу ийм хэдэн саналуудыг өөрсдөө л гаргаж өгсөн.

Тэгээд тэр хүрээнд нь л шийдсэн. Тэр янз бүрийн процессын асуудал руу бид огт оролцоогүй.

Гэхдээ Ц.Мөнх-Оргил гишүүнд хэлэхэд, таны санал зөв байна. Гэхдээ бид зөвхөн сонголт өгч байгаа. Энэ 100 хувь цахим гэх юм байхгүй. Зүгээр цаасан, эсхүл цахим хэлбэрээр байж болно оо л гэж байгаа юм.

Тэгэхээр тухайн байгууллага өөрсдөө цаасаар явуулна уу, цахимаар явуулна уу, аль аль нь нээлттэй байхад мэдээж технологи нь, дэвшил нь гараад бэлэн байдалд орчихвол цахимаар явуулахыг өөрсдөө дотоодод шийдэхгүй бол одоо хуулиар ингээд зөвхөн цаасаар гэгчихсэн юмыг нөгөө хэд бэлэн болчихоод ч байдаг. Цахимаар явуулж болохгүй хуультай учраас дагах боломжгүй.

Анх Хууль зүйн яам энэ цахимын таван хуулийг өргөн мэдүүлж байхад Нийтийн мэдээллийн хууль дээр бичгээр, цахим ба цаасыг гэж ойлгоно гэсэн. Яг амьдрал дээр очихоор энэ төрийн байгууллагууд чинь хуулиа хараад л бид хуулиа л барьж байна гэдэг юм байна лээ.

Тэгэхээр бид та нар цаасаар авч болохгүй, үүнийг ингэж ойлго гэхээр үгүй ээ манай салбарын хууль дээр чинь цаас гэгчихсэн юм чинь хуулиа л хэрэгжүүлбэ гээд байдаг юм байна.

Д.Цогтбаатар: Б.Энхбаяр гишүүн эхлээд санал тавьсан. Б.Энхбаяр гишүүний микрофоныг өгье. Тэгээд дараа нь Б.Энх-Амгалан гишүүн.

Б.Энхбаяр: Энэ бол Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл байгаа.

Миний хувьд энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг шийдэх үед

зарчмын байр суурьтай байсан. Яг Ц.Мөнх-Оргил гишүүнтэй адилхан байр суурьтай байсан.

Энэ ерөөсөө ингээд нэг тийм юу яагаад ороод ирчихсэн байхгүй юу. Бичгээр гэдгийг нь зүгээр ард нь таслал цаасаар гэдэг юм ингээд бүх хуульд байгаа бичгээр гэдэг үгийн ард аваачаад цаасаар гэдэг юм бичээд явчихсан. Цахимаар.

Ингэнгүүт байна шүү дээ. Ерөөсөө цахимаар хийж болдоггүй юмнууд руу хүртэл ороод явчихсан байгаа. Жишээлбэл, энэ Иргэний хууль хөндчихөж байгаа байхгүй юу. Суурь хууль.

Насанд хүрээгүй иргэн хуулиар зөвшөөрснөөс бусад хэлцлийг хууль ёсны төлөөлөгчийн бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр л хийдэг байхгүй юу. Үүнийг цахимаар болгочхож болохгүй.

Насанд хүрээгүй хүүхдийн хувь заяаны асуудлыг цахимаар шийддэг байж болохгүй байхгүй юу даа.

Насанд хүрээгүй иргэнтэй хэлцэл хийсэн 54.1.

Энэ дараагийн асуудал. Одоо энэ орон сууцын өмчлөл дээр гараад ирж байгаа байхгүй юу.

Жишээлбэл, сууц өмчлөгчийг бусад өмчлөгчид нь холбооны гишүүнээс гаргах, сууц өмчлөх эрхээ бусдад шилжүүлэхийг шаардах эрхтэй гээд энэ энэ заасан үүргээ ноцтой зөрчиж тус холбооноос бичгээр гэдгийн ард цахим хэлбэрээр сануулсаар байхад гээд нэмчхэж байгаа байхгүй юу.

Цахим хэлбэрээр сануулна гэж яаж сануулахыг хэлэх юм. Чиний чатаар чинь 3 удаа СӨХ чинь сануулга ирсэн. Чи одоо энэ эрхээ алдлаа гээд. Дараа нь нөгөөдөх нь уншаагүй, үзээгүй явж байсан. Бөөн асуудал.

Барьцааны гэрээ. Барьцааны гэрээг бичгээр байгуулна гэдгийг барьцааны гэрээг бичгээр эсвэл цахим хэлбэрээр байгуулна болгочхож байгаа байхгүй юу.

Цахимаар барьцааны гэрээ байгуулна гэж ер нь ямар юм байдаг юм. Хаана тийм хөрөнгөө барьцаалж, орон сууцаа цахимаар барьцаалдаг ер нь хаана дэлхийд тийм юм гараад ирчихсэн юм. Би бол огт сонсоогүй юм байна.

Энэ ерөөсөө ингээд иргэний. Сая Ц.Мөнх-Оргил гишүүний хэлээд байгаа асуудал байхгүй юу. Суурь бүх харилцаа руу ороод явчихсан байхгүй юу даа.

Түүнээс иргэн төрийн хоорондын үйлчилгээний тухай асуудлаасаа халиад явчихсан.

Компанийн хууль. Үүний үр дагавар нь аягүй өндөр байхгүй юу даа. Үр дагавар нь. Үүнийг ерөөсөө тооцоо, судалгаа хийгээгүй. Үүний үр дагавар нь яах юм, ямар харилцаа үүсэх юм.

Жишээ нь, Прокурорын хууль буюу Процессын хууль дээр ороод ирж байгаа байхгүй юу. Прокурорын зөвшөөрлийг цахим хэлбэрээр өгч болно. Бүр прокурорын даалгаврыг цахим хэлбэрээр мэдэгдэнэ гэж байгаа шүү дээ.

Энэ чинь мөрдөн шалгах ажиллагааны даалгавар байхгүй юу. Чи ийм ийм ийм нотлох баримтыг нэмж цуглуулах гэдэг тэр нөгөө шүүх хуралдаанд хавтаст хэргээр үлддэг нотлох баримтын эх сурвалж болдог

зүйлийг цахимаар үйлдэнэ гэж байгаа байхгүй юу.

Д.Цогтбаатар: Б.Энх-Амгалан гишүүнд микрофон өгье.

Б.Энх-Амгалан: Цааснаас татгалзаж цахимаар түргэн шуурхай, хүнд сурталгүй, авлигагүй ийм байдлаар асуудлыг шийдэх гэж байгаа гэдгийг ойлгож байгаа. Үүнийг дэмжиж байгаа юм.

Гэхдээ яг орж ирсэн нөхцөл байдлаар харах юм бол яг Б.Энхбаяр гишүүний хэлсэн, сая Ц.Мөнх-Оргил гишүүний хэлсэн шиг ингээд цаасан гэдгийн ар талд цахим хэлбэрээр байж болно гэдэг л үг орчихсон юм.

Энд их аюултай юм байна л даа. Харьяатын тухай хууль дээр Монгол Улсын харьяат болох болоод Монгол Улсын харьяатаас гарах асуудал цахимаар явна гэж одоо ямар юм байх вэ.

Тэр дунд нь одоо ингээд 16 нас хүрээгүй хүүхдийг Монгол Улсын харьяатаас гарахыг зөвшөөрч болох асуудал цахимаар явж болохгүй шүү дээ.

Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх асуудал цахимаар явж болохгүй шүү дээ.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгдэх, цагаатгах, нөхөн олговор олгох энэ асуудал цахимаар явж болохгүй.

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг цахимаар өгнө гэж ямар юм байдаг юм. Цахимаар өгөөд хүнийг аваачаад шоронд аваачаад хийчхэж болохгүй биз дээ.

Тэгэхээр энэ чинь заавал нэг тийм юм байж явахгүй болохгүй байгаа юм л даа.

Жишээлбэл, согтууруулах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх асуудлыг тухайн нутаг дэвсгэр цагдаагийн байгууллага ингээд цахимаар гаргачих юм бол тэр хүнийг аваачаад албадан эмчилгээнд оруулах нь л дээ янз нь.

Энэ чинь өөрөө тэр Патентын тухай хууль, Лицензийн тухай хууль, Прокурорын тухай хууль, Иргэний тухай хууль, тэгээд Иргэний бүртгэлийн тухай хууль.

Монгол Улсын харьяат болсон, харьяатаас гарсан иргэний харьяаллыг сэргээн тогтоосны бүртгэлийг хийсэн өдрөөс хойш 5 хоногийн дотор улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн захиргааны байгууллагад бичгээр эсвэл цахимаар явуулж болно гэж байгаа юм.

Тэгэхээр энэ харьяатаас гарах орох асуудал. Энэ суурь хуулиудыг бас хамаагүй оролдож болдоггүй хуулиудыг, тэгээд хүний хөрөнгөтэй холбоотой асуудлыг, тэгээд хүний эрх эрх чөлөөтэй холбоотой асуудлыг, шүүхийн процесстой холбоотой асуудлыг цахимаар явуулна гэдэг цаг нь болоогүй шүү.

Бид өнөөдөр яагаад тэрийг хэлж байна гэхээр цахим халдлага өнөөдөр Монголд өдөрт хэд байгаа билээ. 7 мянга гараад явчихсан шүү дээ.

Тэгэхээр энэ цахим халдлага байж байгаа үед бид ийм нарийн юмнуудыг бүгдийг нь цахимжуулах цаг хугацааны хувьд зарим нэг нь болоогүй байх гэж бодож байгаа юм.

Тийм учраас нэг ажлын хэсэг байгуулаад хамаагүй болж байгаа юмнуудыг нь болгоод. Тэр үйлчилгээний, тэр өмгөөллийн юм бол бололгүй яах вэ. Болоод л явна биз.

Яг энэ суурь хуулиудтай холбоотой, харьяатаас гарахтай холбоотой юмнууд болохгүй байх л гэж бодож байна.

Тэгэхээр энэ дээр нэг тодорхой ажлын хэсэг байгуулаад бас аль альныг нь цахим гэж эхний ээлжид үзэх вэ, альныг нь хугацаанд заах вэ, альныг нь бүр цахим гэдгийг нь хасах вэ гэдэг нэг ийм хэдэн юмнуудыг бас явуулах нь зөв байх л даа.

Д.Цогтбаатар: Н.Учрал гишүүн тайлбараа хэлчих. Тийм.

Н.Учрал: Гишүүдийн саналыг хүндэтгэж хүлээж авч байна.

Тэгээд яах вэ, бид энэ хуулийг боловсруулж байх явцад энэ байгууллагуудаас саналыг нь аваад тэр суурь харилцааг нь хөндөхгүй гэдэг байдлаар л саналуудыг нь аваад л тусгасан.

Энэ бид шууд оруулчихсан зохицуулалт ер нь байхгүй. Дандаа л тэр байгууллагуудынх нь өөрсдийнх нь санал. Тэгээд тэр байгууллагуудынх нь саналыг үндэслээд хийсэн.

Гэхдээ энд зүгээр яах вэ тайлбарлахад 100 хувь цахимаар гэдэг агуулга биш. Зүгээр л бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гээд л оруулчихсан байгаа юм. Яг одоо нэг тийм суурь харилцааг хөндөөд байгаа юм байхгүй.

Ер нь Хувь хүний мэдээлэл хамгаалах хуулийг батлахад Хувь хүний

мэдээлэл хамгаалах хууль дээр тэр мэдээллийн эзний зөвшөөрлийг мэдээлэл хариуцагчид бичгээр өгнө. Энэ зөвшөөрөл нь цаасан эсвэл цахим хэлбэртэй байна гээд л суурь харилцааг нь бид Хувь хүний нууцын хууль буюу Хувь хүний мэдээлэл хамгаалах хуулиар тодорхой тусгаад өгчихсөн.

Тийм учраас энэ агуулга дээр бид цаашдаа зүгээр 100 хувь цахимжих гээд байна гэхээсээ илүүтэйгээр цаасан, эсхүл цахим хэлбэрээр байж болно оо л гэдэг энэ агуулгуудыг хөндөж байгаа шүү гэдгийг хэлье.

Зүгээр зарим салбарын асуудлууд дээр илтэд ойлгомжтой асуудлуудыг цахимыг нь нээж өгөхгүй бол яг амьдрал дээр жишээ нь төрийн мэдээллийн үндсэн систем гэж нэрлээд байгаа системээр таниад, тэр e-mongolia дээр иргэний үнэмлэхийн ID орчихсон, жолооны үнэмлэхийн ID орчихсон, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ID орчихсон байхад чи заавал жолооны үнэмлэхээ бодит байдлаар гаргаж ир гээд. Гаргаж ирэхгүй бол торгоно гээд байгаа юм. Ер нь бол.

Тэгэхээр нөгөө хүмүүсийг бас ингээд шууд буруутгах гэхээр үгүй ээ наадах чинь хууль дээр заачихсан шүү дээ гээд байдаг ийм хэцүү асуудал байдаг.

Дээрээс нь Архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийг энэ дээр бид хөндөхгүй бол. Мэдээж заавал цаасаар архивлах шаардлагатай жагсаалт байдаг.

Тэгэхээр зарим нэг өдөр тутмын харилцаа энэ тэрийг цахимаар явуулахгүй бол одоо яаж байна вэ гэхээр бичиг цаасыг бид цахимаар солилцдог. Өдөр тутам яамд ч байна уу, төрийн байгууллагууд чинь хоорондоо.

Үүнийг давхар хэвлээд хадгалдаг. Цаасаар явчихсан юмнуудыг сканердаж хадгалаад компьютерт хийгээд байдаг. Хоёр, гурван ажил болоод. Цахим чинь бүр сүүлдээ бүр хүнд суртал үүсгэх тал руугаа яваад байгаа юм.

Тийм учраас яалт ч байхгүй энэ асуудлуудыг хөндөхөөс өөр гарц байхгүй байгаа.

Тэгэхээр зүгээр энэ дээр бас ажлын хэсэг гаргаад Хууль зүйн байнгын хороотой холбоотой 38 хууль байгаа юм байна. Тэгэхдээ хөндөөгүй хуулийг бол мэдээж хөндөхгүй учраас яг энэ хөндсөн хуулиуд дээр нь шаардлагагүй гэснийг нь татаж аваад.../минут дуусав/

Д.Цогтбаатар: Болсон уу?
Н.Учрал гишүүн ээ.

Ер нь Н.Учрал гишүүний ярьж байгаа маш зөв шүү. Амьдрал дээрээ, газар дээрээ аль хэдийн амьдрал урагшаа явчихсан. Энэ байгууллагууд чинь хоцорчихсон. Тэгээд авч болох материалуудыг авахгүй. Өөдөөс нь ийм юм яриад суугаад байгаа. Амьдрал дээр хүндрэл гарч байгаа учраас л ингэж байгаа юм.

Гишүүд маань нэг юмыг ойлгоорой.

Ер нь цахимжилт гэдэг бол энэ hard сору-ыг халж байгаа зүйл огтоос биш шүү. Заавал hard сору-той тэр дараа нь архивлагдах материалууд үлдэнэ. Үүнийг софтоор орлуулах. Ерөөсөө ертөнцийн хаана ч үүнийг орлуулаагүй байгаа.

Энэ чинь ажлыг хөнгөвчлөх л арга хэрэгслийн тухай яриад байгаа бөгөөд уг нь хууль нь байгаа. Үүнийг тус

байгууллагууд хүлээж авах ёстой юм билээ.

Хүлээж авахгүй газар дээрээ манай хуульд өөрчлөлт ороогүй байна гэдэг асуудал яриад хүндрэл гаргаад байгаа учраас энэ хуулийг нэмж оруулж ирье гэсэн энэ саналыг оруулж ирсэн байгаа юм билээ.

Би гишүүддээ нэг зүйлийг хэлмээр байгаа юм.

Энэ дээр яг эрх зүйн хувьд нэг асуудал байна. Одоо ингээд нэг хуулийг өөрчлөөд араас нь 122 хууль өөрчлөх тухай юмнууд орж ирдэг. Ингэж явах юм бол ерөөсөө тэр 123 дахь хууль зөрчигдөөгүй гэсэн баталгаа хаана байх вэ энэ чинь. Ийм маягаар явбал хэзээ ч орон зай, нөгөө нүх сүв үлдэх гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр угаасаа энэ салбарын хууль гарснаар бусад бүх байгууллагууд мөрдөх л ёс ёстой шүү дээ.

Төрийнхөн ийм хүнд суртал гаргаад байгаа байхгүй юу. Түүнээс бид хууль гаргачихсан байхад иргэн өөрөө сонгож энэ надад хамаарах хууль, энэ надад хамаарахгүй хууль гэж иргэн сонгодоггүй шүү дээ. Хууль үйлчлэх хүрээндээ бүх байгууллагад, бүх хүнд үйлчлээд л явна.

Уг нь тэр үүднээсээ энэ хууль шууд үйлчлээд явах ёстой л юм билээ. Гэхдээ нэгэнт ийм асуудал гараад байгаа болохоор би зүгээр ийм горимын санал гаргамаар байна.

Ерөөсөө ажлын хэсэг тэгвэл энэ дээр байгуулаад маш богинохон хугацаанд.

Тэгээд энэ ажлын хэсэг яг энэ дээр нэг суугаад ажиллаадах хэрэгтэй байна. Тэгээд үүнийгээ эргээд хэлэлцээд явъя гэсэн ийм саналтай байна.

Н.Учрал гишүүн нэг тайлбар хэлээд өгчих.

Н.Учрал: Яах вэ, би тэр Цахим хөгжлийг дэмжих хуулиудын ажлын хэсгийг ахалж батлуулсан.

Тэгэхэд би хэлж байсан. Та нар энэ бичгээр гэснийг цахим ба цаасан аль альныг нь ойлгоно гэдэг энэ ойлголтыг салбар болгоны органик хууль дээр биччихсэн үгийг энэ хуулиар өөрчилж чадахгүй шүү гэж байхад үгүй ээ болдог юм гэж хэлээд л энэ дагуулсан хуулийг хийгээгүй.

Тэгээд дараа нь би энэ сайдаар томилогдоод амьдрал дээр нөхцөл байдал шал өөр байгааг мэдээд энэ хуулийг өөрчлөх шаардлагатай юм байна.

Одоо жишээ нь би сая Б.Энхбаяр сайдад ажил авсных нь дараа хэлсэн. Шүүх хуралдааны товыг хойшлуулахад бичиг бариад төв рүүгээ очдог байдлыг больчхооч ээ л гэж хэлж байгаа шүү дээ. Энгийн л асуудал шүү дээ.

Онлайн аппликэйшн гарчхаад хууль зүйн туслалцааг онлайнаар үзүүлж болж байхад хуулиар хорьчихсон байна шүү дээ. Үүнийг больчхооч ээ л гээд байгаа шүү дээ.

Өдөр тутам. Одоо бараг ингэж байна шүү дээ. Сайд нар, энэ төрийн байгууллагынхан чинь зэрэгцэж суучхаад наад асуудлаа бичгээр шидчих гэж байна шүү дээ.

Үгүй ээ, энэ чинь хоорондоо яриад л үүнийгээ шийдчих юмыг заавал ингээд

л бичгээр шидээд л, хэдэн мянга дамжаад л, 2 сар болоод л. Тэгээд цахимаар ингээд өдөр тутмын харилцаа явна.

Бараг энэ зөв үү гэнгүүт наадах чинь зөв ч байж магадгүй, наадах чинь буруу юм гээд ингээд бичиг солилцоод байгаа байхгүй юу. Тэгээд бичиг хэрэгт өгчих гээд л.

Тэгээд бичиг хэрэг солилцоод явж байсан чинь Архив албан хэрэг хөтлөлтийнх нь хууль дээр одоо цахим цаасан баримт бичиг зөрөх юм бол цаасанг нь барина гээд заачихаар чинь нөгөө өдөр тутмын харилцааны бичгүүдээ давхар хэвлээд ингээд хадгалаад байдаг. Тэгээд цахимаа энд хадгалаад байдаг, цаасангаа хадгалаад байдаг. Тэгээд нэг ийм нэг тал бүрдээ хүндрэл үүсээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр Б.Энхбаяр сайд надад юу гэж тайлбарлаад байна гэхээр манай шүүх компьютер байхгүй гээд ийм юм яриад байгаа байхгүй юу.

Тэгээд энэ бол Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлсэн хуулийн төсөл шүү.

Тэгэхээр үүнийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжлийн яамтай хамтарч үзэл баримтлалыг нь баталсан шүү. Танай яам. Төрийн ажил залгамж чанартай байх ёстой юм бол би Хууль зүйн яамны баталсан үзэл баримтлал дээр баталсан төсөл гэж үзэж байгаа.

Тийм учраас энэ асуудлаа Б.Энхбаяр сайд өөрөө нэг анхаарна биз.

Яах вэ, би бол энэ төрийн ажлын хүнд суртлыг багасгая л гэдэг зорилгоор явж байгаа болохоос биш ямар нэгэн байдлаар салбаруудын эрх ашиг хөндөх

гээд байгаа юм ер байхгүй. Зүгээр иргэдэд энэ чинь аягүй хүнд сурталтай байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ иргэдэд учраад байгаа хүнд суртлыг багасгая гэхээр хэдүүлээ компьютер байхгүй, сүлжээ нь болоогүй гээд. Дэлхий дахин явчихсан. Тэгээд бид эндээ үлдье ээ л гэж байгаа даа ялгаагүй л нэг ийм.

Харин тэгээд тэрийгээ зас л даа. Танай яам л оруулж ирсэн шүү дээ.

Д.Цогтбаатар: Н.Учрал гишүүн ээ, одоо болсон.

Ингэе. Б.Энхбаяр гишүүн ээ, одоо ойлгосон. Би нэг зүйлийг хэлье.

Нээрээ засгийн гишүүд ээ, энд орж ирж та нар маань хоорондоо ингэж болохгүй шүү. Засгийн бодлого нэг л байх ёстой.

Би Байнгын хороон дээрээ гишүүдээ өөр өөрсдийнхөө үгийг чөлөөтэй хэлж байх. Энэ бол тэр орон зай чинь мөн. Засаг бол нэг байр суурьтай байх ёстой.

Б.Энхбаяр гишүүнд би хандаад хэлэхэд энэ дэвшилтэт технологи бол салбарт нэвтрэх ёстой. Та тэр дээр нь дэмжиж ойлгож ажиллах нь зөв зөв.

Тэгэхээр хоёр талаасаа энэ юмаа засаг дээрээ та нар ярьцгаа.

Одоо би бол ийм санал шууд гаргамаар байна.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах

тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулъя.

Ингээд Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулъя.

Би гишүүдийг шууд өөрөө санал болгоод явчихъя.

Б.Энх-Амгалан гишүүн, Ц.Мөнх-Оргил гишүүн, Б.Пүрэвдорж гишүүн, Ц.Мөнхцэцэг гишүүн гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр.

Тав дахь нь тэгвэл хэн байх вэ? Тэгье. Ц.Сандаг-Очир гишүүнийг оруулчихъя. Тийм. Ингээд 5 гишүүн.

Тэгээд ажлын хэсгийн ахлагчаар Б.Энх-Амгалан гишүүнийг би тавьчихъя.

Тэгээд үүнийг гэхдээ маш богино хугацаанд. Бид яагаад гэвэл энэ хууль нь

үнэхээр удаан хүлээгдчихсэн байгаа юм билээ.

Тэгэхээр үүнийг нь аль болох шуурхай явуулж өгмөөр байна.

Харин Н.Учрал гишүүн ээ, хугацаа ер нь хэд байвал. Би долоо хоногийн хугацаа л өгье.

Тийм. Дараагийн долоо хоногт. Долоо хоногийн хугацаа л өгье.

Тэгвэл саяын ажлын хэсгийг байгуулъя гэсэн томъёоллоор. Энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд ажлын хэсэг байгуулаад долоо хоногийн дотор энэ саналуудыг нэгтгээд орж ирэхээр боллоо.

Дараагийн асуудалдаа орё.

**Дөрөв. “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлт
боловсруулах үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай”
Байнгын хорооны тогтоолын төсөл**

Дараагийн асуудал. Ажлын хэсэг байгуулах тухай байгаа. Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ. Тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү? Танд санал байгаа юм уу? Н.Алтанхуяг гишүүн ээ, таныг нэмчихсэн байна шүү дээ.

Асуух асуулттай гишүүд байхгүй байна. Тогтоолын төслийг би уншиж танилцуулъя.

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Мөнхбаатар -Улсын Их Хурлын гишүүн,

Гишүүд:

Э.Бат-Амгалан -Улсын Их Хурлын гишүүн,
Д.Ганбат -Улсын Их Хурлын гишүүн,
Б.Энх-Амгалан -Улсын Их Хурлын гишүүн,
Г.Амартүвшин -Улсын Их Хурлын гишүүн.

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Г.Золжаргал -Хууль эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх.

Ийм бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг байгуулья гэсэн саналыг дэмжье гэсэн томьёолоор санал хураалт явуулья. /алх цохив/

61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тав.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл

Дараагийн ажлын хэсэг байгуулах асуудал. Байнгын хорооны төсөл танилцуулья.

Тогтоолын төслийг гишүүдэд тараасан байгаа.

Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү?
Байхгүй байна.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Хууль зүйн байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Мөнх-Оргил

-Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

Ц.Мөнхцэцэг

-Улсын Их Хурлын гишүүн

Б.Пүрэвдорж

-Улсын Их Хурлын гишүүн

Ш.Раднаасэд

-Улсын Их Хурлын гишүүн

Ц.Сандаг-Очир

-Улсын Их Хурлын гишүүн

Ц.Сэргэлэн

-Улсын Их Хурлын гишүүн

Б.Энх-Амгалан

-Улсын Их Хурлын гишүүн

Н.Алтанхуяг

-Улсын Их Хурлын гишүүн

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Г.Золжаргал

-Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх.

Тэгвэл ингэе. Саяын нэрсийн жагсаалтаас Б.Энх-Амгалан гишүүнийг хасья. Тэгээд энэ хассан байдлаар.

Тэгэхээр Ц.Мөнх-Оргил гишүүн, Ц.Мөнхцэцэг гишүүн, Б.Пүрэвдорж гишүүн, Ш.Раднаасэд гишүүн, Ц.Сандаг-Очир гишүүн, Ц.Сэргэлэн гишүүн, Н.Алтанхуяг гишүүн гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсгийг байгуулъя гэсэн томьёоллоор.

Тэгэхдээ энэ чинь байна шүү дээ бас том хууль шүү. Тийм.

Ц.Мөнх-Оргил гишүүн ээ, энэ чинь иргэн, эрүү хоёрыг чинь нэгтгэчихсэн, процессыг чинь нэгтгэчихсэн байж байгаа шүү дээ. Тийм.

Тэгвэл ингэе. Ц.Сандаг-Очир гишүүн, Ц.Сэргэлэн гишүүн хоёрыг хасаад 5 гишүүнтэйгээр тэгвэл ажлын хэсгийг байгуулъя.

Дэмжье гэсэн томьёоллоор саналыг хураая. /алх цохив/

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдаан дууслаа.

Хуралдаан 3 цаг 32 минут үргэлжилж, 12 цаг 58 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД